



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР
ПАРЛАМЕНТЫН СУДАЛГАА,
ХӨГЖЛИЙН ХҮРЭЭЛЭН

Улсын Их Хурлын тамгын газрын 1 дүгээр байр,
Жанжин Д.Сүхбаатарын талбай 7, 4 дүгээр хороо,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас/факс: (976-51) 26 45 36,
Цахим шуудан: prd.institute@parliament.mn,
Цахим хуудас: www.research.parliament.mn

2025. 09. 11 № 110-01/0371

танай 2025. 04. 17 -ны № 400-03/4734-Т

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Д.БАТЛУТ ТАНАА

Тус хүрээлэнгээс “Жижиг, дунд үйлдвэр,
үйлчилгээг дэмжих тухай хуулийн зарим зүйл, заалтын
хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээний тайлан”-г
гүйцэтгэн хүргүүлж байна.

Хүлээн авч танилцана уу.

ЗАХИРАЛ  Д.БУМДАРЬ



1525000831



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗАР
ПАРЛАМЕНТЫН СУДАЛГАА,
ХӨГЖЛИЙН ХҮРЭЭЛЭН

**ЖИЖИГ, ДУНД ҮЙЛДВЭР, ҮЙЛЧИЛГЭЭГ ДЭМЖИХ ТУХАЙ ХУУЛИЙН
ЗАРИМ, ЗҮЙЛ ЗААЛТЫН ХЭРЭГЖИЛТИЙН ҮР ДАГАВАРТ ХИЙСЭН
ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

Судалгааны төрөл: **Хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ**
Судалгааны код: **ХҮДҮ-25/02**
Огноо:

ЗАХИАЛАГЧ: УИХ-ын гишүүн Д.Батлут

Хянасан: ПСХХ-ийн Эрдэмтэн нарийн бичгийн дарга Д.Онолт
ПСХХ-ийн Судалгааны хэлтсийн дарга Г.Гэсэр

Судалгаа удирдсан: Судалгааны хэлтсийн зөвлөх Б.Оюун-Эрдэнэ
Судлаач: Б.Оюун-Эрдэнэ, Р.Нургүл, Б.Оюунчимэг

Улаанбаатар хот
2025

АГУУЛГЫН ТОВЬЁГ

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ	iii
ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ	iii
ЗУРГИЙН ЖАГСААЛТ	iii
НЭГ. ҮНЭЛГЭЭНИЙ АРГА ЗҮЙ	1
1.1. Үнэлгээ хийх үндэслэл	1
1.2. Үнэлгээ хийх хүрээ	1
1.3. Үнэлгээний шалгуур үзүүлэлт	4
1.4. Үнэлгээний харьцуулах хэлбэр	4
1.5. Үнэлгээний шалгуур үзүүлэлтийг томьёолох	5
1.6. Үнэлгээний мэдээлэл цуглуулах арга	6
1.6.1. Тоон судалгааны арга	6
1.6.2. Чанарын судалгааны арга	7
ХОЁР. жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуулийн зарим зүйл заалтын хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ	8
2.1. Төрөөс жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих талаар баримтлах бодлогын чиглэлийн хэрэгжилт (§8 дугаар зүйл)	8
2.1.1. Хүний нөөцийн чадавхыг нэмэгдүүлэх, сургах, давтан сургах тогтолцоог хөгжүүлэх (§8.1.1)	8
2.1.2. Санхүүгийн дэмжлэг (§8.1.2)	11
2.1.3. Татварын хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлэх (§8.1.3)	18
2.1.4. Экспортыг нэмэгдүүлэх, импортыг орлох өрсөлдөх чадвартай бүтээгдэхүүний үйлдэрлэл, үйлчилгээг дэмжих (§8.1.4)	19
2.1.5. Бүтээгдэхүүн ажил үйлчилгээний борлуулалтад төрийн худалдан авалтаар дэмжих (§8.1.5)	20
2.1.6. Бизнесийн зөвлөх үйлчилгээ үзүүлэх (§8.1.6)	21
2.1.7. Судалгаа, хөгжүүлэлтийг дэмжих (§8.1.7-§8.1.8)	22
2.1.9. Кластерын хэлбэрээр үйл ажиллагаа явуулдаг ЖДҮҮЭ-ийг дэмжих (§8.1.9)	23
2.1.10. Гадаад, дотоодын зах зээлд нэвтрэхэд дэмжих (§8.1.10)	24
2.2. Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээний кластерыг дэмжих (§ 9 дүгээр зүйл)	25
2.3. Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөр (§10 дугаар зүйл)	27
2.4. Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан	28
2.4.1. Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн тухай (§11.1-11.4)	28
2.4.2. Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, төсөл сонгон шалгаруулах журам (§11.5)	31
2.4.3. Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдэд нэг удаа олгох зээлийн хэмжээ (§11.6, §11.7)	31
2.4.4. Экспортод бүтээгдэхүүнээ гаргасан дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчид зээлийн хүүгийн татаас олгох (§11.8-§11.10)	32
2.4.5. Хөнгөлөлттэй зээл олгохгүй нөхцөл (§11.11)	33

2.4.6. Төслийн сонгон шалгаруулалтад хөндлөнгөөс оролцох (§11.12-§11.13).....	33
2.4.7. Сангаас хөнгөлөлттэй зээл олгоход харгалзан үзэх шалгуур үзүүлэлт (§11.14).....	34
2.4.8. Төсөл сонгон шалгаруулсан шийдвэрийг нээлттэй мэдээлэх, зээлийн гэрээний биелэлтэд тавих хяналт (§11.15-§11.16)	35
ГУРАВ. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ	37
3.1. Дүгнэлт	37
3.2.Зөвлөмж	41
АШИГЛАСАН МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ	i
ДӨРӨВ.ХАВСРАЛТУУД	ii
Хавсралт 1.Санал асуулга	ii
Хавсралт 2. Санал асуулгын үр дүн.....	vii
Хавсралт 3. Ганцаарчилсан ярилцлага	xii

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

АТГ	Авлигатай тэмцэх газар
ЗГ	Засгийн газар
ЗГХЭГ	Засгийн газрын хэрэг эрхлэх газар
ЖДҮГ	Жижиг, дунд үйлдвэрийн газар
ЖДҮҮЭ	Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгч
УИХ	Улсын Их Хурал
ХХААХҮЯ	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
ТЕГ	Татварын Ерөнхий газар
ТХААГ	Төрийн худалдан авах ажиллагааны газар
ШУТС	Шинжлэх ухаан технологийн сан

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Үнэлгээний шалгуур үзүүлэлт	5
Хүснэгт 2. Хүний нөөцийн чадавхыг нэмэгдүүлэх чиглэлээр зохион байгуулсан сургалт	9
Хүснэгт 3. 2019-2024 онд олгосон зээлийн батлан даалтын мэдээлэл	15
Хүснэгт 4. Санхүүгийн түрээсээр олгосон тоног төхөөрөмжийн жагсаалт	17
Хүснэгт 5. Сангийн эх үүсвэрийн бүрдүүлэлт (тэрбум төгрөг)	29
Хүснэгт 6. Санд ирүүлсэн нийт зээлийн хүсэлт болон олгосон зээлийн харьцуулалт	29
Хүснэгт 7. Сангийн зарцуулалт (салбараар)	30
Хүснэгт 8. Сангаас зээл олгосноор гарсан үр дүн	30
Хүснэгт 9. Сангаас нэг удаа олгох хөнгөлөлттэй зээлийн хэмжээ.....	31
Хүснэгт 10. Зээлийн хүүгийн татаас олгох зохицуулалтууд	32
Хүснэгт 11. Хөдөлмөрийн тухай хуулийн зохицуулалт	35
Хүснэгт 12. Чанаргүй зээлийн ангилалд орсон ЖДҮҮЭ-ийн тоон мэдээлэл	36
Хүснэгт 13. Хуулийн зүйл, заалтын хэрэгжилтийн үнэлгээ	37

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Санал асуулгын дүн: Хүний нөөцийн ур чадварыг хөгжүүлэх сургалт, давтан сургалтын талаарх ЖДҮҮЭ-ийн мэдлэг, ойлголт	10
--	----

Зураг 2.....	10
Зураг 3. Санал асуулгын дүн: Төрөөс үзүүлж буй санхүүгийн дэмжлэгийн талаарх ЖДҮҮЭ-ийн мэдлэг, ойлголт	12
Зураг 4. 2019-2024 онд Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас олгосон хөнгөлөлттэй зээл, санхүүжилт олгосон төслийн тоо.....	14
Зураг 5. Аж, ахуйн нэгжийн орлогын албан татварын хөнгөлөлт, чөлөөлөлт	19
Зураг 6. Нэмэгдсэн өртгийн албан татварын чөлөөлөлт.....	19

НЭГ. ҮНЭЛГЭЭНИЙ АРГА ЗҮЙ

Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 6 дугаар хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”-ын дагуу энэхүү үнэлгээний ажлыг хийв.

1.1. Үнэлгээ хийх үндэслэл

Монгол Улсын Их Хурлын даргын 2024 оны 82 дугаар захирамжаар байгуулагдсан Жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжих тухай хуулийн хэрэгжилттэй танилцаж, бичил үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдийг дэмжих тогтолцоог оновчтой болгох чиглэлээр санал, дүгнэлт гаргах, холбогдох хуулийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдсан. Энэ хүрээнд УИХ-ын нэр бүхий гишүүн Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуулийн зарим зүйл заалтын хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийлгэхээр захиалга өгсөн.

Жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжих тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсэгт зааснаар хуулийн зорилго нь жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг төрөлжүүлэн хөгжүүлж, өрсөлдөх чадварыг сайжруулах, ажлын байрыг нэмэгдүүлэх, тэдгээрийн эдийн засагт эзлэх хувь оролцоог дээшлүүлэхэд чиглэнэ, 1.2 дахь хэсэгт зааснаар хуулийн зорилт нь жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээнд үзүүлэх төрийн дэмжлэгийн хамрах хүрээ, хэлбэр, удирдлага, зохицуулалтын эрх зүйн үндсийг тогтоохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

Тус хуулийн шинэчилсэн найруулга 2019 онд батлагдаж, түүнээс хойш 5 удаа нэмэлт, өөрчлөлт орсон байна.¹ Хууль тогтоомжийн тухай хуулийн 51 дүгээр зүйлд 51.3 дахь хэсэгт заасан хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийх үнэлгээг тухайн хуулийг дагаж мөрдсөнөөс хойш 5 жил тутамд хийх гэж заасны дагуу тус судалгааг хийх нөхцөл бүрдсэн.

1.2. Үнэлгээ хийх хүрээ

Захиалагчаас ирүүлсэн хүсэлтийн дагуу Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуулийн 3 дугаар бүлгийг сонгож үнэлгээний хүрээг тогтоосон болно.

ЖИЖИГ, ДУНД ҮЙЛДВЭР, ҮЙЛЧИЛГЭЭГ ДЭМЖИХ ТУХАЙ ХУУЛЬ² (2019.06.06) ГУРАВДУГААР БҮЛЭГ ЖИЖИГ, ДУНД ҮЙЛДВЭР, ҮЙЛЧИЛГЭЭГ ДЭМЖИХ ТӨРИЙН БОДЛОГО	
8 дугаар зүйл. Төрөөс жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих талаар баримтлах бодлогын чиглэл	
<i>8.1. Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээний цар хүрээ, хөгжлийн үе шат, бүс нутгийн хөгжилд үзүүлэх нөлөө, гадаад зах зээлд нэвтрэх чадамж, техник, технологийн байдлыг нь харгалзан төрөөс дараах чиглэлийн дэмжлэгийг үзүүлнэ:</i>	

¹ Тус хуульд 2019, 2021, 2022 (2 удаа), 2024 онд нэмэлт, өөрчлөлт орсон байна.

² Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хууль (2019). Хандах: <https://legalinfo.mn/mn/detail/14525>

8.1.1.жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээний зах зээлийн эрэлт, хэрэгцээ шаардлагыг үндэслэн жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээний салбарын хүний нөөцийн чадавхыг нэмэгдүүлэх, сургах, давтан сургах тогтолцоог хөгжүүлэх;

8.1.2.санхүүгийн дараах дэмжлэгийг үзүүлэх:

8.1.2.а.хөнгөлөлттэй зээл олгох;

8.1.2.б.шинээр бий болгосон ажлын байрны тоо, борлуулалтын орлогын хэмжээг харгалзан зээлийн хүүгийн хэмжээг бууруулах;

8.1.2.в.зээлийн давхар батлан даалт гаргах;

8.1.2.г.зээлийн хүүгийн татаас олгох;

8.1.2.д.тоног төхөөрөмжийн санхүүгийн түрээсийн үйлчилгээ, түрээсийн хүүгийн дэмжлэг үзүүлэх.

8.1.3.татварын хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлэх;

8.1.4.экспортыг нэмэгдүүлэх, импортыг орлох өрсөлдөх чадвартай бүтээгдэхүүний үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжих;

8.1.5.бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний борлуулалтад төрийн худалдан авалтаар дэмжлэг үзүүлэх;

8.1.6.бизнесийн зөвлөх үйлчилгээ үзүүлэх;

8.1.7.шинэ бүтээгдэхүүн хөгжүүлэх, бүтээмжийг нэмэгдүүлэх судалгааг дэмжих;

8.1.8.техник, технологийн дэвшлийг дамжуулах, нутагшуулах, шинжлэх ухаан, технологийн судалгааны үр дүнг үйлдвэрлэлд нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэх;

8.1.9.кластерын хэлбэрээр үйл ажиллагаа явуулдаг жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчийг тухайн орон нутаг дахь түүхий эдийн болон ажиллах хүчний нөөц, чадавх бусад онцлогоос хамааран дэмжих;

8.1.10.гадаад, дотоод зах зээлд нэвтрэхэд дэмжлэг үзүүлэх.

9 дүгээр зүйл.Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээний кластерыг дэмжих

9.1.Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг кластераар хөгжүүлэхэд төрөөс дараах дэмжлэгийг үзүүлнэ:

9.1.1.түүхий эдийн бэлтгэл, нийлүүлэлт, үйлдвэрлэл, тээвэрлэлт, борлуулалтын харилцан уялдаа бүхий үйл ажиллагаа эрхлэх аж ахуйн нэгжид татвар, санхүүгийн цогц дэмжлэг үзүүлэх;

9.1.2.дэд бүтцийн хангамжийг сайжруулах;

9.1.3.үйл ажиллагаагаараа хорших, төрөлжих, хамтран ажиллах нөхцөлийг бүрдүүлэх.

9.2.Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгч нь кластерын хэлбэрээр үйл ажиллагаа явуулах тохиолдолд тэдгээрийн ажилтны тоо, борлуулалтын орлогын хэмжээг нэгтгэн тооцож, зохих ангилалд хамааруулж болно.

9.3.Энэ хуулийн 9.2-т заасан ажилтны тоо, борлуулалтын орлогын хэмжээг нэгтгэн тооцох үндэслэлийг хянаж, зохих ангилалд хамааруулахтай холбогдсон журмыг жижиг, дунд үйлдвэрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

9.4.Орон нутагт кластерын хэлбэрээр үйл ажиллагаа явуулах аж ахуйн нэгжийн төсөл нь энэ хуулийн 15.1.2-т заасан чиглэлд хамаарч байвал төрөөс тэргүүн ээлжинд дэмжинэ.

9.5.Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 39.1-д заасан чиглэлээр нийслэл хотын тусгай бүсэд үйл ажиллагаа эрхлэх бол тухайн аж ахуйн нэгжийг төрөөс тэргүүн ээлжид дэмжинэ.

/Энэ хэсгийг 2021 оны 7 дугаар сарын 7-ны өдрийн хуулиар нэмсэн./

10 дугаар зүйл. Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөр

10.1. Жижиг, дунд үйлдвэрийн тэргүүлэх чиглэлийг тодорхойлох, өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, ажлын байр, санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх, кластераар төрөлжүүлэн хөгжүүлэхэд чиглэсэн дунд хугацааны хөтөлбөртэй байна.

10.2. Ахуйн үйлчилгээний салбарт дэвшилтэт технологийг нэвтрүүлэх, стандартад нийцсэн үйлчилгээг иргэдэд хүргэх, албан бус хөдөлмөр эрхлэлтийг багасгаж ажлын байрыг нэмэгдүүлэхэд чиглэсэн дунд хугацааны хөтөлбөртэй байна.

10.3. Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөрийг боловсруулах, хэрэгжүүлэх, дүгнэхэд эрдэм шинжилгээний болон төрийн бус байгууллага, олон нийтийн оролцоог хангана.

11 дүгээр зүйл. Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан

11.1. Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих үйл ажиллагаанд шаардагдах хөрөнгийг санхүүжүүлэх зорилго бүхий Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан /цаашид "Сан" гэх/ байна.

11.2. Сангийн хуульд заасан чиг үүргийг жижиг, дунд үйлдвэрийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага хэрэгжүүлнэ.

11.3. Сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах, хянахтай холбогдсон харилцааг Засгийн газрын тусгай сангийн тухай хуулиар зохицуулна.

11.4. Санд Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 16.3-т заасны дагуу улсын төсвөөс жил бүр хөрөнгө хуваарилна.

/Энэ хэсэгт 2019 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./

11.5. Сангаас хөнгөлөлттэй зээл олгох, төсөл сонгон шалгаруулах журмыг Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 16.7-д заасны дагуу Засгийн газар батална.

/Энэ хэсэгт 2019 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./

11.6. Сангаас жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчид нэг удаа олгох зээлийн хэмжээг доор дурдсанаар тодорхойлно:

11.6.1. бичил үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчид жилийн борлуулалтын орлогоос хамааруулан 300.0 сая төгрөг хүртэл;

11.6.2. жижиг үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчид жилийн борлуулалтын орлогоос хамааруулан 1.0 тэрбум төгрөг хүртэл;

11.6.3. дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчид жилийн борлуулалтын орлогоос хамааруулан 2.5 тэрбум төгрөг хүртэл.

11.7. Бичил үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчид зээлийг Сангаас шууд, жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчид банкаар дамжуулж олгоно. Банкныг сонгон шалгаруулалтаар сонгоно. Банканд Сангийн эх үүсвэрийг байршуулах, зээл олгох журмыг Засгийн газар батална.

11.8. Дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгч бүтээгдэхүүнээ экспортод гаргасан тохиолдолд банкнаас авсан зээлийн жилийн хүүгийнх нь 5.0 хүртэл хувийг Сангаас олгож болно.

11.9. Сангаас зээл, зээлийн хүүгийн татаас олгоход доор дурдсан хязгаарлалтыг баримтална:

11.9.1. Сангийн тухайн жилийн улсын төсвийн санхүүжилтийн 80-аас доошгүй хувийг үйлдвэрлэлийг дэмжих зориулалтаар олгох;

11.9.2. зээлийн хүүгийн татаасын зориулалтаар олгох хөрөнгийн нийт хэмжээ нь Сангийн тухайн жилийн улсын төсвийн санхүүжилтийн 20 хувиас хэтрэхгүй байх.

11.10. Энэ хуулийн 11.8-д заасны дагуу Сангаас зээлийн хүүгийн татаас олгох журмыг жижиг, дунд үйлдвэрийн болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.

11.11. Дараах жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчид хөнгөлөлттэй зээл олгохгүй:

11.11.1. Сангаас авсан зээлийн үлдэгдэлтэй;

11.11.2. зээлийн мэдээллийн санд муу зээлийн түүхтэй;

11.11.3. Сангаас авсан зээлийг зориулалтын бусаар ашигласан нь тогтоогдсон;

11.11.4. шүүхийн шийдвэрээр бусдад төлөх өртэй;

11.11.5. төсөл хүлээн авах сүүлийн өдрийн байдлаар нийгмийн даатгал, татварын байгууллагад өртэй.

11.12. Зээлийн эх үүсвэрээр хэрэгжүүлэх төслийн талаар санал, дүгнэлт гаргах, сонгон шалгаруулалт явуулах, шийдвэр гаргахад аливаа этгээд хөндлөнгөөс нөлөөлөхийг хориглоно.

11.13. Албан үүргээ гүйцэтгэхэд нь хөндлөнгөөс нөлөөлсөн гэж үзвэл тухайн албан тушаалтан Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасны дагуу эрх бүхий байгууллага, албан тушаалтанд мэдэгдэх үүрэгтэй.

11.14. Сангаас хөнгөлөлттэй зээл олгох, төсөл сонгон шалгаруулахад жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчийг Хөдөлмөрийн тухай хуулийн 111.1, 111.2-т заасныг хэрэгжүүлсэн эсэхийг харгалзан үзнэ.

11.15. Сан төсөл сонгон шалгаруулсан шийдвэрийг тухайн шийдвэр гарснаас хойш Сангийн албан ёсны цахим хуудас болон өдөр тутмын хэвлэлээр ажлын 5 өдрийн дотор нийтэд мэдээлнэ.

11.16. Сан нь зээлийн болон дамжуулан зээлдүүлэх гэрээний биелэлтэд хяналт тавина.

1.3. Үнэлгээний шалгуур үзүүлэлт

Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 6 дугаар хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”-ын 3.4-т заасан шалгуур үзүүлэлтээс Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуулийн холбогдох зүйл, хэсэг, заалтын хэрэгжилтийн бодит байдлыг тодорхойлоход чиглэгдсэн дараах шалгуур үзүүлэлтийг сонгосон болно.

- 1) **Зорилгод хүрсэн түвшин** - тухайн хууль тогтоомж хэрэгжиж эхэлснээс хойш хугацаанд хуулийн зорилго, зорилтдоо хүрсэн эсэхийг тогтооно.
- 2) **Практикт нийцэж байгаа байдал** – тухайн хуулийн зохицуулалт хэрхэн хэрэгжиж байгаа, түүний эерэг болон сөрөг үр дагавар, хэрэгжүүлэхэд хүндрэл гарч байгаа эсэхийг тодорхойлно.

1.4. Үнэлгээний харьцуулах хэлбэр

Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуулийн холбогдох зүйл, заалт нь хэрэгжсэнээр нийгмийн харилцаанд үзүүлсэн эерэг, сөрөг өөрчлөлтүүдийг олж тодорхойлоход “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”-ын 3.5-т заасан үнэлгээний харьцуулах хэлбэрээс **“хууль тогтоомж хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш”** харьцуулах хэлбэрийг сонгосон.

Энэ хэлбэрийг ашиглан хууль хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш нөхцөл байдал хэрхэн өөрчлөгдсөнийг он дарааллаар судалж тогтооход чиглэгдэнэ. Тодорхой цаг хугацааны дарааллаар нөхцөл байдлын өрнөлийг жагсааж гаргасан судалгааг үнэлгээнд хэрэглэнэ.

1.5. Үнэлгээний шалгуур үзүүлэлтийг томьёолох

Шалгуур үзүүлэлтийг томьёолох үе шатны хүрээнд Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуулиар зохицуулсан зарим зүйл, заалтыг шалгуур үзүүлэлт тус бүрээр тодорхой асуулт тавих замаар товч тодорхой томьёолохыг зорилоо.

Хүснэгт 1. Үнэлгээний шалгуур үзүүлэлт

Д/д	Үнэлгээний хүрээ	Шалгуур үзүүлэлт	Харьцуулах хэлбэр	Шалгуур үзүүлэлтийн томьёолол
1	8 дугаар зүйл. Төрөөс жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих талаар баримтлах бодлогын чиглэл	Зорилгод хүрсэн байдал ба хэрэгжсэн байдал Практикт нийцэж байгаа байдал	Хууль хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш	- Төрөөс жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих талаар баримтлах бодлого зорилгодоо хүрсэн эсэх? - Салбарын хүний нөөцийн чадавхыг нэмэгдүүлэх тогтолцоог хөгжүүлж чадсан эсэх? - Төрөөс үзүүлж буй санхүүгийн болон санхүүгийн бус дэмжлэг практикт нийцсэн эсэх? - Төрөөс үзүүлж буй дэмжлэгүүд жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдэд бодит дэмжлэг болж чаддаг эсэх? - Дэмжлэг авах болон үзүүлэхэд ямар нэгэн хүндрэл бэрхшээл тулгардаг эсэх?
2	9 дүгээр зүйл. Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээний кластерыг дэмжих	Зорилгод хүрсэн байдал ба хэрэгжсэн байдал		- Кластерын хэлбэрээр үйл ажиллагаа явуулж буй жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдийг дэмжих тогтолцоо бүрдсэн эсэх?
3	10 дугаар зүйл. Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөр	Зорилгод хүрсэн байдал ба хэрэгжсэн байдал		- Жижиг, дунд үйлдвэр үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөр батлагдсан эсэх?
4	11 дүгээр зүйл. Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан	Зорилгод хүрсэн байдал ба хэрэгжсэн байдал		- Сангийн үйл ажиллагаа зорилгодоо хүрсэн эсэх?

		Практикт нийцэж байгаа байдал		- Сангийн үйл ажиллагаатай холбоотой журмууд батлагдсан эсэх? - Сангаас нэг удаа олгох зээлийн хэмжээ практикт нийцэж байгаа эсэх? - Хөнгөлөлттэй зээл олгохгүй байх нөхцөлүүд практикт нийцсэн эсэх? - Сонгон шалгаруулалт нээлттэй, ил тод, шударга явагддаг эсэх?
--	--	-------------------------------	--	---

1.6. Үнэлгээний мэдээлэл цуглуулах арга

Үнэлгээний мэдээллийг тоон болон чанарын судалгааны аргаар цуглуулна.

1.6.1. Тоон судалгааны арга

Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуулийн зарим зүйл заалтад хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ хийх ажлын хүрээнд санал асуулга болон ганцаарчилсан ярилцлага зохион байгуулсан.

1) **Санал асуулга:** Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэгт заасны дагуу Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээний цар хүрээ, хөгжлийн үе шат, бүс нутгийн хөгжилд үзүүлэх нөлөө, гадаад зах зээлд нэвтрэх чадамж, техник, технологийн байдлыг харгалзан төрөөс санхүүгийн болон санхүүгийн бус дэмжлэгийг үзүүлнэ.

а. Үнэлгээний ажлын хүрээнд төрөөс жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдийг дэмжих тогтолцоо оновчтой байгаа эсэх санхүүгийн болон бусад дэмжлэгийг үзүүлэхэд тулгардаг хүндрэл бэрхшээл зэрэг асуудлыг тодорхойлох зорилгоор 21 аймаг, нийслэлийн 9 дүүргийн Засаг даргын Тамгын газарт асуумжийн судалгаа авахаар албан тоот хүргүүлсэн.

Санал асуулгад нийт 157 холбогдох албан хаагч оролцов. Үүнд:

- Аймгийн мэргэжилтэн – 8;
- Сумын мэргэжилтэн – 109;
- Нийслэлийн мэргэжилтэн – 2;
- Дүүргийн мэргэжилтэн – 36.

2) **Ганцаарчилсан ярилцлага:** Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээнд төрөөс үзүүлж буй дэмжлэгийн хүртээмж, дэмжлэг авахад тулгардаг хүндрэл бэрхшээл, төрөөс үзүүлж буй дэмжлэг бодит хэрэгцээг хангадаг эсэх зэрэг асуудлыг тодорхойлох зорилгоор 10 жижиг, дунд үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэгчдээс ганцаарчилсан ярилцлага авсан. Үүнд:

Хуулийн хэрэгжилтэд өртөж буй этгээд

- Хөнгөлөлттэй зээлд хамрагдсан ЖДҮҮ эрхлэгчид-3
- Хөнгөлөлттэй зээлд хамрагдах хүсэлт гаргасан боловч төслийн материал шаардлага хангаагүй ЖДҮҮ эрхлэгчид-3
- Санхүүгийн дэмжлэг авах хүсэлт огт гаргаагүй ЖДҮҮ эрхлэгчид - 4

1.6.2. Чанарын судалгааны арга

Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотой хууль тогтоомж, холбогдох тайлан, статистик мэдээлэл зэрэг эх сурвалжууд болон төрийн байгууллагаас цуглуулсан баримт бичгүүдэд контент анализ хийсэн болно.

Тус хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотой бусад хууль тогтоомж:

- Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 16 дугаар зүйл (2019 оны 11 дүгээр сарын 13-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсөн);
- Зээлийн батлан даалтын сангийн тухай хууль (2012 оны 02 дугаар сарын 10-ны өдрөөс дагаж мөрдсөн);
- Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн зургаадугаар бүлэг (2019 оны 03 дугаар сарын 19-ний өдрөөс дагаж мөрдсөн);
- Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль (2015 оны 07 дугаар сарын 09-ний өдрөөс дагаж мөрдсөн);
- Хөгжлийн бодлого төлөвлөлт түүний хэрэгжилтийн тухай хууль (2020 оны 05 дугаар сарын 07-ны өдрөөс дагаж мөрдсөн);
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн шинэчилсэн найруулга (2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрөөс дагаж мөрдсөн);
- Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулга (2021 оны 07 дугаар сарын 02-ны өдрөөс дагаж мөрдсөн);
- Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, дамжуулан зээлдүүлэх, эргэн төлүүлэх, хяналт тавих журам (Засгийн газрын 2020 оны 113 дугаар тогтоол).

Хуулийн хэрэгжилттэй холбоотой дараах байгууллагуудын тайлан, мэдээлэл. Үүнд:

- Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам (2025 оны 06 дугаар сарын 18-ны өдөр албаны цахим шуудангаар ирүүлсэн мэдээлэл).
- Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Жижиг, дунд үйлдвэрийн газар (2025 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн 01/665 тоот албан бичгээр ирүүлсэн тайлан);
- Авлигатай тэмцэх газар (2025 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн 03/10820 тоот албан бичгээр ирүүлсэн мэдээлэл);
- Төрийн худалдан авах ажиллагааны газар (2025 оны 06 дугаар сарын 03-ны өдөр албаны цахим шуудангаар ирүүлсэн мэдээлэл);
- Татварын ерөнхий газар (2025 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн 02/1706 тоот албан бичгээр ирүүлсэн тайлан);
- Шинжлэх ухаан технологийн сан (2025 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн 3/271 тоот албан бичгээр ирүүлсэн мэдээлэл);
- Зээлийн батлан даалтын сан (2025 оны 07 дугаар сарын 01-ний өдөр албаны цахим шуудангаар ирүүлсэн мэдээлэл).
- Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Жижиг, дунд үйлдвэрийн газар болон Монголын инновацын холбоо ТББ хамтран төрөөс хэрэгжүүлж буй бодлого хөтөлбөрүүдийн хэрэгжилт тэдгээрийн жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдэд үзүүлж буй нөлөөллийг тодорхойлох зорилгоор жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдээс санал асуулга авах ажлыг 2025.05.01-2025.07.01-ний өдрүүдэд зохион байгуулсан. Санал асуулгад нийт 880 ЖДҮҮ эрхлэгчид хамрагдсан бөгөөд 759 нь орон нутгаас, 121 нь нийслэлээс оролцсон байна.

ХОЁР.ЖИЖИГ, ДУНД ҮЙЛДВЭР, ҮЙЛЧИЛГЭЭГ ДЭМЖИХ ТУХАЙ ХУУЛИЙН ЗАРИМ ЗҮЙЛ ЗААЛТЫН ХЭРЭГЖИЛТИЙН ҮР ДАГАВРЫН ҮНЭЛГЭЭ

Судалгааны энэ хэсэгт Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуулиас сонгож авсан үнэлэх зүйл, хэсэг, заалт бүрийг цуглуулсан мэдээлэлд тулгуурлан үнэлнэ.

2.1. Төрөөс жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих талаар баримтлах бодлогын чиглэлийн хэрэгжилт (§8 дугаар зүйл)

Үнэлэх хэсэг	8 дугаар зүйл. Төрөөс жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих талаар баримтлах бодлогын чиглэл 8.1. Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээний цар хүрээ, хөгжлийн үе шат, бүс нутгийн хөгжилд үзүүлэх нөлөө, гадаад зах зээлд нэвтрэх чадамж, техник, технологийн байдлыг нь харгалзан төрөөс дараах чиглэлийн дэмжлэгийг үзүүлнэ
Томъёолсон шалгуур үзүүлэлт	- Төрөөс ЖДҮҮ-г дэмжих талаар баримтлах бодлого зорилгодоо хүрсэн эсэх? - Салбарын хүний нөөцийн чадавхыг нэмэгдүүлэх тогтолцоог хөгжүүлж чадсан эсэх? - Төрөөс үзүүлж буй санхүүгийн болон санхүүгийн бус дэмжлэг практикт нийцсэн эсэх? - Төрөөс үзүүлж буй дэмжлэгүүд ЖДҮҮ эрхлэгчдэд бодит дэмжлэг болж чаддаг эсэх? - Дэмжлэг авах болон үзүүлэхэд ямар нэгэн хүндрэл бэрхшээл тулгардаг эсэх?

Төрөөс үзүүлэх дэмжлэгийн тухайд: Тус хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэгт жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээний цар хүрээ, хөгжлийн үе шат, бүс нутгийн хөгжилд үзүүлэх нөлөө, гадаад зах зээлд нэвтрэх чадамж, техник, технологийн байдлыг нь харгалзан төрөөс дараах чиглэлийн дэмжлэгийг үзүүлнэ гэж хуульчилсан байдаг. Үүнд: зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцсэн хүний нөөцийг бэлдэх (§8.1.1), санхүүгийн дэмжлэг (§8.1.2), татварын хөнгөлөлт, чөлөөлөлт (§8.1.3), экспорт, импортыг орлох бүтээгдэхүүний өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх (§8.1.4), төрийн худалдан авалтаар борлуулалтыг дэмжих (§8.1.5) зэрэг бодлогын дэмжлэгүүд орно. Мөн бизнесийн зөвлөх үйлчилгээ, инновац ба судалгааг дэмжих, техник технологийг нутагшуулах, кластер хэлбэрээр үйл ажиллагаа явуулж буй ААН-үүдийг орон нутгийн онцлогоос шалтгаалан дэмжих, дотоод болон гадаад зах зээлд нэвтрэх боломжийг өргөжүүлэх зэрэг арга хэмжээнүүдийг хуульд тусгасан байна (§8.1.6-§8.1.10).

Хуулийн 8 дугаар зүйлийн 8.1. дэх хэсгийн зүйл заалт тус бүрээр хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээг хийв.

2.1.1. Хүний нөөцийн чадавхыг нэмэгдүүлэх, сургах, давтан сургах тогтолцоог хөгжүүлэх (§8.1.1)

Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1-т жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдийн хүний нөөцийн чадавхыг нэмэгдүүлэх, сургах, давтан сургах тогтолцоог хөгжүүлэхээр тусгагдсан байна.

Тус хууль хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлснээс хойш 2019-2024 оныг дуустал Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Жижиг, дунд үйлдвэрийн газар³ (цаашид ЖДҮГ)-аас нийт 404 сургалтыг танхим болон цахим хэлбэрээр зохион байгуулж, сургалтад давхардсан тоогоор 197,011 жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч, тэдгээрийн ажилчид хамрагдсан байна (ЖДҮГ, 2025). Мөн бичил, жижиг, дунд үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэгчдэд зориулсан 18 багц 245 дэд сэдэв бүхий цахим хичээлийг тус газрын цахим хуудсаар дамжуулан хүргэсэн байна (мөн тэнд).

Хүснэгт 2. Хүний нөөцийн чадавхыг нэмэгдүүлэх чиглэлээр зохион байгуулсан сургалт

Үзүүлэлт / он	2019	2020	2021	2022	2023	2024	Шинэ хоршоо хөдөлгөөн	Нийт
Сургалтын тоо	10	12	25	58	77	37	185	404
Хамрагдсан хүн, (давхардсан тоогоор)	9,527	15,180	23,453	25,340	79,312	17,672	26,527	197,011

Эх сурвалж: (ЖДҮГ, 2025)

Санал асуулгын дүн:

Төрийн албан хаагчдын асуулгын үр дүн

Санал асуулгад нийт жижиг, дунд үйлдвэр хариуцан ажилладаг 157 төрийн албан хаагчид оролцсон. Тэд төрөөс жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчид (цаашид ЖДҮҮЭ)-ийн ур чадварыг хөгжүүлэх сургалт, давтан сургалт зохион байгуулдаг талаар иргэд, ААН-үүд 23.6% (37) нь сайн, 49.7% (78) нь дунд зэрэг, 15.9% (25) нь муу ойлголт, мэдээлэлтэй байдаг гэж үзжээ.

Харин бүс нутгийн харьцуулалтаас үзэхэд нийслэлийн албан хаагчид 42.1% (16) нь сайн, 36.8% (14) нь дунд зэрэг, харин орон нутагт 17.6% (21) нь сайн, 53.8% (64) дунд зэрэг гэж хариулсан байна. Энэ нь орон нутгийн ЖДҮҮЭ-д төрөөс ур чадварыг хөгжүүлэх чиглэлээр сургалт, давтан сургалтыг зохион байгуулдаг талаар мэдээлэл, ойлголт сул байгааг харуулж байна.

³ Жижиг, дунд үйлдвэрийн газар

1993 он – Үйлвэр худалдааны яам, Жижиг, дунд үйлдвэрийн хэлтэс

2009 он – Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан


2012 он – Хөдөлмөрийн яам, Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан

2014 он – Аж, үйлдвэрийн яам, Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан

2016 он – Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан

2020 он – Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Жижиг, дунд үйлдвэрийн газар

Зураг 1. Санал асуулгын дүн: Хүний нөөцийн ур чадварыг хөгжүүлэх сургалт, давтан сургалтын талаарх ЖДҮҮЭ-ийн мэдлэг, ойлголт




Эх сурвалж: Судлаачийн боловсруулснаар.

Мөн хүний нөөцийн ур чадварыг хөгжүүлэх сургалтаас ЖДҮҮЭ-д өөрт хэрэгцээтэй чадварыг 49% (77) нь дунд зэрэг, 27.3% (43) нь ер нь чаддаг гэж төрийн албан хаагчид үзэж байна. Энэ нь сургалтын чанар, хэрэгцээ шаардлагад нийцсэн байдал хангалттай сайн биш байгааг илтгэж байна. Харин ЖДҮҮЭ-д өөрт хэрэгцээтэй чадварыг эзэмшиж чаддаггүй гэж хариулсан албан хаагчдаас шалтгааныг тодруулахад сургалтын санхүүжилт, дэмжлэгийн боломжоос шалтгаалан сургалтад хамрагдах сонирхолтой бүх хүнийг хамруулахад хүндрэлтэй байдаг, мөн сургалтын мэдээллийг хангалттай хүргэж чаддаггүй, сургалтад оролцогчдын хүлээлт, хэрэгцээ харилцан адилгүй байдаг талаар дурдсан байна.

Харин санал асуулгад оролцсон 880 ЖДҮҮЭ-ийн 73% (618) нь төрөөс зохион байгуулдаг сургалт семинар, үзэсгэлэн яармаг зэрэгт хамрагдсанаар шинэ санаа, туршлага, мэдлэг олж авах, мэдээлэл солилцох боломж олгодогтой санал нийлсэн байна (ЖДҮҮЭ, 2025). Харин 2019 оноос хойш хүний нөөцийн чадавхыг нэмэгдүүлэх сургалт, арга хэмжээнд нийт асуулгад оролцсон ЖДҮҮЭ-ийн 27.3% (241) нь хамрагдсан байна (мөн тэнд).

Зураг 2. Санал асуулгын дүн: "Төрөөс зохион байгуулдаг сургалт семинар, үзэсгэлэн яармаг зэрэгт хамрагдсанаар шинэ санаа, туршлага, мэдлэг олж авах, солилцох боломжтой байдаг".



Тайлбар: Санал асуулгад нийт 880 ЖДҮҮЭ оролцсон. Үүнээс орон нутгийн ЖДҮҮЭ – 759; Нийслэл – 121.Эх сурвалж: Судлаачийн боловсруулснаар.

Ярилцлагын үр дүн:

Ярилцлагад оролцсон арван ЖДҮҮЭ-ийн тав нь сургалтад хамрагдаж байсан бол үлдсэн тав нь огт хамрагдаж байгаагүй гэж хариулжээ. Тэдний үзэж буйгаар зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцсэн мэдлэг, чадварыг эзэмших, үйл ажиллагаагаа үр дүнтэй явуулахын тулд төрөөс үзүүлж буй сургалт, хөгжлийн дэмжлэг нэн шаардлагатай байдаг. Гэвч сургалт, хөтөлбөрүүдийн талаарх мэдээлэл дутмаг, түүнчлэн мэдээллийг цаг тухайд нь авч чаддаггүй нь оролцоонд сөргөөр нөлөөлж байгааг онцолжээ.

Шигтгээ.

- “2014 онд Нийслэлийн ЖДҮДТ-д сургалтад хамрагдаж байсан, түүнээс хойш хамрагдаагүй. Сүүлийн жилүүдэд АНУ-ын BEST (Олон Улсын хөгжлийн агентлаг (USAID)-ын санхүүжилттэй, “Хөгжлийн Шийдэл” төрийн бус байгууллагын хэрэгжүүлсэн “Бизнесийн тогтвортой хөгжлийг сайжруулах, ил тод байдлыг нэмэгдүүлэх” хөтөлбөр), Европын холбооны “Эмэгтэй бизнес эрхлэгчдийг дэмжих” хөтөлбөрийн үнзгүй сургалтуудад их хамрагдсан.” (ЖДҮҮЭ-1)
- “Баянгол, Сүхбаатар дүүргийн ЖДҮ дэмжих хэлтсээс зохион байгуулсан сургалтуудад хамрагдаж байсан. Гэвч сургалтын талаарх мэдээлэл хоцорч ирдэг, сургалт дууссаны дараа л мэддэг. Судалгаанд хамрагдаж буй шигээ сургалт болохоос өмнө мэдээллээ өгч, бүртгэлд хамруулдаг бол сургалтад оролцож, бизнесээ дэмжүүлэх, гадаад, дотоодын хөрөнгө оруулагчидтай B2B уулзалтад оролцох боломж бүрдэх тул хэрэгтэй гэж үздэг. Манайх Баянгол дүүргийн ЖДҮ эрхлэгчдийн холбоонд гишүүнээр элссэн. Холбооноос зохион байгуулсан сургалтуудад хамрагдаж мэдээлэл авдаг.” (ЖДҮҮЭ-3)

Хүний нөөцийн чадавхыг нэмэгдүүлэх, сургалт, давтан сургалтад хамрагдсан ЖДҮҮЭ-ээс сургалтын эрэлт хэрэгцээтэй нийцсэн байдал, хүссэн мэдээллээ авч чаддаг эсэх талаар тодруулж асуухад төрийн байгууллагаас зохион байгуулсан сургалтын багш нар учир дутагдалтай байдаг гэж дүгнэсэн. Харин олон улсын хөгжлийн агентлагийн санхүүжилтээр төрийн бус байгууллагын зохион байгуулсан сургалтад хамрагдсан бөгөөд энэ нь илүү үр дүнтэй байсан талаар онцолсон байна.

Судалгааны үр дүн жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээний салбарын хүний нөөцийн чадавхыг нэмэгдүүлэх эрх зүйн орчин бүрдсэн боловч бодит хэрэгжилт нь хангалтгүй байгааг илтгэж байна. Хэдийгээр сургалтын тоо, хамрагдалт өссөн ч үр дүнгийн талаарх үнэлгээ дунд түвшинд байна. Мэдээллийн хүртээмж, сургалтын чанар, хэрэгцээнд нийцэх байдал, бүсчилсэн ялгаатай байдал зэрэг хүчин зүйлс нь сургалт хөгжлийн бодлогыг илүү үр дүнтэй, зорилтот бүлэгт чиглэсэн байдлаар шинэчилж, сайжруулах шаардлагатайг харуулж байна.

2.1.2. Санхүүгийн дэмжлэг (§8.1.2)

Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2 дахь хэсэгт төрөөс үзүүлэх санхүүгийн дэмжлэгүүдийг тодорхойлсон байдаг. Үүнд:

- хөнгөлөлттэй зээл олгох (960 төсөлд 116.5 тэрбум төгрөгийн зээл олгосон);
- шинээр бий болгосон ажлын байрны тоо, борлуулалтын орлогын хэмжээг харгалзан зээлийн хүүгийн хэмжээг бууруулах;
- зээлийн давхар батлан даалт гаргах (749 ЖДҮҮЭ-д 184.3 тэрбум төгрөгийн баталгаа гаргасан);

- зээлийн хүүгийн татаас олгох;
- тоног төхөөрөмжийн санхүүгийн түрээсийн үйлчилгээ, түрээсийн хүүгийн дэмжлэг үзүүлэх (659.9 сая төгрөгийн үнэ бүхий 112 тоног төхөөрөмж).

Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдэд санхүүгийн дэмжлэгийг Засгийн газрын тусгай сангийн тухай хууль, Зээлийн батлан даалтын сангийн тухай хууль, Санхүүгийн түрээс (лизинг)-ийн тухай хуулийн хүрээнд үзүүлж байна.


Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд зааснаар Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэлтийг дэмжих зорилгоор “хөнгөлөлттэй зээл, зээлийн хүүгийн татаас олгох, шаардлагатай тохиолдолд улсын төсвийн хөрөнгөөр худалдан авсан жижиг, дунд үйлдвэрийг дэмжихэд чиглэсэн тоног төхөөрөмжийн санхүүгийн түрээсийн үйлчилгээ үзүүлэхэд зарцуулна” гэж хуульчилсан байдаг.⁴ Харин Зээлийн батлан даалтын сангийн тухай хуульд “банк санхүүгийн байгууллагаас зээл авахыг хүссэн боловч зээлийн барьцаа хөрөнгө нь хүрэлцэхгүй байгаа жижиг, дунд үйлдвэр эрхлэгчид зээлийн 60 хүртэлх хувийг батлан даалт гаргах” зохицуулалт тусгагдсан байдаг.⁵

Санал асуулгын үр дүн

Төрөөс үзүүлж буй санхүүгийн дэмжлэгийн талаарх ЖДҮҮЭ-дийн мэдлэг ойлголтыг тодорхойлох судалгаанд хамрагдсан төрийн албан хаагчид дараах байдлаар үнэлсэн: 22.9% (36) нь сайн, 52.2% (82) нь дунд зэрэг, 15.3% (24) муу байдаг талаар хариулжээ.

Бүсчилсэн харьцуулалтаас харахад нийслэлээс хамрагдсан төрийн албан хаагчдын 5.3% (2) нь сайн, 47.4% (18) нь дунд зэрэг, 26.3% (10) нь муу гэж хариулсан бол орон нутагт 28.6% (34) нь сайн, 53.8% (64) нь дунд зэрэг, 11.8% (14) нь муу мэдлэг ойлголттой байдаг гэсэн байна. Үүнээс харахад орон нутагт санхүүгийн дэмжлэгийн талаарх мэдээллийн хүртээмж, ЖДҮҮЭ-ийн хэрэгцээ шаардлага илүү байгааг харуулж байна.

Зураг 3. Санал асуулгын дүн: Төрөөс үзүүлж буй санхүүгийн дэмжлэгийн талаарх ЖДҮҮЭ-ийн мэдлэг, ойлголт



Ярилцлагын үр дүн

Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдийн долоо нь төрөөс үзүүлж буй санхүүгийн дэмжлэгийн төрлүүдээс хөнгөлөлттэй зээлийн талаар сайн мэдээлэлтэй, гурав

⁴ Засгийн газрын тусгай сангийн тухай хууль, §16.6 (2019). Хандах: <https://legalinfo.mn/mn/detail?lawId=14848>

⁵ Зээлийн батлан даалтын сангийн тухай хууль, §9.1.1 (2012). Хандах: <https://legalinfo.mn/mn/detail/286>

нь зээлийн батлан даалтын сангийн талаар сонсож байсан, харин бусад дэмжлэгүүдийг найм нь огт мэдэхгүй байв.

Шигтгээ.


- ЖДҮ-ийн хөнгөлөлттэй зээлийн талаар бол мэднэ, бусад дэмжлэгийн талаар сайн мэдэхгүй, сонсож байгаагүй. Бид (ЖДҮ эрхлэгчид) хоорондоо мэдээлэл солилцдог ч эдгээр дэмжлэгт хамрагдсан талаар сонсоогүй. Уг нь ийм дэмжлэгүүд хэрэгтэй байдаг. Батлан даалтын сан байдаг гэж сонссон ч бидний хувьд хэрэгжээгүй. Би 300 сая төгрөгийн зээл авах боломжтой байсан ч барьцаа хөрөнгө байхгүйгээс 160 саяын зээл авч 50 м2 ажлын байр авсан. Гэвч одоо үйлдвэр маань энэ байрандаа багтахгүй, 2-3 газар салгаж ажиллаж байна. Хэрэв тухайн үед батлан даалтын сангаар дэмжлэг авсан бол арай том байр авах боломжтой, үйлдвэрээ нэг дор байрлуулах боломжтой байх байсан. Одоо байр багтахгүй, хэцүү байдаг. (ЖДҮҮЭ-1)
- Энэ дэмжлэгүүдийн талаар мэдээлэлтэй байдаг. Гэхдээ алийг нь ч авч чаддаггүй. Жишээ нь дэлгүүрүүд манайд зорсон мах нийлүүлээч гэсэн хүсэлт байнга тавьдаг. Гэтэл одоо зах зээл дээр ганц компани монополь. Энэ компани ганцаараа зах зээлээ хангаж чадахгүй, зэрэгцээд манайх бас зорсон мах, татсан мах, калбижан мах нийлүүлмээр байдаг. Тэгэхээр тоног төхөөрөмж бас ажлын байр их чухал. Манайх нэг хэсэг Гэгээ гээд захад ажлын байр түрээсэлдэг байсан чинь эзэн нь СУ-д өгнө гээд их олон компани ажлын байргүй болсон. Өөрийн гэсэн ажлын байргүй, түрээсэлдэг болохоор бас хэцүү. Одоо манайх Баянгол дүүрэгт түрээсийн байранд үйл ажиллагаа явуулдаг. Тэр нь хүнсний зориулалттай биш хувцасны чиглэлийнх. Ер нь бид нарт хүнсний зориулалттай шаардлага хангасан ажлын байраар хангах дэмжлэг маш их хэрэгтэй. Бас тоног төхөөрөмжтэй болоход дэмжлэг хэрэгтэй. Манай бизнест худалдан авах зах зээл нь байна. Зарим газарт мах зүсдэг тоног төхөөрөмж, хөлдөөгч гээд байх юм, тэрийгээ хэрэглэхгүй зарна гээд. Ямар хүмүүст дэмжлэг нь олдоод, тэр нь ашиглагдахгүй илүүдээд байдаг юм бол. Тэр илүүдээд байгаа хүмүүс ядаж тоног төхөөрөмжөө бидэнд түрээсэлдэг бол зүгээр юм. Би хамрагдъя гэж хүсээд ч авч чаддаггүй. Би Баянгол дүүрэгт ийм төсөл хэрэгжүүлмээр байгаа, тоног төхөөрөмж олгоод өгөөч гээд хүсэлтээ өгсөн. Сүхбаатар дүүрэгт хандахаар улс төрийн нөхцөл байдлаас болоод юмуу, шийдвэр гаргахдаа маш удаан. Хэрэв би тоног төхөөрөмжийн дэмжлэг авч чадвал Хэнтий, Дорнодоос мах авдаг хүнтэй учраас ажлын байр түрээслээд махан бүтээгдэхүүний бизнесээ өргөжүүлэх боломжтой. Манай бизнесийн хувьд нэгдүгээрт ажлын байр, хоёрдугаарт тоног төхөөрөмж, гуравдугаарт эргэлтийн хөрөнгө чухал хэрэгцээтэй байна. Дэмжээд өгвөл маш чухал байна. Түрээсийн байранд үйл ажиллагаа явуулахад хэцүү. Түрээсийн гэрээгээ нэг нэг жилээр сунгадаг, ядаж 5 жилээр байдаг бол. Тэгээд илүү өндөр түрээс төлөх хүн гараад ирвэл надтай байгуулсан гэрээгээ цуцална. ЖДҮҮ дэмжих төвүүд үйлдвэр эрхлэгчдэд байр түрээсэлдэг, гэхдээ ноос ноолуур, хувцас, эсгий шаахайн үйлдвэрүүдэд голдуу түрээсэлдэг. (ЖДҮҮЭ-3)

2.1.2.1. Хөнгөлөлтэй зээл олгох (§8.1.2.a)

Засгийн газрын тусгай сангийн тухай хууль (§16.1; 16.6)-д Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг- хөгжүүлэх сантай байх бөгөөд тус сангийн хөрөнгийг жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэлтийг дэмжих зориулалтаар хөнгөлөлттэй зээл олгоход зарцуулна гэж хуульчилсан байдаг.

Тус сангаас 2020-2024 онд хүнсний үйлдвэрлэл, хөнгөн үйлдвэр, газар тариалан, мал аж ахуй зэрэг 11 чиглэлийн нийт 960 төсөлд 116.5 тэрбум төгрөгийн санхүүжилт олгожээ. Байршлаар авч үзвэл нийт санхүүжилтийн 32.2%-ийг Улаанбаатар хотод, 67.8%-ийг орон нутгийн төслүүдэд, харин бизнес эрхлэгчдийн ангиллын хувьд нийт зээлийг зөвхөн бичил бизнес эрхлэгчдэд олгожээ (ЖДҮГ, 2025).

Зураг 4. 2019-2024 онд Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас олгосон хөнгөлөлттэй зээл, санхүүжилт олгосон төслийн тоо



Эх сурвалж: (ЖДҮГ, 2025)

Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуулийн шинэчилсэн найруулга хэрэгжиж эхэлснээс хойш хөнгөлөлттэй зээл олголт 2021 онд огцом буурч доод түвшинд хүрсэн байна. Тухайн онд ердөө 12 төсөлд санхүүжилт олгосон нь Ковид-19 цар тахлын оргил үед зээл олголт доод цэгтээ хүрснийг харуулж байна.

Харин 2022 оноос хойш зээл олголт аажмаар сэргэсэн бөгөөд төслийн тоо болон зээлийн хэмжээ жилээс жилд нэмэгдэж, 2024 онд цар тахлын өмнөх буюу 2020 оны түвшнээс давсан үзүүлэлттэй байна. Энэ нь зээлийн санхүүжилтийн бодлого аажмаар тогтворжиж, хэрэгжилт сайжирсныг харуулж байна. Нөгөө талаас, энэхүү өсөлт нь 2019 оны үзүүлэлттэй харьцуулахад хангалттай түвшинд хүрээгүй нь жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих сангийн эх үүсвэрийн бүрдүүлэлт хангалтгүй байгааг илтгэж байна.

Санал асуулгын үр дүн

Жижиг, дунд үйлдвэр хариуцсан нийт албан хаагчдын 80% (125) нь жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчид ихэвчлэн хөнгөлөлттэй зээлд хамрагдах хүсэлтэй байдаг боловч энэ дэмжлэгийг үзүүлэхэд барьцаа хөрөнгийн шаардлага өндөр, зээлийн санхүүжилтийн хүртээмж мүү зэрэг хүндрэл хамгийн их гардаг талаар онцолсон байна.

Харин санал асуулгад оролцсон нийт ЖДҮҮЭ-ийн 44.2% (389) нь хөнгөлөлттэй зээлд хамрагдсан, аливаа зээлд хамрагдахад 65.3% (575) нь барьцаа хөрөнгийн баталгаажуулалт, 46.8% (412) нь санхүүгийн тайлан, орлого баталгаажуулалтын шалгуурыг хангахад хүндрэлтэй байдаг гэж үзжээ (ЖДҮҮЭ, 2025).

Ярилцлагын үр дүн

Мөн ярилцлагад оролцсон ЖДҮҮЭ-д ч мөн барьцаа хөрөнгийн шаардлага өндөр байдаг нь хөнгөлөлттэй зээлд хамрагдахад хүндрэл үүсгэдэг гэж үзсэн байна.

Шигтгээ. - Би 300 сая төгрөгийн зээл авах боломжтой байсан ч барьцаа хөрөнгө байхгүйгээс 160 саяын зээл авч 50 м2 ажлын байр авсан. Гэвч одоо үйлдвэр маань энэ байрандаа багтахгүй, 2-3 газар салгаж ажиллаж байна. (ЖДҮҮЭ-1)	
---	--

Дээрх асуудлын мөрөөр барьцаа хөрөнгийн шаардлагыг судлан үзэхэд Засгийн газрын 2020 оны 113 дугаар тогтоолоор батлагдсан “Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, дамжуулан зээлдүүлэх, эргэн төлүүлэх, хяналт тавих журам”-ын зээлд хамрагдах төсөлд тавигдах шаардлагын 5.9.4-т барьцаалах үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөх эрхийн болон эзэмших эрхийн улсын бүртгэлийн гэрчилгээ, газрын гэрээ, кадастрын зургийн хуулбарыг төслийн материалд хавсарган ирүүлэх гэж тусгажээ. Харин ЖДҮГ даргын 2023 оны А/61 дүгээр тушаалаар батлагдсан “Зээлийн барьцаа хөрөнгийг судалж, үнэлэх журам”-ын дагуу барьцаа хөрөнгийн үнэлгээ хийх ажлын хэсэг барьцаа хөрөнгийн үнэлгээний жишиг хүснэгт эсвэл хөрөнгийн үнэлгээний тайланд үндэслэн үнэлж шийдвэр гаргадаг байна. Тус журмын 2.10-т Ажлын хэсэг барьцаа хөрөнгийг үнэлэхдээ Зээлдэгчийн зээлийн нийт дүн болон үлдэгдэл дүн нь барьцаанд авах болон барьцаанд үлдэх хөрөнгийн үнэлгээний **70 хувиас** хэтрүүлэхгүй байх гэж заасан байна. Энэ нь нэг талаас зээлийн эрсдэлийг бууруулж байгаа хэдий ч, нөгөө талаас ЖДҮҮЭ-дийн хувьд шаардлага хангасан барьцаа хөрөнгөтэй байх хүндрэлийг үүсгэдэг бөгөөд зээлийн шалгуурыг хангах боломжийг хязгаарлаж буйг судалгааны үр дүн харуулж байна.

2.1.2.3. Зээлийн давхар батлан даалт гаргах (§8.1.2.в)

Зээлийн батлан даалтын сангийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.1-т банк, санхүүгийн байгууллагаас зээл авахыг хүссэн боловч зээлийн барьцаа хөрөнгө нь хүрэлцэхгүй байгаа ЖДҮҮЭ-дэд зээлийн 60 хүртэл хувьд батлан даалт гаргана. 9.2 дахь хэсэгт энэхүү батлан даалтыг гаргахдаа тухайн зээл олгох банк, санхүүгийн байгууллагын дүгнэлтэд үндэслэнэ гэж заасан байдаг.

Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хууль хэрэгжиж эхэлснээс хойш буюу зээлийн батлан даалтын сангаас нийт 346.0 тэрбум төгрөгийн зээлд 184.3 тэрбум төгрөгийн батлан даалтыг 749 ЖДҮҮЭ-дэд гаргасан байна (ЗБДС, 2025).

Хүснэгт 3. 2019-2024 онд олгосон зээлийн батлан даалтын мэдээлэл

Огноо	ЖДҮҮЭ-ийн тоо	Олгосон зээлийн дүн (сая төгрөгөөр)	Олгосон батлан даалтын дүн (сая төгрөгөөр)
2019	111	37,763.81	20,539.75
2020	66	24,865.88	12,643.41
2021	242	68,317.30	33,757.67
2022	40	26,300.00	13,731.77
2023	124	82,415.45	46,499.30
2024	166	106,359.76	57,193.94
Нийт	749	346,022.20	184,365.84

Эх сурвалж: (ЗБДС, 2025)

Зээлийн батлан даалтын сангаас ЖДҮҮЭ-дэд зээлийн батлан даалт гаргахад үүсдэг хүндрэл бэрхшээлийн талаар тодруулав.

Шигтгээ. - Зээл хүсэгчдийн мэдээлэл дутмаг: Батлан даалтын шалгуур, шаардлага, нөхцөлийг ойлгодоггүй. - Жижиг аж ахуйн нэгж, хоршоод нягтлан бодох бүртгэл сул байснаас шаардлагатай санхүүгийн тайлан, төлөвлөгөөг гаргаж чаддаггүй. - Зах зээлийн тодорхойгүй байдал, цаг агаарын эрсдэл (хөдөө аж ахуйд) нь эргэн төлөлтөд сөргөөр нөлөөлдөг. - Батлан даалтын хэмжээ нийт зээлийн 60%-д хязгаарлагддаг нь зээлдэгчид нэмэлт барьцаа гаргах шаардлага үүсгэдэг. - ЖДҮ, хоршоодод барьцаа хөрөнгийн асуудал тулгардаг.

Санал асуулгын үр дүн

Өмнө дурдсанчлан ЖДҮҮЭ-д санхүүгийн асуудлаа шийдвэрлэхэд хамгийн их тулгамддаг асуудал бол барьцаа хөрөнгийн шаардлага байдаг талаар асуулгад хамрагдсан албан хаагчид үзсэн байна.

Харин асуулгад хамрагдсан нийт ЖДҮҮЭ-дийн 29% (258) нь зээлийн батлан даалтын дэмжлэгт хамрагдсан бөгөөд зээлийн шалгуур хангахад барьцаа хөрөнгийн баталгаажуулалт хамгийн их хүндрэлтэй байдаг талаар 64.7% (570) нь үзсэн байна (ЖДҮҮЭ, 2025).

Ярилцлагын үр дүн

ЖДҮҮЭ-ийн үзэж байгаагаар зээлийн батлан даалтын талаар мэдээлэл, ойлголт муу, зээлийн батлан даалтын талаар сонсож байсан ч, хамрагдаж байгаагүй талаар онцолжээ.

Шигтгээ.

- Батлан даалтын сан байдаг гэж сонссон ч бидний хувьд хэрэгжээгүй. Би 300 сая төгрөгийн зээл авах боломжтой байсан ч барьцаа хөрөнгө байхгүйгээс 160 саяын зээл авч 50 м2 ажлын байр авсан. Гэвч одоо үйлдвэр маань энэ байрандаа багтахгүй, 2-3 газар салгаж ажиллаж байна. Хэрэв тухайн үед батлан даалтын сангаар дэмжлэг авсан бол арай том байр авах боломжтой, үйлдвэрээ нэг дор байрлуулах боломжтой байх байсан. Одоо байр багтахгүй, хэцүү байдаг. (ЖДҮҮЭ-1)
- Яг дэлгэрэнгүй нарийн мэдэхгүй. Зээлийн батлан даалтын сан гэж сонсож байсан. Үүнийг өөрөө хөөцөлдөж үзээгүй, мэдэхгүй. Хүмүүсийн ярианаас сонсоход хэцүү гэдэг. (ЖДҮҮЭ-7)

Харин зээлийн батлан даалтын талаар судлах явцад Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуулийн 8.1.2.в-д зааснаар зээлийн давхар батлан даалт гаргах замаар дэмжлэг үзүүлнэ гэж заасан нь хууль хэрэгжүүлэгчдэд ойлгомжгүй нөхцөлийг үүсгэж байгааг илрүүлэв. Учир нь Зээлийн батлан даалтын сангийн тухай хуульд “зээлийн давхар батлан даалт” гэсэн томъёолол байхгүй байна. Харин Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас зээлийн батлан даалтын сангийн үйл ажиллагаанаас үүсэх эрсдэл болон сангийн гаргасан нийт батлан даалтын 60 хүртэл хувийг **давхар батлан даах** зохицуулалтуудыг Зээлийн батлан даалтын сангийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2 дахь, 13 дугаар зүйлийн 13.2, 13.4 дэх хэсгүүдэд тус тус хуульчилсан байсныг 2019 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон байна.

Иймд Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуулийн 8.1.2.в дэд заалтыг Зээлийн батлан даалтын сангийн тухай хуультай уялдуулан өөрчлөн найруулах хэрэгцээ шаардлага байна.

2.1.2.3. Бусад санхүүгийн дэмжлэг (§8.1.2.б, §8.1.2.г)

Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2.б, 8.1.2.г дэх дэд заалтуудад шинээр бий болгосон ажлын байрны тоо, борлуулалтын орлогын хэмжээг харгалзан зээлийн хүүгийн хэмжээг бууруулах, зээлийн хүүгийн татаас олгох замаар төрөөс санхүүгийн дэмжлэг үзүүлэхээр тусгагджээ.

Зээлийн хүүгийн хэмжээг бууруулах дэмжлэгийн тухайд: Хууль хэрэгжиж эхэлснээс хойш шинээр бий болгосон ажлын байрны тоо, борлуулалтын орлогын хэмжээг харгалзан зээлийн хүүгийн хэмжээг бууруулахтай холбоотойгоор тусгайлсан бодлого, хөтөлбөр хэрэгжүүлээгүй тул тус дэд заалтын хэрэгжилтийн үр дагаврыг үнэлэх боломжгүй байна.

Зээлийн хүүгийн татаас олгох дэмжлэгийн тухайд: Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.8 дахь хэсэгт заасныг үндэслэн Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яамнаас 2022 оны 11 дүгээр сард “Экспортод бүтээгдэхүүнээ гаргасан дунд ангиллын үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдэд зээлийн хүүгийн татаас олгох, хяналт тавих журам”-ыг боловсруулан Сангийн яаманд хүргүүлсэн байна. Гэвч Сангийн яамнаас төсвийн дутагдалтай байдлаас шалтгаалан батлах боломжгүй гэсэн хариу өгснөөр тус журам одоог хүртэл батлагдаагүй байна (ХХААХҮЯ, 2025). Иймд тус заалтын хэрэгжилтийг үр дагаврыг үнэлэх боломжгүй байна.

2.1.2.4. Тоног төхөөрөмжийн санхүүгийн түрээсийн үйлчилгээ, түрээсийн хүүгийн дэмжлэг (§8.1.2.д)

Жижиг, дунд үйлдвэрийн газраас ирүүлсэн мэдээллээр 2019 онд “Мал хамгаалах сан”-г Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх санд нэгтгэсэн байна. Улмаар “Мал хамгаалах сан”-гаас шилжин ирсэн тоног төхөөрөмжүүдийг ЖДҮҮЭ-дэд 3-5 жилийн хугацаатай, хүүгүй нөхцөлөөр санхүүгийн түрээс (лизинг)-ийн гэрээгээр олгожээ.

2020-2023 онуудад нийт 659.9 сая төгрөгийн үнэ бүхий 6 нэр төрлийн 112 ширхэг тоног төхөөрөмжийг ЖДҮҮЭ-дэд олгосон байна (ЖДҮГ, 2025).

Хүснэгт 4. Санхүүгийн түрээсээр олгосон тоног төхөөрөмжийн жагсаалт

№	Тоног төхөөрөмж	2020		2022		2023	
		Тоо	Үнийн дүн (сая төгрөг)	Тоо	Үнийн дүн (сая төгрөг)	Тоо	Үнийн дүн (сая төгрөг)
1	Сүүний хөдөлгөөнт цахилгаан саалтуур	8	12.16	-	-	1	1.01
2	Сүүний цөцгий ялгах цахилгаан ажиллагаатай тоног төхөөрөмж	-	-	3	3.04	58	58.70
3	Бяслаг үйлдвэрлэх тоног төхөөрөмж	-	-	7	40.04	2	10.44
4	Сүүний хөргөлтийн танк	-	-	1	11.35	-	-
5	Хутган махлагчтай арьс боловсруулах тоног төхөөрөмж	6	105.60	5	88.00	-	-
6	Сойзон махлагчтай арьс боловсруулах тоног төхөөрөмж	-	-	4	62.80	17	266.90
Нийт		14	117.76	20	205.2	78	337.048

Эх сурвалж: (ЖДҮГ, 2025)

Ярилцлагын үр дүн

Ярилцлагад хамрагдсан ЖДҮҮЭ-д төрөөс үзүүлж байгаа дэмжлэгүүдийн талаар мэдээлэл хомс байдаг, мэдээлэлд ойр байдаг хүмүүс л дэмжлэгт хамрагддаг талаар онцолсон.

Шигтгээ.

- Энэ дэмжлэгүүдийн талаар мэдээлэлтэй байдаг. Гэхдээ алийг нь ч авч чаддаггүй. Жишээ нь дэлгүүрүүд манайд зорсон мах нийлүүлээч гэсэн хүсэлт байнга тавьдаг. Гэтэл одоо зах зээл дээр ганц компани монополь. Энэ компани ганцаараа зах зээлээ хангаж чадахгүй, зэрэгцээд манайх бас зорсон мах, татсан мах, калбижан мах нийлүүлмээр байдаг. Тэгэхээр тоног төхөөрөмж бас ажлын байр их чухал. Манайх нэг хэсэг Гэгээ гээд захад ажлын байр түрээсэлдэг байсан чинь эзэн нь СУ-д өгнө гээд их олон компани ажлын байргүй болсон. Өөрийн гэсэн ажлын байргүй, түрээсэлдэг болохоор бас хэцүү. Одоо манайх Баянгол дүүрэгт түрээсийн байранд үйл ажиллагаа явуулдаг. Тэр нь хүнсний зориулалттай биш хувцасны чиглэлийнх. Ер нь бид нарт хүнсний зориулалттай шаардлага хангасан ажлын байраар хангах дэмжлэг маш их хэрэгтэй. Бас тоног төхөөрөмжтэй болоход дэмжлэг хэрэгтэй. Манай бизнест худалдан авах зах зээл нь байна. Зарим газарт мах зүсдэг тоног төхөөрөмж, хөлдөөгч гээд байх юм, тэрийгээ хэрэглэхгүй зарна гээд. Ямар хүмүүст дэмжлэг нь олдоод, тэр нь ашиглагдахгүй илүүдээд байдаг юм бол. Тэр илүүдээд байгаа хүмүүс ядаж тоног төхөөрөмжөө бидэнд түрээсэлдэг бол зүгээр юм. Би хамрагдъя гэж хүсээд ч авч чаддаггүй. Би Баянгол дүүрэгт ийм төсөл хэрэгжүүлмээр байгаа, тоног төхөөрөмж олгоод өгөөч гээд хүсэлтээ өгсөн. Сүхбаатар дүүрэгт хандахаар улс төрийн нөхцөл байдлаас болоод юмуу, шийдвэр гаргахдаа маш удаан. Хэрэв би тоног төхөөрөмжийн дэмжлэг авч чадвал Хэнтий, Дорнодоос мах авдаг хүнтэй учраас ажлын байр түрээслээд махан бүтээгдэхүүний бизнесээ өргөжүүлэх боломжтой. Манай бизнесийн хувьд нэгдүгээрт ажлын байр, хоёрдугаарт тоног төхөөрөмж, гуравдугаарт эргэлтийн хөрөнгө чухал хэрэгцээтэй байна. (ЖДҮҮЭ-3)

2.1.3.Татварын хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлэх (§8.1.3)


Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээний салбарт Аж, ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн хүрээнд татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн дэмжлэгийг үзүүлж байна.

Улсын хэмжээнд 2019-2024 онд нийт аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хөнгөлөлтийг 16,546, орлогын албан татварын чөлөөлөлтийг 3,324 жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж нийт 797.8 тэрбум төгрөгийн татварын хөнгөлөлт, чөлөөлөлтөд хамрагджээ (ТЕГ, 2025).

Мөн хугацаанд Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн хүрээнд 26,628 жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчид нийт 3,656.9 тэрбум төгрөгийн чөлөөлөлтөд хамрагдсан байна (мөн тэнд).


Нэмэгдсэн өртгийн албан татвар болон аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хөнгөлөлт, чөлөөлөлтөд хамрагдсан ЖДҮҮЭ-ийн тоог тухайн жилийн нийт ЖДҮҮЭ-ийн тоонд эзлэх хувиар харьцуулбал 2019 онд 6%, 2020 онд 9%, 2021-2024 онд 13% болж тогтвортой өссөн үзүүлэлттэй байна (мөн тэнд).

Зураг 5. Аж, ахуйн нэгжийн орлогын албан татварын хөнгөлөлт, чөлөөлөлт



Эх сурвалж: (ТЕГ, 2025)

Зураг 6. Нэмэгдсэн өртгийн албан татварын чөлөөлөлт



Эх сурвалж: (ТЕГ, 2025)

Санал асуулгын үр дүн

Жижиг, дунд үйлдвэрийн асуудал хариуцсан нийт албан хаагчдын 41.4% (65) нь ЖДҮҮЭ-ийн хамгийн их хүсэлт гаргадаг дэмжлэгт татварын хөнгөлөлт, чөлөөлөлт гэж хариулжээ.

Харин санал асуулгад оролцсон нийт ЖДҮҮЭ-дийн 27% (238) нь татварын хөнгөлөлт, чөлөөлөлтөд хамрагдсан, 54.9% (483) нь татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн дэмжлэг нь хамгийн шаардлагатай байдаг талаар хариулжээ (ЖДҮҮЭ, 2025).

Ярилцлагын үр дүн

Харин ярилцлагад хамрагдсан арван ЖДҮҮЭ-д төрөөс татварын хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлэх замаар дэмжлэг үзүүлдэг талаар огт мэдэхгүй гэж хариулжээ.

Судалгааны үр дүнгээс харахад татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн бодлого нь тодорхой түвшинд хэрэгжиж, хууль хэрэгжиж эхэлснээс хойш дэмжлэгт хамрагдах ЖДҮҮЭ-дийн тоо өссөн үзүүлэлттэй байна. Гэсэн хэдий ч татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн талаарх мэдээллийн хүртээмж сул байгаа нь ЖДҮҮЭ-ийн дунд татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн бодит хэрэглээ, оролцоог хязгаарлаж байгааг илтгэж байна.

2.1.4.Экспортыг нэмэгдүүлэх, импортыг орлох өрсөлдөх чадвартай бүтээгдэхүүний үйлдэрлэл, үйлчилгээг дэмжих (§8.1.4)

Дэлхийн банкны санхүүжилтээр хэрэгжсэн "Экспортыг дэмжих төсөл"-тэй ЖДҮГ хамтран жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийн экспортын чадавхыг сайжруулах, санхүүгийн буцалтгүй тусламж үзүүлэх зорилгоор "Түншлэлийн хөтөлбөр"-ийг хэрэгжүүлсэн.

Тус хөтөлбөрт 2022 онд нийт 43,1 тэрбум төгрөгийн 203 хүсэлт ирснээс 20,2 тэрбум төгрөгийн 100 хүсэлт бүхий төслөөс иж бүрдлийн шаардлага хангасан төслүүдийг Жижиг, дунд үйлдвэрийн газар нарийвчлан судалж, "Түншлэлийн хөтөлбөр"-өөс давхардсан тоогоор 78 төслийн 10,7 тэрбум төгрөгийн гэрээний ажлыг хянаж, Дэлхийн банкны "Экспортыг дэмжих төсөл"-ийн нэгжид хүргүүлснээс **9,6 тэрбум** төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг **54 аж ахуйн нэгжид** олгосон байна.

Ярилцлагад хамрагдсан ЖДҮҮЭ-дийн дөрөв нь экспортыг нэмэгдүүлэх, импортыг орлох өрсөлдөх чадвартай бүтээгдэхүүний үйлдвэрлэл, үйлчилгээг төрөөс дэмждэг талаар сонссон боловч хамрагдаж байгаагүй, тав нь энэ дэмжлэгийн талаар мэдэхгүй гэж хариулжээ.

Шигтгээ.

- Мэднэ, Монгол-Хятадын хоёр жилд нэг удаа болдог экспол мэднэ, тэрэнд оролцдог. Бага зардлаар бараа бүтээгдэхүүнээ гаргах боломжтой байдаг. (ЖДҮҮЭ-1)
- Монгол ноос, ноолууран бүтээгдэхүүнээ экспортод гаргахад төр анхаарч, холбож өгөөсэй гэж хүсдэг. Дотоодын жижиг зах зээлд үнэ нэмэх боломжгүй, олон жил ижил үнээр зарагдаж байна. Импортоор орж ирж буй барааг хязгаарлах нь чухал гэж боддог. Бид нэхий, гутлаа өөрсдөө хийж байгаа ч урдаас ижил төрлийн бүтээгдэхүүн ихээр орж ирдэг. Хятадын ноосыг авч ашигладаг ч, ингэснээр дотоодын ээрмэл утасны үйлдвэрүүд алдагдал хүлээж байдаг. Тиймээс импортын татварыг нэмэх, эсвэл хязгаарлаж, дотоодын үйлдвэрлэлийг хамгаалах бодлого хэрэгтэй гэж үздэг. (ЖДҮҮЭ-2)
- Мэдэхгүй. PayPal, Stripe зэрэг төлбөрийн систем манайд ажилладаггүй. Онлайн худалдааны эрх зүйн орчин байхгүй, ийм байж экспорт дэмжих тухай яриад байдгийг ойлгодоггүй. (ЖДҮҮЭ-5)
- Ер нь мэднэ. Гэхдээ бид хэрэглэж байгаа бүх юмаа Хятадаас авдаг, Монголоос авах юм байдаггүй. (ЖДҮҮЭ-10)

2.1.5. Бүтээгдэхүүн ажил үйлчилгээний борлуулалтад төрийн худалдан авалтаар дэмжих (§8.1.5)

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай (цаашид ТБОНӨХБАҮХАТ) хуулийн шинэчилсэн найруулга 2023 онд батлагдсан бөгөөд тус хуулийн 8 дугаар зүйлийн 8.6 дахь хэсэгт хог хаягдлыг дахин боловсруулсан, хэрэглээний хог хаягдлыг дахин ашиглах, эсхүл боловсруулахаар эргүүлэн авах санал ирүүлсэн, нийслэл, дүүрэг болон улсын зэрэглэлтэй хотоос бусад харьяалалтай орон нутагт үйлдвэрлэсэн түүхий эд, бараа, материалыг ашиглан үйлдвэрлэсэн, инновацын бүтээгдэхүүн, ажиллах хүчний 30 ба түүнээс дээш хувийг хөгжлийн бэрхшээлтэй хүн эзэлдэг, 25 ба түүнээс дээш ажилтантай аж ахуй эрхлэгч үйлдвэрлэсэн бараа санал болгосон ЖДҮҮЭ-д дотоодын барааны хэсгийн үнийн 15 хувиар тендерийн үнээс хийсвэрээр бууруулж тооцно гэж заажээ⁶.

Төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр 2024 онд нийт 26.6 их наяд төгрөгийн төсөвт өртөг бүхий 16,931 төсөл арга хэмжээний тендер шалгаруулалт зохион байгуулсан байна (ТХААГ, 2024). Үүнээс 8,970 төсөл арга хэмжээ нь бараа нийлүүлэх тендер шалгаруулалт байна (мөн тэнд)

ТБОНӨХБАҮХАТ хуулийн 8 дугаар зүйлийн 8.6-д заасны дагуу 2024 онд нийт 187 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 417 тендер шалгаруулалтад оролцогч ЖДҮҮЭ-дийн ирүүлсэн тендерийн үнийг 15 хувиар хийсвэрээр бууруулан үнэлгээг хийсэн байна (ТХААГ, 2025). Энэ нь тухайн жилд зарласан нийт тендер шалгаруулалтын 2.4%-ийг, бараа нийлүүлэх тендер шалгаруулалтын 4.6%-ийг эзэлж байна. Уг зохицуулалт нь нийт ЖДҮҮЭ-дэд хамаарах бус, харин зорилтод бүлэгт чиглэсэн дэмжлэгийн зохицуулалт болохыг харуулж байна.

Харин ЖДҮГ-аас дотоодын үйлдвэр эрхлэгчдийг төрийн худалдан авалтаар дэмжих, төрийн болон орон нутгийн өмчийн байгууллагуудтай холбох, бараа бүтээгдэхүүнийг танилцуулах зорилгоор “Эх оронч худалдан авалт-Үндэсний үйлдвэрлэл 2021” үзэсгэлэнг анх удаа цахим хэлбэрээр ХХААХҮЯ, ЖДҮГ болон ТХААГ, Монголын үндэсний худалдаа

⁶ Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (2023).
Хандах: <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16760359992351>

аж үйлдвэрийн танхим (цаашид МҮХАҮТ), “Экспорт олон улсын худалдааны төв” ТББ-тай хамтран зохион байгуулж, 27 мянга гаруй иргэн сонирхож, 232 ЖДҮҮЭ, **төрийн болон орон нутгийн өмчит 94 байгууллага үзэсгэлэнд оролцсон.**

Тус арга хэмжээг 2023, 2024 онуудад дотоодын үйлдвэрлэгчид болон худалдан авагч талууд (төрийн байгууллагууд, ТӨК-ууд, хувийн хэвшил) хооронд шууд харилцаа үүсгэх, гадаад бүтээгдэхүүний оронд дотоодын ижил төрлийн барааг нийлүүлэх боломжийг бүрдүүлэх зорилгоор Улаанбаатар хотод МҮХАҮТ-тай хамтарч 400 дотоодын үйлдвэрлэгч, **100 гаруй төрийн байгууллага**, 10,000 орчим зочин, худалдан авагч байгууллагуудын төлөөллүүдийг оролцуулан зохион байгуулсан байна.

Ярилцлагын үр дүн

Ярилцлагад хамрагдсан ЖДҮҮЭ-ийн дийлэнх долоо нь төрийн худалдан авалтаар дэмжлэг үзүүлдэг талаар мэдээлэлгүй байсан бөгөөд энэ дэмжлэгт хамрагдах хүсэлтэй байгаагаа илэрхийлсэн. Харин төрийн худалдан авалтад оролцож байсан ЖДҮҮЭ санхүүжилт удаж ордог нь хүндрэлтэй байдаг талаар онцолжээ.

Шигтгээ.

- Төрийн худалдан авалтад оролцож байсан. Баянгол дүүргийн сургалтад цай, кофе нийлүүлж, нэр бүхий сургуульд мах нийлүүлсэн. Гэхдээ төлбөр орж ирэх хугацаа их уддаг тул хэцүү, заримдаа ашиггүй байх тохиолдол гардаг. Манай бизнест эргэлтийн мөнгө чухал байдаг. (ЖДҮҮЭ-3)
- Ковидын үеэр манай үйлдвэрээс эрүүл мэндийн газар, эмнэлэг хөнжил авч байсан. (ЖДҮҮЭ-10)

2.1.6. Бизнесийн зөвлөх үйлчилгээ үзүүлэх (§8.1.6)

Хүнс, хөдөө, аж ахуй, хөнгөн үйлдвэрийн Сайд, Монгол банкны Ерөнхийлөгчийн хамтран баталсан “Бичил, жижиг, дунд үйлдвэр үйлчилгээ эрхлэгчдийн санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх дунд хугацааны хөтөлбөр”-ийн хүрээнд бичил, жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийн санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх сургалтыг 21 аймагт зохион байгуулж, танхимаар 840, цахимаар 450 нийт 1300 орчим ЖДҮҮЭ-д хамрагдсан байна (ХХААХҮЯ, 2023, р. 30). Сургалтыг Монгол банк, ЖДҮГ, Зээлийн батлан даалтын сангийн сургагч багш нар дараах сэдвийн хүрээнд хөтлөн явуулсан байна (ЖДҮГ, 2025). Үүнд:

- Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан болон Хоршоо хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл авах журам;
- санхүүгийн бүтээгдэхүүний талаар ойлголт (Зээл даатгал, зээлийн батлан даалт, банкны баталгаа, гадаад валют, үндэсний валютаар зээл авахын ялгаа гэх мэт);
- Санхүүгийн байгууллагатай хэрхэн харилцах тухай;
- Бизнесийн дэмжлэг, туслалцааны хөтөлбөрүүдийн мэдээлэл (Баталгаа, зөвлөх үйлчилгээ, татварын схем) зэрэг сэдвүүдээр мэдлэг мэдээллийг олгосон (мөн тэнд).

Ярилцлагын үр дүн

Ярилцлагад хамрагдсан ЖДҮҮЭ-ийн дийлэнх нь төрөөс бизнесийн зөвлөх үйлчилгээ үзүүлдэг талаар мэдээлэлгүй байсан. Харин зарим нь жижиг, дунд үйлдвэрийг дэмжих төвүүд ЖДҮҮЭ-дэдээ хүрч ажиллаж чаддаггүй гэсэн байна.

Шигтгээ

- Нийслэл, дүүргийн ЖДҮ дэмжих төвүүдтэй холбоотой ажилладаг. Сүүлийн 2-3 жил ЖДҮ-ийн асуудал ихээр яригдаж, ажил идэвхжиж байна. Өмнө нь төрийн байгууллагууд ихэнхдээ сургалт санал болгодог ч бусад төрлийн дэмжлэгийн мэдээлэл сайн өгдөггүй байсан, өөрөө ч мэдээлэл авахгүй өнгөрдөг байсан. Одоо зөвлөгөө, мэдээлэл авах боломжтой болсон. Гэхдээ хувь хүн өөрөө идэвхтэй байх хэрэгтэй байдаг. (ЖДҮҮЭ-2)
- Үгүй. Татварын байгууллага, төрийн байгууллагууд мэдээлэл өгөхдөө хангалтгүй. Иргэд Google хайлтаар мэдээллээ авах боломжтой хэдий ч хайгаад олдохгүй байна. (ЖДҮҮЭ-5)
- Хувиараа зөвлөгөө авч байсан. Төрийн байгууллагаас авч байгаагүй. Дүүрэг, хороо зэрэгт ЖДҮ төвүүд байдаг ч бидэнд хүрч үйлчилдэггүй. (ЖДҮҮЭ-9)

2.1.7. Судалгаа, хөгжүүлэлтийг дэмжих (§8.1.7-§8.1.8)

Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуулиар шинэ бүтээгдэхүүн хөгжүүлэх, бүтээмжийг нэмэгдүүлэх судалгааг дэмжих (§8.1.7), техник, технологийн дэвшлийг дамжуулах, нутагшуулах, шинжлэх ухаан, технологийн судалгааны үр дүнг үйлдвэрлэлд нэвтрүүлэхэд дэмжлэг (§8.1.8) үзүүлэхээр заасан байна.

Энэ хүрээнд ЖДҮГ-аас Боловсролын яам, Шинжлэх ухаан технологийн сан, АНУ-ын Олон улсын хөгжлийн агентлаг (USAID)-ийн BEST хөтөлбөр зэрэг байгууллагуудтай хамтран ЖДҮҮЭ-дэд үйлдвэрлэлд нэвтрүүлсэн инновац туршлагыг танилцуулах, техник технологийн дэвшлийг нэвтрүүлэх сурталчлах, ажлуудыг жил бүр зохион байгуулж байна. Ингэхдээ эрдэм шинжилгээний байгууллага, судлаачдын бүтээлийг танилцуулан, ЖДҮҮЭ-тэй холбох, хамтран ажиллах боломжийг нэмэгдүүлэх, инновацын чиг хандлага, мэдээллийг хүргэх, мэдээлэл солилцох хэлэлцүүлэг өрнүүлэх зэргээр ЖДҮҮЭ-д дэмжлэг үзүүлж байна.

Шигтгээ

2021-2024 онд зохион байгуулсан арга хэмжээг дурдвал:

- Инновацын бүтээгдэхүүнд хэрхэн хамрагдах талаар ШУТС-гийн сургалт;
- Жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд ШУ-ны паркийн оролцоо;
- Жижиг, дунд үйлдвэрлэлд инновац нэвтрүүлэх нь;
- Инновацлаг ЖДҮ ба Оюуны өмч;
- Инновацын бизнест үзүүлэх нөлөө ба ач холбогдол;
- “Эрдэм шинжилгээний байгууллага, Жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийн хамтын ажиллагааны боломж” хэлэлцүүлэг;
- “Гарааны бизнест хэрхэн хөрөнгө оруулалт татах, бүтээгдэхүүн үйлчилгээгээ зах зээлд хэрхэн амжилттай нэвтрүүлэх”;
- “Монголын Энтрепренерүүдийн нэгдсэн чуулган”;
- Ногоон бизнес загварыг хөгжүүлэх боломж, туршлага.

Эх сурвалж: (ЖДҮГ, 2025)

Харин 2019-2024 онд Шинжлэх ухаан технологийн сангаас техник, технологийн дэвшлийг дамжуулах, нутагшуулах, шинжлэх ухаан, технологийн чиглэлээр 32 судалгааны ажил хийгдсэн байна (ШУТС, 2025). Тухайлбал, Эх орны эрдэс түүхий эдээр өндөр үзүүлэлттэй бетон гарган авах технологийн судалгаа, дулаан хадгалах нано материалын судалгаа, тархмал нарны эрчим хүчний системийг Монгол оронд нутагшуулах технологийн судалгаа гэх мэт (мөн тэнд).

Ярилцлагын үр дүн

ЖДҮҮЭ-ийн дийлэнх нь төрөөс үзүүлж буй дээрх дэмжлэгийн талаарх мэдээлэлд хүрч чадаагүй, огт мэдэхгүй байгаагаа илэрхийлсэн нь мэдээллийн хүртээмж хангалтгүй байгааг харуулж байна.

Шигтээ <i>Шинэ бүтээгдэхүүн хөгжүүлэх, бүтээмжийг нэмэгдүүлэх судалгаа:</i> - Энэ талаар мэдээлэл муутай. Шинжлэх ухааны академи, Мал эмнэлэгийн хүрээлэн, Биологийн хүрээлэн зэрэг байгууллагуудтай хувийн хэвшлийнхэн хамтарч ажиллах боломж нээж өгвөл зүгээр байх гэж боддог. (ЖДҮҮЭ-3) - Сонсож байсан. Шинэ технологи гэдгээр барилгын зураг зурдаг, тооцоолол хийдэг программыг Монголд оруулж ирэх талаар хөөцөлдөж байсан. Тэр нь Боловсролын яамнаас зөвшөөрөл авдаг гээд чадаагүй. Манайхны хэрэглэдэг программыг бодвол илүү хялбар, нарийн тооцоолол хийдэг байсан. Олон зөвшөөрөл шаардлагаас болоод орхисон. (ЖДҮҮЭ-7) <i>Техник, технологийн дэвшлийг дамжуулах, нутагшуулах, шинжлэх ухаан, технологийн судалгааны үр дүнг үйлдвэрлэлд нэвтрүүлэхэд:</i> - Шинэ зүйлийг өөрсдөө л зохицуулж хийдэг. Яг төрөөс дэмждэг талаар мэдэхгүй. Хамрагдаж байгаагүй. (ЖДҮҮЭ-2) - Шинжлэх ухаан технологийн сангаас дэмжлэг авч байсан. ЖДҮ-гээс үгүй.	
---	--

Хуулийн хэрэгжилтийн хүрээнд судалгаа-үйлдвэрлэлийн хоорондын гүүр бий болгох арга хэмжээг тогтмол зохион байгуулж байгаа нь ЖДҮҮЭ, судлаач, төрийн байгууллагын түншлэл нэмэгдэж буйг харуулж байна. Гэвч техник технологийн дэвшлийг нутагшуулах, технологийн судалгааны үр дүнг үйлдвэрлэлд нэвтрүүлэхэд дэмжлэг, хөрөнгө оруулалт, хамрах хүрээ нэмэгдүүлэх шаардлагатай хэвээр байна.

2.1.9. Кластерын хэлбэрээр үйл ажиллагаа явуулдаг ЖДҮҮЭ-ийг дэмжих (§8.1.9)

Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуульд кластерын хэлбэрээр үйл ажиллагаа явуулдаг жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчийг тухайн орон нутаг дахь түүхий эдийн болон ажиллах хүчний нөөц, чадавх бусад онцлогоос хамааран дэмжихээр тусгагдсан байдаг.

ЖДҮГ-ын даргын 2021 оны А/29 дүгээр тушаалаар “Кластераар бүсчлэн хөгжүүлэх чиглэл, кластерын хэлбэрээр үйл ажиллагаа явуулах жижиг, дунд үйлдвэр эрхлэгчийг зохих ангилалд хамааруулахтай холбогдсон журам”-ын төслийг боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулагдсан. Ажлын хэсэг нь их дээд сургуулийн эрдэмтэн судлаач, төрийн бус байгууллагын төлөөлөл бүхий бүрэлдэхүүнтэй ажиллаж “Кластерын ангилал тооцох журам”-ын төсөл боловсруулж, санал авч хэлэлцүүлсэн бөгөөд кластераар бүсчлэн хөгжүүлэх тэргүүлэх чиглэлийг батлах тухай Засгийн газрын тогтоолын төсөл боловсруулж 2021 оны 08 дугаар сард ХХААХҮ-ийн сайд Засгийн газрын бусад гишүүдээс санал авахаар хүргүүлсэн байна. Гэвч тухайн үед Үндэсний хөгжлийн газраас 2021 оны 01/512 дугар албан бичгээр “Кластераар бүсчилэн хөгжүүлэх чиглэл”-д тодорхойлсон бүсүүд нь Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал болон Бүсийн хөгжлийн зорилтот хөтөлбөрийн төсөлд тусгагдсан бүсчлэлтэй зөрчилдөж байгаагаас гадна бусад хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгүүдтэй уялдуулах, нэгтгэх санал ирүүлж, хэлэлцүүлэгдээгүй байна (ХХААХҮЯ, 2025).

Харин “Кластераар бүсчилэн хөгжүүлэх чиглэл” болон “Кластерын ангилал тооцох журам” нь одоог хүртэл батлагдаагүй хэвээр байна.

Ярилцлагын үр дүн

Ярилцлагад хамрагдсан ЖДҮҮЭ-ийн зарим нь кластер хөгжлийн дэмжлэг маш хэрэгтэй байдаг боловч төрөөс энэ чиглэлээр дэмждэг талаар мэдээлэлгүй байна. Харин зарим нь кластерын талаар ойлголт муу байна гэжээ.

Шигтгээ

- Тэр талаар ерөнхий ойлголттой. Манай арьс ширний холбоо кластер байгуулсан, цүнхний үйлдвэрүүд кластер болж ажилладаг, бид ч оролцож байгаа. Кластераар ажиллах нь хамтын хүчээр хөгжих боломж гэж үздэг. Одоогоор төрөөс дэмжлэг аваагүй, Европын холбооноос дэмжлэг авах гэж ажиллаж байна. Төрөөс тэгж дэмждэг гэж сонсоогүй. (ЖДҮҮЭ-1)
- Кластер маш чухал гэж үздэг. Манай бүтээгдэхүүн 21 дамжлагатайгаар үйлдвэрлэгддэг тул кластераар ажиллавал илүү үр дүнтэй байх болов уу гэж боддог. Европын холбоонд ноос, ноолууран бүтээгдэхүүний экспортыг дэмжих кластер байдаг, бид энэ оны 3-р сард гишүүнээр элссэн. Гишүүд нэгдэж арга хэмжээнд оролцож, бүтээгдэхүүнээ гадаадад гаргах зорилготой ажиллаж байна. Гадаадад бүтээгдэхүүнээ гаргахад бичиг баримт бүрдүүлэх асуудал тулгардаг тул төрөөс дэмжлэг хэрэгтэй. Харин кластерын хүрээнд төрөөс дэмжлэг байдаггүй, холбооны зүгээс түрээс төлөх, үзэсгэлэнд оролцуулах байдлаар дэмжлэг үзүүлдэг. (ЖДҮҮЭ-2)
- Кластер нь оролцогч талуудад ашигтай. Төрөөс дэмжих нь зөв бодлого, гэхдээ хэр хүртээмжтэй байдаг бол гэж бодож байна, одоо л сонсож байна. (ЖДҮҮЭ-5)

Судалгааны үр дүнгээс харахад кластерын хэлбэрээр үйл ажиллагаа явуулж буй ЖДҮҮЭ-дийг төрөөс дэмжих бодит хэрэгцээ, шаардлага оршин байгааг харуулж байна. Гэвч уг заалтыг хэрэгжүүлэхэд шаардлагатай бодит дэмжлэгийн механизм бүрдээгүй, дэмжлэгийн арга хэмжээ авч хэрэгжүүлээгүй зэрэг шалтгаанаар энэхүү заалтын хэрэгжилт хангалтгүй, үнэлгээ хийх боломжгүй байгаа нь зорилгодоо хүрээгүйг илтгэж байна.

Иймд кластерын хэлбэрээр үйл ажиллагаа эрхэлж буй ЖДҮҮЭ-дэд чиглэсэн бодлого, санхүүгийн дэмжлэг, хамтын ажиллагааны зохион байгуулалтыг бодлогын түвшинд тодорхойлох шаардлагатай байна.

2.1.10. Гадаад, дотоодын зах зээлд нэвтрэхэд дэмжих (§8.1.10)

Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдийн үйл ажиллагааг дэмжих зорилгоор ЖДҮГ-аас гадаад, дотоод зах зээлд нэвтрэхэд ЖДҮҮЭ-ийг дэмжих, гадаад, дотоодын үзэсгэлэн худалдаанд оролцуулах чиглэлээр дангаар болон холбогдох байгууллагуудтай хамтран жил бүр тогтмол арга хэмжээ зохион байгуулдаг байна. Тухайлбал, гадаад улс орнуудад экспортыг нэмэгдүүлэх, үндэсний үйлдвэрийн бүтээгдэхүүний борлуулалтыг дэмжих зорилгоор 2020-2024 онд БНСУ, АНУ, БНХАУ, ХБНГУ, БНФУ, БНИУ, Канад, Япон, Австралийн Холбооны Улс зэрэг улсуудад 20 удаагийн үзэсгэлэн, арга хэмжээг зохион байгуулсан (ЖДҮГ, 2025). Тус үзэсгэлэн, арга хэмжээнүүдэд 930 гаруй ЖДҮҮЭ оролцож АНУ, БНХАУ, ХБНГУ-д байнгын ажиллагаатай дэлгүүр нээж, нийт 17,1 тэрбум төгрөгийн борлуулалтыг хийсэн байна (мөн тэнд). Харин дотоодын зах зээлийг тэлэх, борлуулалтыг нэмэгдүүлэх чиглэлээр 17 үзэсгэлэн, арга хэмжээ зохион байгуулж 1700 гаруй ЖДҮҮЭ оролцож, 13,7 тэрбум төгрөгийн борлуулалтыг хийсэн байна (мөн тэнд).

Мөн түүнчлэн ЖДҮГ-аас 2023 онд Канадын Мерит төсөлтэй хамтран жижиг, дунд үйлдвэрийн бэлтгэн нийлүүлэлтийн тогтолцоог бүрдүүлэх чиглэлээр 4 аймгийн 21 ЖДҮҮЭ-дийг 81 уул уурхайн байгууллагатай холбосноор 230 гэрээ хийгдэж, 5,2 тэрбум төгрөгийн борлуулалт хийсэн байна (ЖДҮГ, 2025). Цаашид энэхүү тогтолцоог улсын хэмжээнд нэвтрүүлэх чиглэлээр ЗГ-ын хэрэгжүүлэгч агентлаг Ашигт малтмал газрын тосны газартай “Хамтран ажиллах гэрээ” байгуулан ажиллаж байгаа талаар ЖДҮГ-ын тайланд дурджээ (мөн тэнд).

Ярилцлагын үр дүн

Ярилцлагад хамрагдсан зарим ЖДҮҮЭ-д гадаад, дотоодын зах зээлд нэвтрэхэд төрөөс үзүүлж буй дэмжлэгт хамрагдсанаар үндэсний үйлдвэрлэгчдийн танигдах байдал, гадаад харилцаа, борлуулалт сайжирсан эерэг нөлөөлөл гарсан талаар ярьсан бол зарим нь энэ дэмжлэгт хамрагдаж байгаагүй гэжээ.

Шигтээ

- Хоёр улсын экспор бодитой дэмжлэг байж чаддаг. Энэ нь манай экспортыг дэмжиж байгаа ганц дэмжлэг гэж харж байна. Түүнд Нарантуулын жижиг цехүүд хүртэл явдаг. Ер нь 1000-аад үйлдвэрлэгч явдаг, тэр дотор том, жижиг, дөнгөж үйл ажиллагаа эхэлж байгаа бизнес ч оролцдог. Бүх хүн хамрагддаг, маш бага түрээсийн зардалтай, бүх бараа бүтээгдэхүүн татваргүй гардаг болохоор төрөөс үзүүлж буй маш чухал дэмжлэг. Ард түмэн, үйлдвэрлэгч нарт маш их өгөөжөө өгч байгаа ганц үзэсгэлэн. (ЖДҮҮЭ-1)
- Намрын өдрүүд зэрэг дотоодын үзэсгэлэн худалдаанд оролцдог. Өөр дэмжлэгт хамрагдаж байгаагүй. Үзэсгэлэнд оролцоход заримдаа түрээс өндөр байдаг. Жишээ нь наадмаар болох үзэсгэлэнгийн түрээс 250 мянган төгрөг, 3 өдөр гарахаар 750 мянга төгрөг болно. Төр нь мөнгө олох гээд байна уу, ЖДҮ-гээ дэмжих гээд байна уу. Түрээс өндөр байгааг анхаарах хэрэгтэй. (ЖДҮҮЭ-3)
- Энэ нь бүтээгдэхүүнээс шалтгаална. Төрөөс зардлыг хөнгөлөөд явуулж байгаа нь сайн боловч, тухайн бүтээгдэхүүний зах зээлд ямар байгаагаас их шалтгаалдаг юм байна. Манай барагшуун тэнд сайн танигдаагүй. Жишээ нь, ноолууран бүтээгдэхүүний хувьд ашигтай харагдсан. (ЖДҮҮЭ-4)

2.2. Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээний кластерыг дэмжих (§ 9 дүгээр зүйл)

Жижиг, дунд үйлдвэр үйлчилгээг кластераар хөгжүүлэхэд төрөөс үзүүлэх дэмжлэгийн тухайд (§9.1):

Жайка-Монмап төслийн хүрээнд ЖДҮГ-аас кластер хөгжүүлэхтэй холбоотой тулгарч буй нөхцөл байдал, асуудлуудыг тодорхойлох, бүс нутгийн хөгжлийн бодлогын чиглэл дэх кластерын хөгжлийн бодлогын байр суурь, кластерын бодлогын чиг хандлагын судалгааг боловсруулсан байна.

Түүнчлэн жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг кластераар хөгжүүлэхэд дэд бүтцийн хангамжийг сайжруулах чиглэлээр Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгүүдтэй уялдуулан ХХААХҮЯ болон Эдийн засаг, хөгжлийн яамны захиалгаар Япон Улсын хамтын ажиллагааны байгууллага (Жайка) Монгол улсын бүс нутгийн онцлог хүчин зүйлсийг тусгасан стратегийн хөдөө аж ахуйн нэмүү өртгийн сүлжээг хөгжүүлэх Мастер төлөвлөгөөг боловсруулсан байна. Уг мастер төлөвлөгөөг Монгол Улс 2025-2034 он хүртэл 10 жилийн хугацаатай хэрэгжүүлнэ.

Харин үйл ажиллагаагаараа хорших, төрөлжих, хамтран ажиллах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор ХХААХҮ-ийн сайдын 2023 оны А/521 дугаар тушаалаар Хоршоог хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтийг сайжруулж, чанаргүй зээлийг бууруулж орон нутгийн хоршоог хөгжүүлэх сангаас зөвхөн хоршоод зээл авах боломжийг бүрдүүлсэн байна. Тус журмын өөрчлөлтийг таниулж, сурталчлах замаар сангийн эргэн төлөлтийг сумын хоршоод, хоршооны гишүүдийн оролцоотой татан төвлөрүүлэх ажлыг хэрэгжүүлэхээр Хэнтий аймаг болон МХААХҮХ-ны гишүүн хоршоодыг танхимын сургалтад, 21 аймгийн, 333 сумын асуудал хариуцсан мэргэжилтнүүд, хоршоодын 190 төлөөллийг цахим сургалтад хамруулсан (ЖДҮГ, 2025). Мөн ЖДҮҮЭ-ийг чадавхжуулах, мэдээ мэдээллээр хангах, эрх зүйн орчны өөрчлөлт, төрөөс баримталж буй бодлого арга хэмжээг

сурталчлах ажлыг зөвлөгөөн, сургалт хэлбэрээр Сэлэнгэ, Дундговь, Сүхбаатар, Дорнод, Хөвсгөл аймгуудад зохион байгуулсан байна.

Кластерын хэлбэрээр үйл ажиллагаа явуулж буй ЖДҮҮЭ-ийн ангилал тооцох журмын тухайд (§9.2-§9.3):

Тус хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2 болон 9.3 дахь хэсэгт Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгч нь кластерын хэлбэрээр үйл ажиллагаа явуулах тохиолдолд тэдгээрийн ажилтны тоо, борлуулалтын орлогын хэмжээг нэгтгэн тооцож, зохих ангилалд хамааруулж болох ба ангилал тооцох журмыг жижиг, дунд үйлдвэрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална гэж заасан байдаг.

Энэ хүрээнд ЖДҮГ-аас Их дээд сургуулийн эрдэмтэн судлаач, төрийн бус байгууллагын төлөөлөл бүхий бүрэлдэхүүнтэй ажиллаж “Кластерын ангилал тооцох журам”-ын төсөл боловсруулж, санал авч хэлэлцүүлсэн бөгөөд кластераар бүсчлэн хөгжүүлэх тэргүүлэх чиглэлийг батлах тухай Засгийн газрын тогтоолын төсөл боловсруулж 2021 оны 08 дугаар сард ХХААХҮ-ийн сайдаар уламжлан ЗГХЭГ-т хүргүүлсэн байна.

Гэвч өнөөдрийг хүртэл тус тогтоол нь батлагдаагүй байгаа нь хэрэгжилтийг ханган ажиллаагүйг илтгэж байна.

Орон нутаг дахь Кластерын хэлбэрээр үйл ажиллагаа эрхлэгчдийг дэмжих (§9.4):

Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуулийг 9 дүгээр зүйлийн 9.4 дэх хэсэгт заасны дагуу Орон нутагт кластерын хэлбэрээр үйл ажиллагаа явуулах аж ахуйн нэгжийн төсөл нь кластераар бүсчлэн хөгжүүлэх чиглэл (15.1.2)-д хамаарч байвал төрөөс тэргүүн ээлжинд дэмжихээр заасан байдаг. Гэвч кластераар бүсчлэн хөгжүүлэх тэргүүлэх чиглэл батлагдаагүй тул энэ хэсгийг үнэлэх боломжгүй юм.

Харин Монгол Улсын Их Хурлын 2024 оны 64 дүгээр тогтоолоор батлагдсан Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд бүсүүдийн тэргүүлэх чиглэлийг тодорхойлсон байдаг. Иймд бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалтай уялдуулах нь зүйтэй юм.

Жижиг, дунд үйлдвэрийг Кластераар бүсчлэн хөгжүүлэх чиглэлийг тогтоох ажлын хүрээнд өмнө нь дурдсанчлан бусад хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгүүдтэй уялдуулах, нэгтгэх санал ирсэнтэй холбоотойгоор батлагдаагүй байна.

Харин УИХ-ын 2024 оны 64 дүгээр тогтоолоор батлагдсан Монгол Улсын Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд бүсийн хөгжлийн нийтлэг зорилгод Үйлдвэр, үйлчилгээг хоршилт, төрөлжилт, дагналт, кластерын бодлогоор дэмжинэ гэж тусгагджээ.

Шигтгээ.	
- Бүсүүдэд Орон нутгийн хөгжлийн төвүүдэд үйлдвэрлэл, үйлчилгээ, худалдаа, бирж, тээвэр, логиستيкийн цогцолборыг кластераар хөгжүүлэх хувийн хэвшил, хоршоодыг тэргүүн ээлжид дэмжинэ. - Чойр хотыг логиستيкийн төв, хуурай боомтод түшиглэн олон улсын худалдааны төв, оёдлын кластерын загвараар хөгжүүлнэ.	
	(Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал)

Иймд Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд заасан бүсийн хөгжлийн зорилгод нийцүүлэн “Кластераар бүсчлэн хөгжүүлэх чиглэл”, Кластерын ангилал тооцох журмыг боловсруулан батлуулж, хуулийн хэрэгжилтийг хангах шаардлагатай байна.

Нийслэлийн тусгай бүсэд үйл ажиллагаа эрхлэгчдийг дэмжих (§9.5):

Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.5-д Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 39.1-д заасан чиглэлээр нийслэл хотын тусгай бүсэд **үйл ажиллагаа эрхлэх** бол тухайн аж ахуйн нэгжийг төрөөс тэргүүн ээлжид дэмжинэ гэж тусгагджээ.

Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1 дэх хэсэгт Тусгай бүсийг үйл ажиллагааны дараах чиглэлээр дагнан, эсхүл хослуулж байгуулж болно гэж заасан байна. Үүнд: Мэдээлэл технологи, инновац, аялал жуулчлал, соёл амралт, хүлэмж, агуулахын аж ахуй, хөнгөн болон хүнсний үйлдвэрлэл (согтууруулах ундаа болон тамхины үйлдвэрлэл орохгүй), агаарын хөлгийн засвар, үйлчилгээ, угсралт.

Засгийн газрын 2024 оны "Эдийн засгийн тусгай бүс байгуулах тухай" 220 дугаар тогтоолоор Хүнсний аюулгүй байдлыг хангах, экспортын чиг баримжаатай хүнс, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хөгжүүлэх, хүн амын хүнсний хангамжийг нэмэгдүүлэх зорилгоор нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн 21 дүгээр хорооны нутаг дэвсгэрт хүлэмж-агуулахын аж ахуй, хөнгөн болон хүнсний үйлдвэрлэлийн чиглэлээр "Агро-сити" эдийн засгийн тусгай бүсийг, олон улсын тээвэр логистик, аялал жуулчлалын төрөлжсөн үйлчилгээ, аж үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээг кластераар хөгжүүлэх зорилгоор Налайх дүүргийн 3, 5 дугаар хорооны нутаг дэвсгэрт хөнгөн үйлдвэрлэлийн чиглэлээр "Налуу-Ухаа" эдийн засгийн тусгай бүсийг байгуулахаар тогтоосон байна. Энэхүү тогтоолоор Агро-сити тусгай бүсийн эдэлбэр газрын байршил, хил заагийг баталсан бөгөөд уг тусгай бүсэд одоогоор үйл ажиллагаа явуулж эхлээгүй байна.

Иймд тухайн бүсэд үйл ажиллагааг эрхлэх аж ахуйн нэгжийг тэргүүн ээлжид дэмжих заалтын хэрэгжилтийг үнэлэх боломжгүй байна.

2.3.Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөр (§10 дугаар зүйл)

Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуулийн 10 дугаар зүйлд жижиг, дунд үйлдвэрийн тэргүүлэх чиглэлийг тодорхойлох, өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, ажлын байр, санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх, кластераар төрөлжүүлэн хөгжүүлэхэд чиглэсэн дунд хугацааны хөтөлбөр (§10.1), ахуйн үйлчилгээний салбарт дэвшилтэт технологийг нэвтрүүлэх, стандартад нийцсэн үйлчилгээг иргэдэд хүргэх, албан бус хөдөлмөр эрхлэлтийг багасгаж ажлын байрыг нэмэгдүүлэхэд чиглэсэн дунд хугацааны хөтөлбөр (§10.2)-тэй байхаар хуульчлагдсан байна. Мөн эдгээр хөтөлбөрүүдийг боловсруулах, хэрэгжүүлэх, дүгнэхэд эрдэм шинжилгээний болон төрийн бус байгууллага, олон нийтийн оролцоог ханган ажиллахаар зохицуулагдсан байдаг.

Жижиг, дунд үйлдвэрийн тэргүүлэх чиглэлийг тодорхойлох, өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, ажлын байр, санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх, кластераар төрөлжүүлэн хөгжүүлэхэд чиглэсэн дунд хугацааны хөтөлбөр:

Засгийн газрын 2019 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн 156 дугаар тогтоолоор "Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих үндэсний хөтөлбөр"-ийг баталсан байдаг. Тус хөтөлбөр нь Жижиг, дунд үйлдвэр эрхлэгчийг дэмжих замаар бүтээмжийг өсгөх, зах зээлд өрсөлдөх чадварыг дээшлүүлэн ажлын байр нэмэгдүүлэхэд хөтөлбөрийн зорилгоор 6 зорилтын хүрээнд 47 үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр тусгасан байна. Тус хөтөлбөр нь 2019-2022 оныг дуустал 2 үе шаттай хэрэгжсэн бөгөөд 2023 онд ХХААХҮЯ-наас тус хөтөлбөрийн хэрэгжилтийн үр нөлөөний үнэлгээг хийж, хөтөлбөрийн үр дүнг тодорхойлох шалгуур үзүүлэлтийн үнэлгээг 73.5 хувиар дүгнэсэн байна (ХХААХҮЯ, 2023).

Ахуйн үйлчилгээний салбарт дэвшилтэт технологийг нэвтрүүлэх, стандартад нийцсэн үйлчилгээг иргэдэд хүргэх, албан бус хөдөлмөр эрхлэлтийг багасгаж ажлын байрыг нэмэгдүүлэхэд чиглэсэн дунд хугацааны хөтөлбөр:

Засгийн газрын 2019 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн 418 дугаар тогтоолоор “Ахуйн үйлчилгээний салбарыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр”-ийг баталсан байна. Тус хөтөлбөр нь иргэдэд чанартай, стандартын шаардлагад нийцсэн ахуйн үйлчилгээг үзүүлэх, иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, ядуурлыг бууруулах, жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг хөгжүүлэхэд ахуйн үйлчилгээний салбарын гүйцэтгэх үүргийг нэмэгдүүлэх зорилгоор 5 зорилтын хүрээнд 32 үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр тусгасан байна. Тус хөтөлбөр нь 2020-2024 онд хэрэгжүүлсэн байна.

Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн шинэчилсэн найруулга 2020 оны 05 дугаар сарын 07-ны өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн. Тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.11 дэх хэсэгт “... бусад хууль тогтоомжид “үндэсний хөтөлбөр” гэснийг энэ хуулийн 6.5-д заасан Хөгжлийн зорилтот хөтөлбөрт тус тус хамааруулж ойлгоно” гэж заасан байна. Харин тус хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.5 дахь заалтаар “Хөгжлийн зорилтот хөтөлбөр” гэж Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод тусгагдсан тодорхой зорилт, арга хэмжээг улсын хэмжээнд хэрэгжүүлэхээр салбар, салбар хоорондын болон бүс, орон нутгийн онцлогт нийцсэн, нөөцөд суурилсан, санхүүгийн эх үүсвэрээр баталгаажсан үйл ажиллагаа, тоон болон чанарын шалгуур үзүүлэлтийг тусгасан дунд хугацааны бодлогын баримт бичгийг ойлгоно гэж тодорхойлсон бөгөөд 6 дугаар зүйлийн 6.5 дахь хэсэгт “Хөгжлийн зорилтот хөтөлбөр”-ийн төрлийг тодорхойлсон байдаг.

Иймд Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуулийн 10 дугаар зүйлийг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.5 дахь хэсэгт нийцүүлэн өөрчлөн найруулах нь зүйтэй юм.

2.4. Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан

Үнэлэх хэсэг	11 дүгээр зүйл. Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан
Томьёолсон шалгуур үзүүлэлт	- Сангийн үйл ажиллагаа зорилгодоо хүрсэн эсэх? - Сангийн үйл ажиллагаатай холбоотой журмууд батлагдсан эсэх? - Сангаас нэг удаа олгох зээлийн хэмжээ практикад нийцэж байгаа эсэх? - Хөнгөлөлттэй зээл олгохгүй байх нөхцөлүүд практикад нийцсэн эсэх? - Сонгон шалгаруулалт нээлттэй, ил тод, шударга явагддаг эсэх?

2.4.1. Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн тухай (§11.1-11.4)

Засгийн газрын 2020 оны 49 дүгээр тогтоолоор Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн ажлын албыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Жижиг, дунд үйлдвэр, хоршооны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газартай нэгтгэн Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг “Жижиг, дунд үйлдвэрийн газар”-ыг байгуулсан байна.

Мөн Засгийн газрын тусгай сангийн тухай хуулиар Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн хөрөнгийн бүрдүүлэлт, зарцуулалт, гүйцэтгэлийг тайлагнах, хянахтай холбоотой харилцааг зохицуулсан байдаг.

Сангийн хөрөнгийн бүрдүүлэлтийн тухайд: Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2, 16.4 дэх хэсэгт тус тус зааснаар Жижиг, дунд

үйлдвэрийг хөгжүүлэх сан нь дараах эх үүсвэрээс бүрдэнэ. Үүнд, улсын төсвийн хөрөнгө, хандив, тусламж, тусгай сангийн өөрийн үйл ажиллагаанаас олсон орлого, зээлийн хүүгийн орлого, мөн орон нутгийн төсвөөс олгосон хөрөнгө зэрэг багтана.

Хүснэгт 5. Сангийн эх үүсвэрийн бүрдүүлэлт (тэрбум төгрөг)

Эх үүсвэрийн ангилал	2020	2021	2022	2023	2024	Нийт
Зээлийн эргэн төлөлт	21.8	-	14.8	31.5	35.9	104.0
Улсын төсвөөс	-	-	-	-	-	-
Орон нутгийн санхүүжилт	1.0	-	5.0	5.8	4.2	16.0
Гадаадын хөнгөлөлттэй зээл	-	0.8	-	2.6	4.2	7.6
Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний санхүүжилт	-	-	-	2.1	3.2	5.3
Нийт эх үүсвэр	22.8	0.8	19.8	42.0	47.5	132.9

Эх сурвалж: (ЖДҮГ, 2025)

Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх санд 2020-2024 онд нийт 132.9 тэрбум төгрөгийг төвлөрүүлсэн байна. Үүнд, нийт эх үүсвэрийн 78.3%-ийг зээлийн эргэн төлөлт, 12%-ийг орон нутгийн санхүүжилт, 5.7%-ийг гадаадын хөнгөлөлттэй зээл, 2.4%-ийг УИХ-ын 2022 оны 36 дугаар тогтоолоор батлагдсан Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний санхүүжилтээс тус тус бүрдүүлсэн байна (ЖДҮГ, 2025). Харин тус хугацаанд улсын төсвөөс санхүүжилт олгогдоогүй байна.

Сангийн хөрөнгийн зарцуулалтын тухай: Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.6 дахь хэсэгт сангийн хөрөнгийг зарцуулах арга хэмжээг тодорхойлсон байдаг. Үүнд, хөнгөлөлттэй зээл олгох, бүтээгдэхүүнээ экспортод гаргасан бол зээлийн хүүгийн татаас олгох, бизнес, инкубацийн зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах, сургалт, давтан сургалтад хамруулах, жижиг, дунд үйлдвэрлэлийн чиглэлээр судалгаа, шинжилгээ хийхэд дэмжлэг үзүүлэх, үндэсний болон олон улсын хэмжээний үзэсгэлэн, худалдаа, чуулга уулзалт зохион байгуулах, дэмжлэг үзүүлэх, тоног төхөөрөмжийн санхүүгийн түрээсийн үйлчилгээ үзүүлэх зэрэг үйл ажиллагаа орно.

Гэвч ЖДҮГ-аас ирүүлсэн мэдээллээр Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих сангийн хөрөнгийг зөвхөн хөнгөлөлттэй зээл олгоход зарцуулж байна. 2020-2024 онд ЖДҮГ-дээс нийт 572.8 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 3865 төслийн санал ирүүлснээс 24.8% буюу 960 төсөлд зээл олгожээ.

Хүснэгт 6. Санд ирүүлсэн нийт зээлийн хүсэлт болон олгосон зээлийн харьцуулалт

Он	Нийт хүсэлт		Олгосон		Нийт хүсэлтэд эзлэх хувь	
	Төсөл	Зээлийн хэмжээ (тэрбум.төг)	Төсөл	Зээлийн хэмжээ (тэрбум.төг)	Төсөл	Зээлийн хэмжээ
2020	1,579	238.5	249	22.8	15.8%	9.6%
2021	16	1.2	12	0.8	75.0%	66.7%
2022	608	87.8	156	19.2	25.7%	21.9%
2023	820	120.8	265	35.4	32.3%	29.3%
2024	842	124.5	278	38.3	33.0%	30.8%

Нийт	3,865	572.8	960	116.5	24.8%	20.3%
------	-------	-------	-----	-------	-------	-------

Эх сурвалж: (ЖДҮГ, 2025)

Харин хөнгөлөлттэй зээлд хамрагдсан ЖДҮҮЭ-ийн үйл ажиллагааны чиглэлээр харьцуулан харахад дийлэнх буюу 73%-ийг хүнс болон хөнгөн үйлдвэрлэл, мал аж ахуй, газар тариалангийн салбарын төслүүд эзэлж байна.

Хүснэгт 7. Сангийн зарцуулалт (салбараар)

Он	2020		2021		2022		2023		2024	
Зарцуулалт	төслийн тоо	зээлийн хэмжээ /сая.₮/	төслийн тоо	зээлийн хэмжээ /сая.₮/	төслийн тоо	зээлийн хэмжээ /сая.₮/	төслийн тоо	зээлийн хэмжээ /сая.₮/	төслийн тоо	зээлийн хэмжээ /сая.₮/
Хүнсний үйлдвэр	72	6,238	5	291	33	4,634	64	9,065	96	13,359
Хөнгөн үйлдвэр	46	3,596	1	45	19	2,583	47	5,559	53	7,518
Газар тариалан	26	2,301	4	322	22	2,321	41	5,687	32	3,927
Мал аж ахуй	-	-	2	152	32	3,827	57	7,554	47	6,700
Барилгын үйлдвэрлэл	-	-	-	-	2	202	-	-	-	-
Зоорь	49	4,737	-	-	17	2,038	31	5,144	14	2,418
Био	9	1,024	-	-	-	-	-	-	-	-
Үйлчилгээ	29	3,163	-	-	6	440	25	2,495	27	3,381
Бусад	5	427	-	-	21	2,401	-	-	4	451
Боловсруулах үйлдвэр	13	1,330	-	-	4	736	2	190	-	-
Дахивар	-	-	-	-	-	-	-	-	5	595
Нийт дүн	249	22,816	12	810	156	19,182	267	35,694	278	38,349

Эх сурвалж: (ЖДҮГ, 2025)

ЖДҮГ нь Засгийн газрын 2020 оны 113 дугаар тогтоолоор Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, дамжуулан зээлдүүлэх, эргэн төлүүлэх, хяналт тавих журмыг баталж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. 2024 оны байдлаар 278 төсөлд 38.3 тэрбум төгрөгийн зээл олгосон нь 2020 онтой харьцуулахад хөнгөлөлттэй зээлд хамрагдсан төслийн тоо 11.6%-иар, олгогдсон зээлийн хэмжээ 67.9%-иар өссөн үзүүлэлттэй (Хүснэгт 6-оос харна уу) байна.

Хүснэгт 8. Сангаас зээл олгосноор гарсан үр дүн

Бодит үр нөлөө		2020	2021	2022	2023	2024	Нийт
Үйл ажиллагаа	Өргөтгөсөн	202	12	119	213	224	770
	Шинэ	47	0	37	52	54	190
Ажлын байр	Хадгалсан	811	24	815	895	1,007	3,552
	Шинэ	1,497	74	1,002	1,326	1,290	5,189

Эх сурвалж: (ЖДҮГ, 2025)

Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, дамжуулан зээлдүүлэх, эргэн төлүүлэх, хяналт тавих журмын дагуу сангаас

зээл олгож эхэлснээс хойш нийт 770 ЖДҮҮЭ үйл ажиллагаагаа өргөтгөн, 3,552 ажлын байрыг хадгалсан бол 190 ЖДҮҮЭ шинээр үйл ажиллагаа эхлүүлж, 5,189 шинэ ажлын байр бий болгосон эерэг үзүүлэлттэй байна (ЖДҮГ, 2025).

2.4.2. Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, төсөл сонгон шалгаруулах журам (§11.5)

Тус хуулийн 11 дүгээр зүйлийн 11.5 дахь хэсэгт Сангаас хөнгөлөлттэй зээл олгох, төсөл сонгон шалгаруулах журмыг Засгийн газар батална гэж заасан байна.

Энэ хүрээнд Засгийн газрын 2020 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн 113 дугаар тогтоолоор “Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, дамжуулан зээлдүүлэх, эргэн төлүүлэх, хяналт тавих журам”-ыг баталсан байна.

Тус журмаар экспортыг нэмэгдүүлж, импортыг орлох бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжин өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, инновацыг дэмжих, шинээр бизнес эхлүүлэх болон ажлын байр бий болгох, нэмэгдүүлэх зорилгоор жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдэд Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, дамжуулан зээлдүүлэх арилжааны банкныг сонгох, эргэн төлүүлэх, хяналт тавихтай холбогдон үүсэх харилцааг зохицуулж байна.

Мөн журамд сангаас хөнгөлөлттэй зээл олгох, төсөл сонгон шалгаруулах хороо, дэд хорооны бүрэлдэхүүн, эрх, үүрэг болон төсөлд тавигдах шаардлага, хавсаргах материал, төсөл сонгон шалгаруулалт зарлах, хүлээн авах, төслийн үнэлгээний аргачлал, үе шат зэргийг нарийвчлан зохицуулсан байна.

2.4.3. Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдэд нэг удаа олгох зээлийн хэмжээ (§11.6, §11.7)

Тус хуулийн 11.6 дахь хэсэгт Сангаас жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчид нэг удаа олгох зээлийн хэмжээг ЖДҮҮЭ-ийн ангилал болон борлуулалтын орлогоос хамааруулан 2.5 тэрбум төгрөг хуульчилсан байдаг. Мөн Засгийн газрын 2020 оны 113 дугаар тогтоолоор Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, дамжуулан зээлдүүлэх, эргэн төлүүлэх, хяналт тавих журмаар олгох зээлийн доод хэмжээ болон бичил үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдэд борлуулалтын орлогоос хамаарсан зээлийн дээд хэмжээг нарийвчлан зохицуулсан байна.

Хүснэгт 9. Сангаас нэг удаа олгох хөнгөлөлттэй зээлийн хэмжээ

Д/д	Ангилал	Зээл олгох хэлбэр	Хуулийн зохицуулалт (§11.6)	Журмын зохицуулалт	
				Борлуулалтын орлого	Зээлийн дээд хэмжээ
1	Бичил үйлдвэр, үйлчилгээ эрхлэгч	Сангаас шууд олгох	300 сая хүртэл	0-100 сая хүртэл	100 сая хүртэл
				100-200 сая хүртэл	200 сая хүртэл
				200 саяас дээш	300 сая хүртэл
2	Жижиг үйлдвэр, үйлчилгээ эрхлэгч	Банкаар дамжуулан олгох	1 тэрбум хүртэл	300 саяас дээш	1 тэрбум хүртэл
3	Дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгч		2.5 тэрбум хүртэл	1-2.5 тэрбум хүртэл	2.5 тэрбум хүртэл

Эх сурвалж: Судлаачийн боловсруулснаар.

Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.6 дахь хэсэгт заасан ЖДҮҮЭ-дэд нэг удаа олгох зээлийн дээд хэмжээг ЗГ-ын 2020 оны 113 дугаар тогтоолоор батлагдсан “Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, дамжуулан зээлдүүлэх, эргэн төлүүлэх, хяналт тавих журам”-аар борлуулалтын орлогын хэмжээнээс хамааруулан нэг удаа олгох зээлийн дээд, доод хязгаарыг нарийвчлан тогтоож өгсөн байна (Хүснэгт 7).

Мөн журмын 4 дүгээр зүйлд дамжуулан зээл олгох банкныг сонгон шалгаруулах, хяналт тавих, 12 дугаар зүйлээр банкаар дамжуулан олгох зээлийн санхүүжилтийн талаар тус тус зохицуулсан байна.

Ярилцлагын үр дүн

Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчид ЖДҮ хөгжүүлэх сангаас нэг удаа олгох зээлийн хэмжээ хангалттай байдаг ч барьцаа хөрөнгийн шаардлагаас шалтгаалан анх хүссэн зээлийн хэмжээг бууруулж олгох тохиолдол байдаг талаар дурдсан юм.

Шигтгээ.

- (Хүсэлт өгөөд зээл авч чадаагүй). Хэрэв зээл авч чадвал хангалттай хүрнэ, би тооцоо хийж үзсэн. (ЖДҮҮЭ-4)
- Мэдээж дэмжлэг болдог. Гэхдээ манайх 1 тэрбум 500 сая төгрөгөөр батлагдлаа гэхэд барьцаа хөрөнгө байхгүйгээс зээл нь танагдаж, дээр хэлсэнчлэн 50 эсвэл 30 хувь олгогддог тул анхны хэрэгцээгээ хангаж чаддаггүй. (ЖДҮҮЭ-9)

2.4.4. Экспортод бүтээгдэхүүнээ гаргасан дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчид зээлийн хүүгийн татаас олгох (§11.8-§11.10)

Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яамнаас 2022 оны 11 дүгээр сард “Экспортод бүтээгдэхүүнээ гаргасан дунд ангиллын үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдэд зээлийн хүүгийн татаас олгох, хяналт тавих журам”-ыг боловсруулан Сангийн яаманд хүргүүлсэн байна. Гэвч Сангийн яамнаас төсвийн дутагдалтай байдлаас шалтгаалан батлах боломжгүй гэсэн хариу өгснөөр тус журам одоог хүртэл батлагдаагүй байна.

Түүнчлэн Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн үйл ажиллагааг Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 16 дугаар зүйл болон Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуулийн 11 дүгээр зүйлээр зохицуулсан байдаг. Харин тус зохицуулалтуудад ойлголтын зөрүүтэй байдал үүссэнийг Хүснэгт 4-т харуулав.

Хүснэгт 10. Зээлийн хүүгийн татаас олгох зохицуулалтууд

Засгийн газрын тусгай сангийн тухай хууль	Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хууль
16.6.2.жижиг, дунд <u>үйлдвэрлэл</u> эрхлэгчид бүтээгдэхүүнээ экспортод гаргасан бол зээлийн хүүгийн татаас олгох;	11.8.Дунд <u>үйлдвэр, үйлчилгээ</u> эрхлэгч бүтээгдэхүүнээ экспортод гаргасан тохиолдолд банкнаас авсан зээлийн жилийн хүүгийнх нь 5.0 хүртэл хувийг Сангаас олгож болно.

Дээрх хоёр хуульд Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн хөрөнгийг зарцуулах үйл ажиллагааг харилцан адилгүйгээр зохицуулсан нь жижиг үйлдвэрлэл эрхлэгч болон үйлчилгээ эрхлэгчдийг эрх зүйн зохицуулалтаас гадуур үлдээх, улмаар хууль хэрэгжүүлэгч байгууллагад ойлгомжгүй байдлыг үүсгэж байна

Иймд Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.8 дахь хэсгийг Засгийн газрын тусгай сангийн тухай хуультай нийцүүлэн өөрчлөн найруулах шаардлага байгааг харуулж байна.

Экспортод бүтээгдэхүүн гаргасан дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчид жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас зээлийн хүүгийн татаас олгох, хяналт тавих журам батлагдаагүй тул 11 дүгээр зүйлийн 11.9 дэх хэсэгт заасан сангаас зээл, зээлийн хүүгийн татаас олгоход баримтлах хязгаарлалт өнөөдрийг хүртэл ашиглагдаагүй байна.

Иймд хуулийн §11.8-§11.10 дахь хэсгүүдийн хэрэгжилтийг үнэлэх боломжгүй байна.

2.4.5. Хөнгөлөлттэй зээл олгохгүй нөхцөл (§11.11)

Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас олгох хөнгөлөлттэй зээлийг (1) сангаас авсан зээлийн үлдэгдэлтэй, (2) зээлийн мэдээллийн санд муу зээлийн түүхтэй, (3) Сангаас авсан зээлийг зориулалтын бусаар ашигласан нь тогтоогдсон, (4) шүүхийн шийдвэрээр бусдад төлөх өртэй (5) төсөл хүлээн авах сүүлийн өдрийн байдлаар нийгмийн даатгал, татварын байгууллагад өртэй жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдэд олгохгүй гэж хуульчилсан байна. Харин өмнө дурдсанчлан Засгийн газрын 2020 оны 113 дугаар тогтоолоор батлагдсан журамд илүү нарийвчлан тусгажээ.

ЖДҮГ-аас ирсэн мэдээллээр 2024 онд нийт 826 ЖДҮҮЭ хөнгөлөлттэй зээлд хамрагдах хүсэлт ирүүлснээс 387 буюу 46.8% нь дээрх хууль, журмын шалгуурыг хангасан байна.

Ярилцлагад хамрагдсан ЖДҮҮЭ-ийн дийлэнх нь жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас санхүүжилт хүсэхэд хамгийн хүндрэл үүсгэдэг шалгуур нь төсөл хүлээн авах сүүлийн өдрийн байдлаарх нийгмийн даатгал, татварын байгууллагад өртэй байх гэсэн бол зарим нь зээлийн муу түүх гэж хариулжээ.

Шигтгээ.

- *Нийгмийн даатгал, татварын өртэй байх нөхцөл (5) хамгийн их хүндрэл учруулдаг. Өргүй байж л зээл авдаг. Өргүй ЖДҮ бараг байхгүй, зээл аваад өрөө төлдөг тул энэ шалгуур байхгүй бол зүгээр санагдсан. Энэ нь ЖДҮ эрхлэгчдэд том дарамт болдог. (ЖДҮҮЭ-1)*
- *Ер нь (2) дугаар заалт хэцүү. Муу зээлийн түүх үүсэх шалтгаан олон байдаг. Тухайлбал, үнийн өсөлт, барааны хомстол. (3) байх ёстой. (4) байж болно. (5) бол ААН бүрийн зовлон шүү дээ. (ЖДҮҮЭ-9)*

2.4.6. Төслийн сонгон шалгаруулалтад хөндлөнгөөс оролцох (§11.12-§11.13)

Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуулийн 11 дүгээр зүйлд зээлийн эх үүсвэрээр хэрэгжүүлэх төслийн талаар санал, дүгнэлт гаргах, сонгон шалгаруулалт явуулах, шийдвэр гаргахад аливаа этгээд хөндлөнгөөс нөлөөлөхийг хориглох (§11.12) бөгөөд албан үүргээ гүйцэтгэхэд нь хөндлөнгөөс нөлөөлсөн гэж үзвэл тухайн албан тушаалтан Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасны дагуу эрх бүхий байгууллага, албан тушаалтанд мэдэгдэх үүрэгтэй (§11.13) гэж заасан байна.

ЖДҮГ-аас зээлийн эх үүсвэрээр хэрэгжүүлэх төслийн талаар санал, дүгнэлт гаргах, сонгон шалгаруулалт явуулах, шийдвэр гаргах үүрэг гүйцэтгэж буй албан хаагчдад зөвлөгөө мэдээлэл өгөх, Авлигатай тэмцэх газраас зөвлөмж хүсэх, Төсөл сонгон шалгаруулалтын ажлын хэсгийн гишүүдээр “Ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл” болон “Төрийн болон албаны нууцыг задруулахгүй байх баталгаа”-г тухай бүрд баталгаажуулан ажилладаг байна. Мөн төсөл сонгон шалгаруулах зарыг олон нийтэд нээлттэй зарлаж, төрийн байгууллагын 3, төрийн бус байгууллагын 4

гишүүний бүрэлдэхүүнтэйгээр сонгон шалгаруулалтын хурлыг нээлттэй, ил тод олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон цахим хуудсаар хороо, дэд хорооны хурлыг дамжуулан хүргэж, шалгарсан аж ахуйн нэгжүүдийг www.shilen.gov.mn сайтад байршуулж ажилладаг байна.

Энэ хүрээнд Авлигатай тэмцэх газраас тодруулга мэдээлэл авахад хууль хэрэгжиж эхэлснээс хойш буюу 2019-2024 оны хугацаанд Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуулийн хүрээнд ЖДҮ хөгжүүлэх сангийн эх үүсвэрээр хэрэгжүүлэх төслийн талаар санал, дүгнэлт гаргах, сонгон шалгаруулалт явуулах, шийдвэр гаргах үйл ажиллагаатай холбоотойгоор гэмт хэргийн шинжтэй нийт 24 гомдол, мэдээлэл бүртгэгдсэнээс 11 гомдолд хэрэг бүртгэлийн хэрэг нээхээс татгалзах саналтай прокурорт шилжүүлж, 13 гомдолд хэрэг бүртгэлийн хэрэг нээн шалгаж, шийдвэрлэсэн байна.

Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулах байгууллага нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 29.3 дугаар зүйлд зааснаар хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын төлөвлөлт, явц, үр дүнгийн нууцлалыг хангах ажиллах үүрэгтэй тул дэлгэрэнгүй мэдээлэл өгөх боломжгүй талаар мэдэгдсэн юм.

Ярилцлагын үр дүн

Төслийн сонгон шалгаруулалт ил тод, шударга явагдаж байгаад зарим ЖДҮҮЭ-д санал нийлсэн ч, зарим ЖДҮҮЭ-ийн хувьд итгэл бүрэн сэргээгүй, эргэлзээ хэвээр байгаа нь ажиглагдлаа.

Шигтгээ.	
	- Өмнө нь ЖДҮ-ийн зээл арын хаалгаар олддог гэж их сонсдог байсан тул хүсэлт өгч байгаагүй, өндөр хүүтэй банкны зээл авч явдаг байсан. BEST хөтөлбөрт хамрагдаж, сүүлийн 2-3 жил мэдээлэл авч, шалгаруулалт шударга явагддаг гэдгийг ойлгосон. 2024 онд оролцоход шударга болсон гэж үзэж байна, учир нь зээл авсан компаниуд бүгд танил, үзэсгэлэн худалдаанд хамт оролцдог, жижиг дунд үйлдвэрлэгч нар байсан. 2023 оны Экспортыг дэмжих төсөлд хамрагдахад ч шударга байсан. Өөрсдөө зээл авч чадсан тул төрөөс биднийг дэмжсэн гэж үзэж байна. (ЖДҮҮЭ-1) - Шударга, ил тод биш гэж боддог. Ер нь ЖДҮ эрхлэгчид хоорондоо “материалаа өгсөн ч сонгон шалгаруулдаг хүмүүс нь өөрсдөдөө ашигтайгаар шийддэг” гэж ярьдаг. Тийм зүйл байхыг үгүйсгэхгүй. Бид өөрсдөө хамрагдаж чадаагүй. (ЖДҮҮЭ-2) - 2023, 2024 онд их бүрхэг байсан. Би бусад хүмүүст төсөл бичихэд нь тусалдаг. Энэ жил Төв, Дархан, Сэлэнгэ аймгийн сонгон шалгаруулалтыг харсан. Урьд нь юу болж байгаа нь мэдэгдэхгүй таг алга болчихдог байсан. Энэ жилийн хувьд хүнд сурталгүй, явц юу болж байгаа талаар цаг тухайд нь хурдан хариу өгдөг, мэдээлэл илүү ил тод болсон байна. (ЖДҮҮЭ-3) - Шударга гэж бодохгүй байна. Тухайн үед (2010 он) яамны мэргэжилтэн “хувь өгвөл бүтээж өгнө” гэж байсан. (ЖДҮҮЭ-5)

2.4.7. Сангаас хөнгөлөлттэй зээл олгоход харгалзан үзэх шалгуур үзүүлэлт (§11.14)

Сангаас хөнгөлөлттэй зээл олгох, төсөл сонгон шалгаруулахад жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчийг Хөдөлмөрийн тухай хуулийн 111.1, 111.2-т заасныг хэрэгжүүлсэн эсэхийг харгалзан үзнэ гэж тусгажээ. Гэвч Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулга 2021 оны 07 дугаар сарын 21-ний өдөр батлагдаж, 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөгдөж эхэлсэн байна. Гэвч Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.14 дэх хэсэгт эшилсэн Хөдөлмөрийн тухай хуулийн зүйл,

хэсгийн дугаарыг өөрчлөн найруулаагүй байгаа нь хууль хэрэгжүүлэгчдэд ойлгомжгүй байдлыг үүсгэж байна.

Хүснэгт 11. Хөдөлмөрийн тухай хуулийн зохицуулалт

Жижиг, дунд үйлдвэр үйлчилгээг дэмжих тухай хууль (2019.06.06)	Хөдөлмөрийн тухай хууль (2022.01.01-ний өдрөөс эхлэн хүчингүй болгосон)	Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулга (2022.01.01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсөн)
11.14. Сангаас хөнгөлөлттэй зээл олгох, төсөл сонгон шалгаруулахад жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчийг Хөдөлмөрийн тухай хуулийн 111.1, 111.2-т заасныг хэрэгжүүлсэн эсэхийг харгалзан үзнэ.	111.1. 25, түүнээс дээш ажилтантай аж ахуйн нэгж, байгууллага нь ажил, албан тушаалынхаа дөрөв, түүнээс дээш хувийн орон тоонд хөгжлийн бэрхшээлтэй буюу одой хүнийг ажиллуулна. 111.2. Аж ахуйн нэгж, байгууллага энэ хуулийн 111.1-д заасан хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй буюу одой хүн ажиллуулаагүй бол ажиллуулбал зохих орон тоо тутамд сар бүр төлбөр төлнө.	111.1. Ажлын бүтэн бус цагийн ажилтны цагаар болон хийснээр тооцох цалингийн нэгжийн үнэлгээ нь ижил ажлын байранд бүтэн цагаар ажилладаг ажилтныхаас багагүй байна. 111.2. Ажлын бүтэн бус цагийн ажилтны цалин хөлсийг гүйцэтгэсэн ажлын хэмжээ, эсхүл ажилласан цагаар нь тооцож ажилтантай тохиролцсон хугацаанд олгоно.

Иймд Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуулийн 11.14 дэх хэсгийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх боломжгүй байна.

2.4.8. Төсөл сонгон шалгаруулсан шийдвэрийг нээлттэй мэдээлэх, зээлийн гэрээний биелэлтэд тавих хяналт (§11.15-§11.16)

Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.15 дахь хэсэгт “Сан төсөл сонгон шалгаруулсан шийдвэрийг тухайн шийдвэр гарснаас хойш Сангийн албан ёсны цахим хуудас болон өдөр тутмын хэвлэлээр ажлын 5 өдрийн дотор нийтэд мэдээлнэ.”, 11.16 дахь хэсэгт “Сан нь зээлийн болон дамжуулан зээлдүүлэх гэрээний биелэлтэд хяналт тавина.” гэж тус тус заасан байдаг.

ЖДҮГ нь төсөл сонгон шалгаруулалтын хурлыг нээлттэй, олон нийтийн сүлжээгээр шууд дамжуулж олон нийтэд хүргэж, байгууллагын хуудаст төслийн сонгон шалгаруулах хурлын үйл явцыг www.sme.gov.mn цахим хуудаст ААНБ-ын бүртгэлийн кодоор оноог шууд байршуулж танилцуулах, шалгарсан аж ахуйн нэгжүүдийг www.shilen.gov.mn цахим хуудаст байршуулах ажлыг гүйцэтгэж олон нийтэд ил тод мэдээлдэг.

Түүнчлэн хөнгөлөлттэй зээлд хамрагдсан жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгч аж, ахуйн нэгжтэй байгуулсан гэрээнд зааснаар төсөл хэрэгжүүлэгч нь дараа жилийн тайлант хугацаанд зарцуулалтын тайланг ирүүлэх, тооцоо нийлэх, зөрчил өр төлбөр үүсгэхгүй гэрээний үүргээ хангаж байгаа эсэхэд ЖДҮГ-аас тогтмол хяналт тавьж ажилладаг байна. Мөн ЗГ-ын 2020 оны 113 дугаар тогтоолоор батлагдсан “Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, дамжуулан зээлдүүлэх, эргэн төлүүлэх, хяналт тавих журам”-ын 16.2-т зааснаар ЖДҮГ нь жилд нэгээс доошгүй удаа зээлийг зориулалтын дагуу зарцуулж байгаа эсэхэд иж бүрэн эсхүл түүвэрчлэн хяналт, шалгалт хийдэг байна.

Харин www.shilen.gov.mn цахим хуудаст байршуулсан Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас 2020-2024 онд олгосон зээлийн мэдээлэлд чанаргүй зээлийн ангилал (хугацаа хэтэрсэн, хэвийн бус, эргэлзээтэй, муу зээл)-д орсон нийт 308 зээлдэгч байна.

Хүснэгт 12. Чанаргүй зээлийн ангилалд орсон ЖДҮҮЭ-ийн тоон мэдээлэл

Он	Зээл олгосон ЖДҮҮЭ-ийн тоо	Чанаргүй ангилалд ЖДҮҮЭ-ийн тоо	зээлийн орсон	Нийт дүнд эзлэх хувь
2020	249	101		41%
2021	12	4		33%
2022	156	68		44%
2023	265	77		29%
2024	278	58		21%

Эх сурвалж: (Шил ажиллагаа, 2025)

Чанаргүй зээлийн ангилалд орсон зээлдэгчдийн тоо 2021 онтой харьцуулахад 2024 онд 2 дахин буурсан эерэг үзүүлэлттэй байна. Гэсэн хэдий ч тодорхой хэмжээний зөрчил байгаа нь эрсдэлийн удирдлагын тогтолцоо, хяналтын механизмыг сайжруулах шаардлага байгааг харуулж байна.

ГУРАВ. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуулийн гурав дугаар бүлэг буюу Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих төрийн бодлогод хийсэн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээнээс дараах дүгнэлт, зөвлөмжийг хүргүүлж байна.

3.1. Дүгнэлт

Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих төрийн бодлогын зарим зүйл, заалтын хэрэгжилт тодорхой ахиц дэвшил гарч, үр нөлөө үзүүлж байгаа хэдий ч дэмжлэгийн тогтолцоо бүрэн хөгжөөгүй, зарим талаараа үр дүнгүй байсаар байна.

Хүснэгт 13. Хуулийн зүйл, заалтын хэрэгжилтийн үнэлгээ

Хуулийн заалт	Хэрэгжилт	Хэрэгжилтийн үнэлгээ
8 дугаар зүйл. Төрөөс жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих талаар баримтлах бодлогын чиглэл		
§8.1.1	2019-2024 онд ЖДҮҮЭ аж ахуйн нэгжийн хүний нөөцийн чадавхыг нэмэгдүүлэх, сургах, давтан сургах чиглэлээр нийт 404 сургалт зохион байгуулж, давхардсан тоогоор 197 мянга гаруй ЖДҮҮЭ-д хамрагдсан байна. Зохион байгуулсан сургалтын тоо болон хамрагдсан оролцогчдын тоо өссөн үзүүлэлттэй байгаа хэдий ч бодит хэрэгжилтийн хувьд ЖДҮҮЭ-дийн тус дэмжлэгийн талаарх мэдээлэл, ойлголт хангалтгүй хэвээр байна. Мөн ЖДҮҮЭ-д сургалтаас хэрэгцээт мэдлэг, ур чадварыг бүрэн эзэмшиж чадахгүй байгаа нь жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээний зах зээлийн эрэлт, хэрэгцээ шаардлагыг үндэслэн хүний нөөцийн чадавхыг нэмэгдүүлэх, сургах, давтан сургах тогтолцоог бүрэн хөгжөөгүй байна.	хангалтгүй
§8.1.2.а	2020-2024 онд ЖДҮҮЭ-ээс хөнгөлөлттэй зээлд хамрагдахаар нийт 572.8 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 3,865 төслийн саналыг ирүүлсэн байна. Үүнээс 116.5 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг 960 төсөлд олгосон байна. Хэдийгээр 2020 онтой харьцуулахад 2024 онд олгосон зээлийн хэмжээ өссөн үзүүлэлттэй байгаа ч сангийн эх үүсвэрийн хязгаарлагдмал байдлаас шалтгаалан зөвхөн бичил бизнес эрхлэгчдэд зээл олгож, жижиг болон дунд ангиллын бизнес эрхлэгчид орхигдож, зорилтот бүлгийг бүрэн хамруулж чадаагүй байна.	хангалтгүй
§8.1.2.в	Зээлийн батлан даалтын сангаас 2019-2024 онд нийт 749 ЖДҮҮЭ-ийн 346 тэрбум төгрөгийн зээлд 184.3 тэрбум төгрөгийн батлан даалт гаргасан байна.	биелсэн
§8.1.2.д	Мал хамгаалах сангаас шилжин ирсэн 659.9 сая төгрөгийн үнэ бүхий 116 ширхэг тоног төхөөрөмжийг ЖДҮҮЭ-дэд санхүүгийн түрээсийн гэрээгээр хүүгүй олгосон байна. Энэ нь Мал хамгаалах сангаас шилжин ирсэн тоног төхөөрөмжөөр хязгаарлагдаж, нэг удаагийн шинж чанартай, тогтворгүй хэлбэрээр хэрэгжсэн.	хангалтгүй
§8.1.2.б, §8.1.2.г	Шинээр бий болгосон ажлын байрны тоо, борлуулалтын орлогын хэмжээг харгалзан зээлийн хүүгийн хэмжээг бууруулах болон зээлийн хүүгийн татаас олгох зэрэг дэмжлэгүүд нь огт хэрэгжээгүй нь төрөөс үзүүлэх санхүүгийн дэмжлэгийн бодит үр нөлөөг үнэлэх боломжийг бууруулж байна.	биелээгүй
§8.1.3	Хууль хэрэгжиж эхэлснээс хойш татварын хөнгөлөлт, чөлөөлөлтөд хамрагдаж буй ЖДҮҮЭ-ийн тоо тогтмол өсөж, 2024 оны байдлаар нийт 11,110 ЖДҮҮЭ татварын хөнгөлөлт, чөлөөлөлтөд хамрагдсан байна. Энэ үзүүлэлт нь 2024 оны нийт ЖДҮҮЭ-ийн 13%-ийг эзэлж	хангалтгүй

	байна. Гэвч ярилцлагад хамрагдсан ЖДҮҮЭ-д бүгд энэ дэмжлэгийн талаар огт мэдэхгүй байгаа нь мэдээллийн хүртээмж сул байгааг харуулж байна. Энэ нь ЖДҮҮЭ-ийн татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн дэмжлэгийн бодит хэрэглээ, оролцоог хязгаарлаж байна.	
§8.1.4	Экспортыг нэмэгдүүлэх, импортыг орлох өрсөлдөх чадвартай бүтээгдэхүүний үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжих ажлын хүрээнд Дэлхийн банкны санхүүжилтээр хэрэгжсэн “Экспортыг дэмжих төсөл”-өөс 2022 онд 9,6 тэрбум төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг 54 аж ахуйн нэгжид олгосон байна. Энэ нь нэг удаагийн арга хэмжээгээр хязгаарлагдсан, урт хугацааны тасралтгүй үйл ажиллагааг хангаж чадаагүй тул хэрэгжилт хангалтгүй гэж үзэж байна.	хангалтгүй
§8.1.5	ЖДҮГ-аас дотоодын үйлдвэр эрхлэгчдийг төрийн худалдан авалтаар дэмжих, төрийн болон орон нутгийн өмчийн байгууллагуудтай холбох, бараа бүтээгдэхүүнийг танилцуулах зорилготой зохион байгуулсан 3 удаагийн арга хэмжээнд нийт 632 ЖДҮҮЭ (нийт ЖДҮҮЭ-ийн 0.8%), 194 төрийн байгууллага оролцсон. Харин ТБОНӨХБАҮАТ хуулийн зохицуулалтын хүрээнд 2024 онд 417 бараа нийлүүлэх тендер шалгаруулалт тодорхой нөхцөл хангасан ЖДҮҮЭ-д оролцсон бөгөөд энэ нь тухайн онд зарлагдсан бараа нийлүүлэлтийн тендер шалгаруулалтын 4.6%-ийг эзэлж байна. Иймд энэ заалтын бодит хэрэгжилт хангалтгүй, нийт ЖДҮҮЭ-дэд чиглэсэн бодлогын зохицуулалт шаардлагатай байгааг харуулж байна.	хангалтгүй
§8.1.6, §8.1.7	Бизнесийн зөвлөх үйлчилгээ үзүүлэх заалтын хүрээнд ЖДҮҮЭ-ийн санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх сургалтыг 21 аймагт зохион байгуулж, танхимаар 840, цахимаар 450 нийт 1300 орчим ЖДҮҮЭ хамрагдсан байна. Харин шинэ бүтээгдэхүүн хөгжүүлэх, бүтээмжийг нэмэгдүүлэх судалгааг дэмжих (§8.1.6), техник, технологийн дэвшлийг дамжуулах, нутагшуулах, шинжлэх ухаан, технологийн судалгааны үр дүнг үйлдвэрлэлд нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэх (§8.1.7) зэрэг заалтын хэрэгжилт нийтлэг сургалт, зөвлөгөөн, хэлэлцүүлэг, үзэсгэлэн яармаг зэргээр хязгаарлагдаж байгаа нь эдгээр дэмжлэгийн урт хугацааны тогтвортой хөгжлийг хангах бодлогын орчин бүрдээгүй байгааг харуулж байна.	хангалтгүй
§8.1.10	Гадаад, дотоод зах зээлд нэвтрэхэд дэмжлэг үзүүлэх чиглэлээр 2020-2024 онд 9 улсад 20 удаагийн үзэсгэлэн, арга хэмжээг зохион байгуулж 930 гаруй ЖДҮҮЭ-д оролцсон. Харин дотоодын зах зээлийг тэлэх, борлуулалтыг нэмэгдүүлэх чиглэлээр 17 үзэсгэлэн, арга хэмжээ зохион байгуулж 1700 гаруй ЖДҮҮЭ хамрагдсан байна. Эдгээр арга хэмжээ жил бүр тогтмол зохион байгуулагддаг болсон нь ЖДҮҮЭ-ийн бүтээгдэхүүнээ танилцуулах, зах зээлд нэвтрэх сувгийг өргөжүүлэхэд эерэг нөлөө үзүүлж байна.	биелсэн
9 дүгээр зүйл. Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээний кластерыг дэмжих, §8.1.9-дэх заалт		
	Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг кластераар хөгжүүлэхэд төрөөс үзүүлэх дэмжлэгийн хүрээнд кластерын бодлогын чиг хандлагын судалгаа, Монгол улсын бүс нутгийн онцлог хүчин зүйлсийг тусгасан стратегийн хөдөө аж ахуйн нэмүү өртгийн сүлжээг хөгжүүлэх Мастер төлөвлөгөө (2025-2034), холбогдох дүрэм, журамд өөрчлөлт оруулах зэргээр тодорхой түвшний бодлогын сайжруулалт хийгдэж байгаа ч “Кластераар бүсчилэн хөгжүүлэх чиглэл”, “Кластерын ангилал тооцох журам” зэрэг шаардлагатай баримт бичгүүд одоог хүртэл батлагдаагүй хэвээр байна. Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээний кластерыг дэмжих бодит дэмжлэгийн механизм бүрдээгүй, дэмжлэгийн арга хэмжээ авч хэрэгжүүлээгүй зэрэг шалтгаанаар зүйлийн хэрэгжилт бүхэлдээ хангалтгүй, зорилгодоо хүрээгүйг харуулж байна.	биелээгүй
10 дугаар зүйл. Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөр		

	ЖДҮҮ-ийг дэмжих болон ахуйн үйлчилгээний үндэсний хөтөлбөрүүд хэрэгжсэн боловч цаашид хөгжлийн бодлогын тухай хуультай нийцүүлэн өөрчлөх шаардлагатай.	хангалттай
11 дүгээр зүйл. Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан		
§11.1- §11.2	ЖДҮГ нь жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих үйл ажиллагаанд шаардагдах хөрөнгийг санхүүжүүлэх зорилго бүхий Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн үйл ажиллагааг хариуцан ажиллаж байна.	биелсэн
§11.3- §11.4	Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх санд 2020-2024 онд нийт 132.9 тэрбум төгрөг төвлөрсөн байна. Үүнийг эх үүсвэрээр нь ангилан авч үзвэл 78.3% буюу 104 тэрбум төгрөгийг зээлийн эргэн төлөлт, үлдсэн 21.7% буюу 28.9 тэрбум төгрөгийг бусад эх үүсвэрээс бүрдүүлжээ. Харин тус хугацаанд санд улсын төсвөөс санхүүжилт олгогдоогүй байна. Харин сангийн хөрөнгийн зарцуулалт зөвхөн хөнгөлөлттэй зээлийн олголтоор хязгаарлагдаж байна. Хэдийгээр хөнгөлөлттэй зээл нь ЖДҮҮЭ-д шинээр үйлвэр, үйлчилгээ эхлүүлэх, өргөтгөн шинэчлэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг ч, сангийн хөрөнгөөр санхүүжих бусад дэмжлэгийн хэрэгжилтэд сөргөөр нөлөөлж байна.	хангалтгүй
§11.5, §11.7	ЗГ-ын 2020 оны 113 дугаар тогтоолоор “Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, дамжуулан зээлдүүлэх, эргэн төлүүлэх, хяналт тавих журам” батлагдаж сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, бүхий л харилцааг зохицуулж байна. Тус журам батлагдсанаар хуулийн §11.5, §11.7 дахь хэсгүүд зорилгодоо хүрч хэрэгжсэн байна.	биелсэн
§11.8- §11.10	“Экспортод бүтээгдэхүүнээ гаргасан дунд ангиллын үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдэд зээлийн хүүгийн татаас олгох, хяналт тавих журам”-ын төслийг боловсруулсан боловч одоог хүртэл батлагдаагүй байгаа нь тус хэсэгт тодорхойлсон зорилгод хүрээгүй гэж үзэж байна.	биелээгүй
§11.11	Зээл авах төслийн шаардлага ЖДҮ-д хүндрэл учруулсан. Татвар, НД-ын өртэй байх асуудал тулгарсан.	хангалтгүй
§11.12- §11.13	Зээлийн эх үүсвэрээр хэрэгжүүлэх төслийн талаар санал, дүгнэлт гаргах, сонгон шалгаруулах хороо нь найман хүний бүрэлдэхүүнтэй байх бөгөөд үүнээс дөрөв нь төрийн бус байгууллага, мэргэжлийн байгууллагын төлөөлөл байх зохицуулалттай байна. Харин зарим ЖДҮҮЭ-ийн хувьд шударга, ил тод явагдаж байгаа эсэхэд эргэлзсэн хэвээр байна. Түүнчлэн АТГ-аас ирүүлсэн мэдээллээр дээрх асуудлын хүрээнд 2019-2024 онд нийт 24 гомдол, мэдээлэл бүртгэгдсэн нь тодорхой хэмжээнд зээлийн эх үүсвэрээр хэрэгжүүлэх төслийн сонгон шалгаруулалт явуулах, шийдвэр гаргахад хөндлөнгөөс нөлөөлөх оролдлого гарч байж болзошгүйг илтгэж байна.	хангалтгүй
§11.14	Сангаас хөнгөлөлттэй зээл олгох, төсөл сонгон шалгаруулахад харгалзан үзэх Хөдөлмөрийн тухай хуулиас эшилсэн заалтыг Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгатай уялдуулаагүйгээс хэрэгжилтийг үнэлэх боломжгүй нөхцөл үүссэн.	үнэлэх боломжгүй
§11.15- §11.16	ЖДҮГ нь жилд нэгээс доошгүй удаа зээлийг зориулалтын дагуу зарцуулж байгаа эсэхэд иж бүрэн эсхүл түүвэрчлэн хяналт, шалгалт хийдэг байна. Харин чанаргүй зээлийн ангилалд орсон зээлдэгчдийн тоо 2021 онтой харьцуулахад 2024 онд 2 дахин буурсан эерэг үзүүлэлттэй байна. Гэсэн хэдий ч тодорхой хэмжээний зөрчил байгаа нь эрсдэлийн удирдлагын тогтолцоо, хяналтын механизмыг сайжруулах шаардлага байгааг харуулж байна.	биелсэн

3.2.Зөвлөмж

№	Үнэлгээний хамрах хүрээ	Санал, зөвлөмж
1	8 дугаар зүйл. Төрөөс жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих талаар баримтлах бодлогын чиглэл 8.1.1. жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээний зах зээлийн эрэлт, хэрэгцээ шаардлагыг үндэслэн жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээний салбарын хүний нөөцийн чадавхыг нэмэгдүүлэх, сургах, давшан сургах тогтолцоог хөгжүүлэх;	- Сургалт хөгжлийн эрэлт, хэрэгцээг тодорхойлох тандан судалгаанд тулгуурлан зохион байгуулах; - Төрөөс жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих талаар баримталж буй бодлого дэмжлэгийн талаар ЖДҮҮЭ-ийн бүртгэлийн системээр дамжуулан мэдээллийг тогтмол хүргэх; - Сургалтын чанарын үнэлгээ хийх тогтолцоо бий болгох, үр дүнд суурилсан сургалт зохион байгуулах.
2	8 дугаар зүйл. Төрөөс жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих талаар баримтлах бодлогын чиглэл 8.1.2. санхүүгийн дараах дэмжлэгийг үзүүлэх: 8.1.2.б. шинээр бий болгосон ажлын байрны тоо, борлуулалтын орлогын хэмжээг харгалзан зээлийн хүүгийн хэмжээг бууруулах; 8.1.2.в. зээлийн давхар батлан даалт гаргах; 8.1.2.д. тоног төхөөрөмжийн санхүүгийн түрээсийн үйлчилгээ, түрээсийн хүүгийн дэмжлэг үзүүлэх.	- Санхүүгийн дэмжлэгийн талаарх мэдлэг, ойлголт, хэрхэн хамрагдах талаар ЖДҮҮЭ-дэд мэдээлэл хүргэх арга хэмжээг тогтмол зохион байгуулах; - Төрөөс үзүүлэх санхүүгийн дэмжлэгийн санхүүжилтийн эх үүсвэрийг тодорхой заах, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг дэмжих. - Шинээр бий болгосон ажлын байрны тоо, борлуулалтын орлогын хэмжээг харгалзан зээлийн хүүгийн хэмжээг бууруулах арга хэрэгслийг тодорхой заах, нарийвчлан зохицуулах, эсхүл журмаар зохицуулах. - Тус заалтыг Зээлийн батлан даалтын сангийн тухай хуультай нийцүүлэн өөрчлөн найруулах. - Тоног төхөөрөмжийн түрээсийг тогтмол үйл ажиллагаа болгон, тоног төхөөрөмжийг төрөлжүүлэх, олон салбарт хүргэх; - Тоног төхөөрөмжийн түрээсийн үйлчилгээг түрээсийн хүүгийн тодорхой хувийг татаас хэлбэрээр олгох замаар хувийн хэвшилтэй хамтран хэрэгжүүлэх.

	8.1.3. татварын хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлэх;	- ЖДҮҮЭ-дэд татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн талаарх мэдээллийн хүртээмжийг сайжруулах; - Нийт ЖДҮҮЭ-дэд чиглэсэн татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн бодлогыг хэрэгжүүлэх.
3	8.1.4.экспортыг нэмэгдүүлэх, импортыг орлох өрсөлдөх чадвартай бүтээгдэхүүний үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжих;	- Агуулгын давхардлыг арилгах үүднээс зорилго, үр дүн ижил заалтуудыг нэгтгэх. Тухайлбал, “экспортыг нэмэгдүүлэх, импортыг орлох өрсөлдөх чадвартай бүтээгдэхүүний үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжих” болон “гадаад, дотоод зах зээлд нэвтрэхэд дэмжлэг үзүүлэх”; - Экспортыг нэмэгдүүлэх, импортыг орлох өрсөлдөх чадвартай бүтээгдэхүүний үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжих арга замыг тодорхойлох.
	8.1.5.бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний борлуулалтад төрийн худалдан авалтаар дэмжлэг үзүүлэх;	- ТБОНӨХБАҮХАТ хуулиар нийт ЖДҮҮЭ-д чиглэсэн төрийн худалдан авалтаар дэмжих зохицуулалтыг оруулах арга хэмжээг авч хэрэгжүүлэх; - ЖДҮҮЭ-дийн бараа, бүтээгдэхүүний нэгдсэн цахим бүртгэл бий болгож, төрийн худалдан авах ажиллагааны цахим системтэй холбох; - ЖДҮҮЭ-дэд зориулсан худалдан авах ажиллагааны талаарх зөвлөгөө мэдээлэл, сургалт арга хэмжээнүүдийг системтэйгээр хэрэгжүүлэх.
	8.1.6.бизнесийн зөвлөх үйлчилгээ үзүүлэх;	- Бизнесийн зөвлөх үйлчилгээг зөвхөн сургалтаар бус, зөвлөх үйлчилгээ, менторшигчийн хөтөлбөрөөр өргөжүүлэх.
	8.1.7. шинэ бүтээгдэхүүн хөгжүүлэх, бүтээмжийг нэмэгдүүлэх судалгааг дэмжих;	- Инноваци, техник технологийг дамжуулах, нутагшуулах шинжлэх ухаан технологийн судалгааг үйлдвэрлэлтэй холбосон “судалгаа-үйлдвэрлэл-зах зээл” гурвалсан механизмыг бий болгох; - Төр хувийн хэвшлийн түншлэлд тулгуурлан дээрх механизмыг хэрэгжүүлэх.
	8.1.10.гадаад, дотоод зах зээлд нэвтрэхэд дэмжлэг үзүүлэх.	

	9 дүгээр зүйл. Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээний кластерыг дэмжих; 8 дугаар зүйл. Төрөөс жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих талаар баримтлах бодлогын чиглэл; 8.1.9. кластерын хэлбэрээр үйл ажиллагаа явуулдаг жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг эрхлэгчийг тухайн орон нутаг дахь түүхий эдийн болон ажиллах хүчний нөөц, чадаах бусад онцлогоос хамааран дэмжих;	- Хөгжлийн бодлого, төлөвлөлт түүний удирдлагын тухай хууль, Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд нийцүүлэн "Кластераар бүсчлэн хөгжүүлэх чиглэл" болон "Кластерын ангилал тооцох журам"-ыг батлуулах; - Кластертраар үйл ажиллагаа эрхлэх аж ахуйн нэгжид татвар, санхүүгийн цогц дэмжлэг үзүүлэх, дэд бүтцийг сайжруулах тогтолцоог бүрдүүлэх, дээрх бодлогын баримт бичгүүдтэй уялдуулан журмаар нарийвчлан зохицуулах.
	10 дугаар зүйл. Жижиг, дунд үйлдвэр үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөр;	- Хөгжлийн бодлого, төлөвлөлт түүний удирдлагын тухай хуульд нийцүүлэн өөрчлөн найруулах.
	11 дүгээр зүйл. Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан. 11.3. Сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах, хянахтай холбогдсон харилцааг Засгийн газрын тусгай сангийн тухай хуулиар зохицуулна; 11.4. Санд Засгийн газрын тусгай сангийн сангийн тухай хуулийн 16.3-т заасны дагуу улсын төсвөөс жил бүр хөрөнгө хуваарилна.	- Сангийн эх үүсвэрийн хангалтгүй байдлаас хэрэгжилт хангалтгүй байгаа асуудлуудыг шийдвэрлэхэд шаардлагатай төсвийг холбогдох тооцоо, судалгаанд суурилан боловсруулж, жил бүрийн улсын төсөвт тусгуулах арга хэмжээг авч ажиллах; - Сангийн хөрөнгөд оновчтой хуваарилалт хийж, зөвхөн хөнгөлөлттэй зээлд бус, Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 16.6-д заасан арга хэмжээнүүдэд зарцуулах.
	11 дүгээр зүйл. Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан 11.8. Дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгч бүтээгдэхүүнээ экспортод гаргасан тохиолдолд банкнаас авсан зээлийн жилийн хүүгийн нь 5.0 хүртэл хувийг Сангаас олгож болно. 11.10. Энэ хуулийн 11.8-д заасны дагуу Сангаас зээлийн хүүгийн татаас олгох журмыг жижиг, дунд үйлдвэрийн болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална. 8 дугаар зүйл. 8.1.2.г. зээлийн хүүгийн татаас олгох;	- "Дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгч бүтээгдэхүүнээ экспортод гаргасан тохиолдолд банкнаас авсан зээлийн жилийн хүүгийн нь 5.0 хүртэл хувийг Сангаас олгож болно" гэсэн заалтыг Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.6.2 дахь заалттай нийцүүлэн өөрчлөн найруулах; - Сангаас зээлийн хүүгийн татаас олгох журмыг өөрчлөн найруулсан зохицуулалттай нийцүүлэн дахин боловсруулж, батлуулах. - Хууль хэрэгжүүлэгчдэд тодорхойгүй байдал үүсгэхгүй байх үүднээс "8.1.2.г. зээлийн хүүгийн татаас олгох" гэсэн заалтын өмнө "бүтээгдэхүүнээ экспортод гаргасан тохиолдолд" гэж нэмэлт өөрчлөлт оруулах

	11 дүгээр зүйл. Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан 11.11. Дараах жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчид хөнгөлөлттэй зээл олгохгүй: 11.11.1. Сангаас авсан зээлийн үлдэгдэлтэй; 11.11.2. зээлийн мэдээллийн санд муу зээлийн түүхтэй; 11.11.3. Сангаас авсан зээлийг зориулалтын бусаар ашигласан нь тогтоогдсон; 11.11.4. шүүхийн шийдвэрээр бусдад төлөх өртэй; 11.11.5. төсөл хүлээн авах сүүлийн өдрийн байдлаар нийгмийн даатгал, татварын байгууллагад өртэй.	- Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгохгүй байх шаардлагыг өнөөгийн нөхцөл байдалд нийцүүлэн уян хатан зохицуулалт хийх
	11 дүгээр зүйл. Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан 11.12. Зээлийн эх үүсвэрээр хэрэгжүүлэх төслийн талаар санал, дүгнэлт гаргах, сонгон шалгаруулалт явуулах, шийдвэр гаргахад аливаа этгээд хөндлөнгөөс нөлөөлөхийг хориглоно.	- Сонгон шалгаруулалтын ил тод байдлыг цахим системээр бүрэн хангах, хөндлөнгийн хяналтын оролцоог нэмэгдүүлэх.
	11 дүгээр зүйл. Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан 11.14. Сангаас хөнгөлөлттэй зээл олгох, төсөл сонгон шалгаруулахад жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчийг Хөдөлмөрийн тухай хуулийн 111.1, 111.2-т заасныг хэрэгжүүлсэн эсэхийг харгалзан үзнэ.	- Тус заалтыг Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгатай нийцүүлэн, өөрчлөн найруулах.

---000---

АШИГЛАСАН МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ

ЖДҮГ. (2025). 2025 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн 01/665 тоот албан бичгээр ирүүлсэн тайлан .

ЖДҮҮЭ. (2025). ЖДҮГ, Монголын инновацын холбоо ТББ хамтран зохион байгуулсан санал асуулга.

ЗБДС. (2025). Зээлийн батлан даалтын сангийн тайлан.

ТЕГ. (2025). 2025 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн 02/1706 тоот албан бичгээр ирүүлсэн тайлан.

ТХААГ. (2024). Худалдан авах ажиллагааны цахим системийн статистик. Хандах:
<https://www.tender.gov.mn/mn/statistics?year=2024>

ТХААГ. (2025). Төрийн худалдан авах ажиллагааны газрын тайлан.

ХХААХҮЯ. (2023). ХУУЛЬ ТОГТООМЖ, ЗАСГИЙН ГАЗРЫН ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ЯВЦАД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТОВЧ ТАНИЛЦУУЛГА. ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН ЯАМНЫ ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ГАЗАР. Хандах: <https://mofa.gov.mn/files/pdf-files/sbvvcnh8kh/64d2f09d78a6a4593d74ddb2.pdf>

ХХААХҮЯ. (2023). ХХААХҮЯ. Хандах: <https://mofa.gov.mn/files/pdf-files/ia5teo1b4n/66ac2ca5eb5a6a60df09dca5.pdf>

ХХААХҮЯ. (2025). Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас ирүүлсэн хуулийн хэрэгжилтийн тайлан.

Шил ажиллагаа. (2025). Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан. <https://shilen.gov.mn/open-data/medium-industry?id=65f9d367445b0e14312adb46>

ШУТС. (2025). 2025 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн 3/271 тоот албан бичгээр ирүүлсэн мэдээлэл

ДӨРӨВ.ХАВСРАЛТУУД

Хавсралт 1.Санал асуулга

Сайн байна уу. УИХ-ын Тамгын газрын харьяа Парламентын судалгаа, хөгжлийн хүрээлэнгээс “Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуулийн зарим зүйл заалтын хэрэгжилтийн үр дагаварын үнэлгээ”-г хийж байна. Та тус судалгаанд оролцсоноор жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдийг дэмжих тогтолцоог оновчтой болгох чиглэлд үнэтэй хувь нэмэр оруулах юм.

I. СУДАЛГААНД ОРОЛЦОГЧИЙН МЭДЭЭЛЭЛ

1. Таны харьяалал?

1. Улаанбаатар хот --- тус хариултыг сонгосон бол 2, 3 дугаар асуултыг алгасна.
2. Орон нутаг --- тус хариултыг сонгосон бол 4, 5 дугаар асуултыг алгасна.

2. Та аль аймагт ажиллаж байна вэ? (Зөвхөн нэг хариулт сонгоно)

№	Аймаг	№	Аймаг
1	Архангай	12	Орхон
2	Баян-Өлгий	13	Өвөрхангай
3	Баянхонгор	14	Өмнөговь
4	Булган	15	Сүхбаатар
5	Говь-Алтай	16	Сэлэнгэ
6	Говьсүмбэр	17	Төв
7	Дархан-Уул	18	Увс
8	Дорноговь	19	Ховд
9	Дорнод	20	Хөвсгөл
10	Дундговь	21	Хэнтий
11	Завхан		

3. Та аль, аль суманд ажиллаж байна вэ? (Бичгээр хариулна)

1. Аймгийн төв
2. _____ сум

4. Та аль дүүрэгт ажиллаж байна вэ? (Зөвхөн нэг хариулт сонгоно)

1. Багануур
2. Багахангай
3. Баянгол
4. Баянзүрх
5. Сонгинохайрхан
6. Сүхбаатар
7. Чингэлтэй
8. Хан-Уул
9. Налайх

5. Та дүүргийнхээ аль, аль хороог хариуцан ажиллаж байна вэ? (Тоогоор 1, 2, 3 гэх зэргээр тэмдэглэнэ)

1. _____

6. Таны албан тушаал? (Зөвхөн нэг хариулт сонгоно)

1. **Аймаг:** Жижиг, дунд үйлдвэр, хөнгөн, хоршоо, ахуйн үйлчилгээний асуудал хариуцсан мэргэжилтэн
2. **Сум:** Жижиг дунд үйлдвэрлэл хариуцсан мэргэжилтэн
3. **Дүүрэг:** Төсөл, мэдээлэл хариуцсан мэргэжилтэн
4. **Дүүрэг:** Хороод зохион байгуулалт хариуцсан мэргэжилтэн
5. **Дүүрэг:** Үйлдвэрлэл, судалгаа хариуцсан мэргэжилтэн
6. **Дүүрэг:** Өрхийн үйлдвэрлэл, судалгаа хариуцсан мэргэжилтэн
7. **Дүүрэг:** Сургалт, мэдээлэл хариуцсан мэргэжилтэн

8. Бусад: _____

II. ЖИЖИГ, ДУНД ҮЙЛДВЭР, ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭГЧДИЙГ ДЭМЖИХ ТӨРИЙН БОДЛОГО

7. Танайд иргэд, ААН-үүдээс аль нь хамгийн их дэмжлэг авах хүсэлт гаргадаг вэ? (Зөвхөн нэг хариулт сонгоно)

1. Бичил үйлдвэр, үйлчилгээ эрхлэгч (10 хүртэл ажилтантай, үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээний салбарт үйл ажиллагаа явуулдаг, жилийн 300.0 сая төгрөг хүртэл борлуулалтын орлоготой аж ахуйн нэгж)
2. Жижиг үйлдвэр, үйлчилгээ эрхлэгч (10-50 хүртэл ажилтантай, үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээний салбарт үйл ажиллагаа явуулдаг, жилийн 300.0 сая-1.0 тэрбум төгрөг хүртэл борлуулалтын орлоготой аж ахуйн нэгж)
3. Дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгч (50-200 хүртэл ажилтантай, үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээний салбарт үйл ажиллагаа явуулдаг, жилийн 1.0-2.5 тэрбум төгрөг хүртэл борлуулалтын орлоготой аж ахуйн нэгж)

8. Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчид ихэнх тохиолдолд ямар төрлийн дэмжлэг хүсдэг вэ? (3 хүртэлх хариулт сонгоно)

1. Хүний нөөцийн чадавхыг нэмэгдүүлэх, сургах, давтан сургалт
2. Санхүүгийн дэмжлэг
3. Татварын хөнгөлөлт, чөлөөлөлт авах
4. Экспортыг нэмэгдүүлэх, импортыг орлох өрсөлдөх чадвартай бүтээгдэхүүний үйлдвэрлэл, үйлчилгээний дэмжлэг
5. Бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний борлуулалтад төрийн худалдан авалтаар дэмжлэг авах
6. Бизнесийн зөвлөх үйлчилгээ
7. Шинэ бүтээгдэхүүн хөгжүүлэх, бүтээмжийг нэмэгдүүлэх судалгааны
8. Техник, технологийн дэвшлийг дамжуулах, нутагшуулах, шинжлэх ухаан, технологийн судалгааны үр дүнг үйлдвэрлэлд нэвтрүүлэхэд дэмжлэг авах
9. Кластерын хэлбэрээр үйл ажиллагаа явуулдаг жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчийг тухайн орон нутаг дахь түүхий эдийн болон ажиллах хүчний нөөц, чадавх бусад онцлогоос хамааран дэмжлэг авах
10. Гадаад, дотоод зах зээлд нэвтрэхэд дэмжлэг авах
11. Дотоодын болон олон улсын үзэсгэлэн худалдаа зохион байгуулах, оролцоход дэмжлэг авах

III. СУРГАХ, ДАВТАН СУРГАХ ТОГТОЛЦООНЫ ДЭМЖЛЭГ

9. Төрөөс ЖДҮ эрхлэгчдийн ур чадварыг хөгжүүлэх сургалт, давтан сургалт зохион байгуулдаг талаар иргэд, ААН-үүд хэр зэрэг мэдлэг, ойлголттой байдаг вэ? (Зөвхөн нэг хариулт сонгоно)

- | | |
|---------------|------------------|
| 1. Маш муу | 4. Сайн |
| 2. Муу | 5. Маш сайн |
| 3. Дунд зэрэг | 6. Хэлж мэдэхгүй |

10. Танай аймаг/сум/дүүргийн түвшинд 2024 онд хэдэн удаа ЖДҮ эрхлэгчдийн ур чадварыг хөгжүүлэх сургалт зохион байгуулсан бэ? (Зөвхөн нэг хариулт сонгоно) --- Хэрэв олон сум, хороог хариуцдаг бол нийтэд нь тооцно.

- | | |
|-------------------|---------------------|
| 1. 5 хүртэлх удаа | 4. 16-20-н удаа |
| 2. 6-10-н удаа | 5. 20-оос дээш удаа |
| 3. 11-15-н удаа | |

11. Танай аймаг/сум/дүүргийн хэдэн хүн 2024 онд ЖДҮ эрхлэгчдийн ур чадварыг хөгжүүлэх сургалтад хамрагдсан бэ? (Зөвхөн нэг хариулт сонгоно) --- Хэрэв олон сум, хороог хариуцдаг бол нийтэд нь тооцно.

- | | |
|-------------------|---------------------|
| 1. 50 хүртэлх хүн | 4. 151-200 хүн |
| 2. 51-100 хүн | 5. 201-ээс дээш хүн |
| 3. 101-150 хүн | |

12. Таны бодлоор ЖДҮ эрхлэгчдийн ур чадварыг хөгжүүлэх сургалтаас иргэд, ААН-үүд өөрт хэрэгцээ шаардлагатай чадварыг эзэмшиж чаддаг уу? (Зөвхөн нэг хариулт сонгоно) --- 4, 5, 6 дугаар хариултыг сонгосон бол 13 дугаар асуултыг алгасна.

- | | |
|--------------------|------------------|
| 1. Огт чаддаггүй | 4. Ер нь чаддаг |
| 2. Ер нь чаддаггүй | 5. Бүрэн чаддаг |
| 3. Дунд зэрэг | 6. Хэлж мэдэхгүй |

13. ЖДҮ эрхлэгчдийн ур чадварыг хөгжүүлэх сургалтаас иргэд, ААН-үүд өөрт шаардлагатай чадварыг эзэмшиж чаддаггүй шалтгаан нь юу вэ? (Хэдэн ч хариулт сонгож болно)

1. Сургалтын хэрэгцээг тогтоох, зорилтот бүлгийг оновчтой тодорхойлох механизм дутмаг
2. Орон нутагт сургалт зохион байгуулах логистик, хүний нөөцийн боломж хязгаарлагдмал
3. Сургалтын талаарх мэдээллийг хүртээмжтэй хүргэж чаддаггүй
4. Сургалтын төлөвлөлт, хөтөлбөрийн агуулга нь орон нутгийн ЖДҮ эрхлэгчдийн онцлогт нийцээгүй байх тохиолдол байдаг
5. Сургалт зохион байгуулах хугацаа, байршил нь оролцогчдын боломжид тохироогүй байх тохиолдол байдаг
6. Санхүүжилт, дэмжлэгийн боломжоос шалтгаалан сургалтад хамрагдах сонирхолтой бүх хүнийг хамруулахад хүндрэлтэй байдаг
7. Сургалтын дараах дагалдах зөвлөх үйлчилгээ, арга зүйн дэмжлэг тогтмол бус
8. Цахим сургалт зохион байгуулахад техник, интернэт дэд бүтэц хангалтгүй
9. Сургалтад оролцогчдын хүлээлт, хэрэгцээ харилцан адилгүй байдаг
10. Сургалтын үр нөлөөг үнэлэх, эргэх холбоо авах тогтолцоо сул хөгжсөн
11. Бусад: _____

14. Таны бодлоор ЖДҮ эрхлэгч иргэд, ААН-үүдэд ямар төрлийн сургалт орох шаардлагатай вэ? (Бичгээр хариулна)

1. _____
2. _____
3. _____

IV. САНХҮҮГИЙН ДЭМЖЛЭГ

15. Төрөөс жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих санхүүгийн дэмжлэгийн талаар иргэд, ААН-үүд хэр зэрэг мэдлэг, ойлголттой байдаг вэ? (Зөвхөн нэг хариулт сонгоно)

- | | |
|---------------|------------------|
| 1. Маш муу | 4. Сайн |
| 2. Муу | 5. Маш сайн |
| 3. Дунд зэрэг | 6. Хэлж мэдэхгүй |

16. Танай аймаг/дүүргийн түвшинд 2024 онд хэдэн ЖДҮ эрхлэгч иргэн, ААН-д санхүүгийн дэмжлэг үзүүлсэн бэ? (Зөвхөн нэг хариулт сонгоно) --- 6 дугаар хариултыг сонгосон бол 17, 18, 19, 20, 21 дүгээр асуултыг алгасна.

- | | |
|--------------|--|
| 1. 5 хүртэлх | 5. 20-оос дээш |
| 2. 6-10 | 6. Сум/хорооны түвшинд санхүүгийн дэмжлэг үзүүлдэггүй тул мэдэхгүй |
| 3. 11-15 | |
| 4. 16-20 | |

17. ЖДҮ эрхлэгч иргэн, ААН-үүд ихэнх тохиолдолд ямар “санхүүгийн” дэмжлэг хүсдэг вэ? (Зөвхөн нэг хариулт сонгоно)

1. Хөнгөлөлттэй зээл авах
2. Шинээр бий болгосон ажлын байрны тоо, борлуулалтын орлогын хэмжээг харгалзан зээлийн хүүгийн хэмжээг бууруулах
3. Зээлийн давхар батлан даалт гаргуулах
4. Зээлийн хүүгийн татаас олгуулах
5. Тоног төхөөрөмжийн санхүүгийн түрээсийн үйлчилгээ, түрээсийн хүүгийн дэмжлэг авах

18. Доорх санхүүгийн дэмжлэгүүдээс алийг нь (бичиг баримт бүрдүүлэхээс бусад) иргэн, ААН-үүдэд өгөхөд хамгийн хүндрэлтэй байдаг вэ? (Зөвхөн нэг хариулт сонгоно)

1. Хөнгөлөлттэй зээл олгох

2. Шинээр бий болгосон ажлын байрны тоо, борлуулалтын орлогын хэмжээг харгалзан зээлийн хүүгийн хэмжээг бууруулах
 3. Зээлийн давхар батлан даалт гаргах
 4. Зээлийн хүүгийн татаас олгох
 5. Тоног төхөөрөмжийн санхүүгийн түрээсийн үйлчилгээ, түрээсийн хүүгийн дэмжлэг үзүүлэх
 6. Ямар нэгэн хүндрэл байдаггүй
19. Тус санхүүгийн дэмжлэгийг өгөхөд ямар хүндрэл учирдаг вэ? (Бичгээр хариулна) --- 18 дугаар асуултын хариулттай уялдуулж хариулна.
1. _____
 2. _____
 3. _____

20. Таны бодлоор шаардлага хангасан ЖДҮ эрхлэгч иргэн, ААН бүр төрөөс олгож буй санхүүгийн дэмжлэгт хамрагдаж чаддаг уу? (Зөвхөн нэг хариулт сонгоно) --- 4, 5, 6 дугаар хариултыг сонгосон бол 21 дүгээр асуултыг алгасна.
- | | |
|--------------------|------------------|
| 1. Огт чаддаггүй | 4. Ер нь чаддаг |
| 2. Ер нь чаддаггүй | 5. Бүрэн чаддаг |
| 3. Дунд зэрэг | 6. Хэлж мэдэхгүй |

21. Шаардлага хангасан ч санхүүгийн дэмжлэг авч чаддаггүй шалтгаан нь юу байдаг гэж Та бодож байна вэ?
1. Дэмжлэгийн төсөв, хүртээмж нь өргөдөл гаргасан бүх хүсэлтэд хүрэлцдэггүй
 2. Хувийн танил тал, хандлага нөлөөлдөг байж болзошгүй
 3. Өргөдөл, төсөл шийдвэрлэх хугацаа урт байдаг
 4. Өмнө нь татгалзсан тохиолдолд дахин оролдох итгэл, мэдээлэл дутмаг байдаг
 5. Мэдээлэл хомс, иргэн, ААН-үүд мэдээлэлгүй байдаг
 6. Бусад: _____

V. **ЖИЖИГ, ДУНД ҮЙЛДВЭР КЛАСТЕРААР ТӨРӨЛЖҮҮЛЭН ХӨГЖҮҮЛЭХ** (Жижиг, дунд үйлдвэрийг кластераар төрөлжүүлэн хөгжүүлэх гэдэг нь ижил салбарын аж ахуйн нэгжүүдийг газар зүйн болон үйлдвэрлэлийн уялдаанд үндэслэн хамтарч хөгжүүлэх замаар өрсөлдөх чадвар, бүтээмжийг нэмэгдүүлэх бодлого юм.)

22. “Төрөөс жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих ур чадварыг хөгжүүлэх чиглэлээр кластераар төрөлжүүлэн хөгжүүлэхэд чиглэсэн дунд хугацааны хөтөлбөр”-ийн талаар иргэн, ААН-үүд хэр зэрэг мэдлэг, ойлголттой байдаг вэ? (Зөвхөн нэг хариулт сонгоно)
- | | |
|---------------|------------------|
| 1. Маш муу | 4. Сайн |
| 2. Муу | 5. Маш сайн |
| 3. Дунд зэрэг | 6. Хэлж мэдэхгүй |
23. Танай аймаг/дүүрэг төрөөс жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих ур чадварыг хөгжүүлэх чиглэлээр кластераар төрөлжүүлэн хөгжүүлэхэд чиглэсэн дунд хугацааны хөтөлбөртэй юу? (Зөвхөн нэг хариулт сонгоно)
1. Тийм --- тус хариултыг сонгосон бол 25 дугаар асуултыг алгасна.
 2. Үгүй --- тус хариултыг сонгосон бол 24 дүгээр асуултыг алгасна.
24. Кластераар төрөлжүүлэхэд чиглэсэн дунд хугацааны хөтөлбөр хэрэгжиж байгаа бол Та хэрэгжилтийг хэрхэн үнэлж байна вэ? (Зөвхөн нэг хариулт сонгоно)
- | | |
|---------------|------------------------|
| 1. Маш муу | 4. Сайн |
| 2. Муу | 5. Маш сайн |
| 3. Дунд зэрэг | 6. Хэлж мэдэхгүй байна |
25. Танай аймаг/дүүрэг кластераар төрөлжүүлэхэд чиглэсэн дунд хугацааны хөтөлбөргүй байгаа шалтгааныг Та юу гэж харж байна вэ? (3 хүртэлх хариулт сонгоно)
1. Аймаг/дүүргийн хөгжлийн бодлого, төлөвлөлтөд кластерын чиглэлийг тусгаагүй
 2. Кластерт чиглэсэн хөтөлбөр хэрэгжүүлэх санхүүжилт, хөрөнгө оруулалт тогтмол бус
 3. Аймаг/дүүргийн түвшинд мэргэжлийн дэмжлэг, арга зүйн баг хүрэлцээгүй

4. Кластер байгуулах суурь нөхцөл (дэд бүтэц, зах зээл, хамтын орчин) бүрэн хангагдаагүй
5. ЖДҮ, үйлчилгээний кластерыг дэмжих журам тодорхойгүй
6. Хувийн хэвшлийн оролцоо тогтвортой биш, уялдаа холбоо сул
7. Хөтөлбөрийн талаарх мэдээлэл, сурталчилгаа орон нутагт дутмаг
8. Орон нутгийн түвшинд хэрэгжүүлэх удирдлага, зохион байгуулалт уялдаагүй байдаг
9. Бүс нутгийн эдийн засгийн онцлог, тэргүүлэх чиглэлүүдийг тодорхойлох судалгаа хязгаарлагдмал
10. Хөтөлбөр, төсөл сонгон шалгаруулах үндэслэл, шалгуур нь ойлгомжгүй
11. Бусад: _____

Хавсралт 2. Санал асуулгын үр дүн

I. ЕРӨНХИЙ АСУУЛГА

1. Аймаг, нийслэл, дүүрэг

1	Архангай	1.9
2	Баян-Өлгий	7.6
3	Баянхонгор	10.8
4	Булган	0.6
5	Говь-Алтай	5.1
6	Говьсүмбэр	1.9
7	Дархан-Уул	0.6
8	Дорноговь	4.5
9	Дорнод	6.4
10	Дундговь	3.2
11	Өмнөговь	8.9
12	Сүхбаатар	3.8
13	Төв	9.6

14	Хөвсгөл	10.8
15	Улаанбаатар	1.3
16	Багануур	0.6
17	Багахангай	3.2
18	Баянгол	2.5
19	Баянзүрх	3.8
20	Сонгинохайрхан	3.8
21	Сүхбаатар	1.3
22	Чингэлтэй	1.9
23	Хан-Уул	5.1
24	Налайх	0.6
25	Нийт	100.0

2. Албан тушаал

1	Аймаг: Жижиг, дунд үйлдвэр, хөнгөн, хоршоо, ахуйн үйлчилгээний асуудал хариуцсан мэргэжилтэн	17.8
2	Сум: Жижиг дунд үйлдвэрлэл хариуцсан мэргэжилтэн	55.4
3	Дүүрэг: Төсөл, мэдээлэл хариуцсан мэргэжилтэн	1.3
4	Дүүрэг: Хороод зохион байгуулалт хариуцсан мэргэжилтэн	0.6
5	Дүүрэг: Үйлдвэрлэл, судалгаа хариуцсан мэргэжилтэн	3.8
6	Дүүрэг: Өрхийн үйлдвэрлэл, судалгаа хариуцсан мэргэжилтэн	0.6
7	Дүүрэг: Сургалт, мэдээлэл хариуцсан мэргэжилтэн	5.1
8	Бусад	15.3
	Нийт	100.0

II. ЖИЖИГ, ДУНД ҮЙЛДВЭР, ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭГЧДИЙГ ДЭМЖИХ ТӨРИЙН БОДЛОГО

3. Дэмжлэг хүсдэг ЖДҮҮЭ-дийн ангилал

	Улсын дүн	Улаанбаатар хот	Орон нутаг
Бичил үйлдвэр, үйлчилгээ	89.2	84.2	90.8
Жижиг үйлдвэр, үйлчилгээ	8.9	13.2	7.6
Дунд үйлдвэр, үйлчилгээ	1.9	2.6	1.7
Нийт	100.0	100.0	100.0

III. СУРГАХ, ДАВТАН СУРГАХ ТОГТОЛЦООНЫ ДЭМЖЛЭГ

4. Хүний нөөцийн ур чадварыг хөгжүүлэх сургалт, давтан сургалт зохион байгуулдаг талаар ЖДҮҮЭ-ийн мэдлэг ойлголт

Үнэлгээ	Улсын дүн	Улаанбаатар хот	Орон нутаг
Маш муу	7.0	5.3	7.6
Муу	15.9	13.2	16.8

Дунд зэрэг	49.7	36.8	53.8
Сайн	23.6	42.1	17.6
Маш сайн	1.9	2.6	1.7
Хэлж мэдэхгүй	1.9	0.0	2.5
Нийт	100.0	100.0	100.0

5. 2024 онд зохион байгуулсан ЖДҮ эрхлэгчдийн ур чадварыг хөгжүүлэх сургалтын тоо зохион байгуулсан бэ?

	Улсын дүн	Улаанбаатар хот	Орон нутаг
5 хүртэлх удаа	71.3	23.7	86.6
6-10-н удаа	12.1	21.1	9.2
11-15-н удаа	4.5	15.8	0.8
16-20-н удаа	6.4	23.7	0.8
20-оос дээш удаа	5.7	15.8	2.5
Нийт	100.0	100.0	100.0

6. 2024 онд ЖДҮ эрхлэгчдийн ур чадварыг хөгжүүлэх сургалтад хамрагдсан хүний тоо

	Улсын дүн	Улаанбаатар хот	Орон нутаг
5 хүртэлх	40.8	15.8	48.7
6-10	11.5	2.6	14.3
11-15	4.5	2.6	5.0
16-20	2.5	5.3	1.7
20-оос дээш	8.9	15.8	6.7
Сум/хорооны түвшинд санхүүгийн дэмжлэг үзүүлдэггүй тул мэдэхгүй	31.8	57.9	23.5
	100.0	100.0	100.0

7. Ур чадварыг хөгжүүлэх сургалтаас иргэд, ААН-үүд өөрт хэрэгцээ шаардлагатай чадварыг эзэмшиж чаддаг эсэх үнэлгээ

	Улсын дүн	Улаанбаатар хот	Орон нутаг
Хэлж мэдэхгүй	2.5%	2.6%	2.5%
Огт чаддаггүй	3.8%	2.6%	4.2%
Ер нь чаддаггүй	8.9%	5.3%	10.1%
Дунд зэрэг	49.0%	39.5%	52.1%
Ер нь чаддаг	27.4%	31.6%	26.1%
Бүрэн чаддаг	8.3%	18.4%	5.0%
Нийт	100.0%	100.0%	100.0%

8. ЖДҮ эрхлэгчдийн ур чадварыг хөгжүүлэх сургалтаас иргэд, ААН-үүд өөрт шаардлагатай чадварыг эзэмшиж чаддаггүй шалтгаан (олон хариулттай)

	Шалтгаан	Улсын дүн	Улаанбаатар хот	Орон нутаг
1	Сургалтын хэрэгцээг тогтоох, зорилтот бүлгийг оновчтой тодорхойлох механизм дутмаг	0.0%	0.0%	0.0%
2	Орон нутагт сургалт зохион байгуулах логистик, хүний нөөцийн боломж хязгаарлагдмал	2.9%	0.0%	5.9%

3	Сургалтын талаарх мэдээллийг хүртээмжтэй хүргэж чаддаггүй	9.0%	7.9%	10.1%
4	Сургалтын төлөвлөлт, хөтөлбөрийн агуулга нь орон нутгийн ЖДҮ эрхлэгчдийн онцлогт нийцээгүй байх тохиолдол байдаг	5.1%	2.6%	7.6%
5	Сургалт зохион байгуулах хугацаа, байршил нь оролцогчдын боломжид тохироогүй байх тохиолдол байдаг	9.8%	7.9%	11.8%
6	Санхүүжилт, дэмжлэгийн боломжоос шалтгаалан сургалтад хамрагдах сонирхолтой бүх хүнийг хамруулахад хүндрэлтэй байдаг	11.6%	10.5%	12.6%
7	Сургалтын дараах дагалдах зөвлөх үйлчилгээ, арга зүйн дэмжлэг тогтмол бус	5.5%	2.6%	8.4%
8	Цахим сургалт зохион байгуулахад техник, интернэт дэд бүтэц хангалтгүй	9.0%	7.9%	10.1%
9	Сургалтад оролцогчдын хүлээлт, хэрэгцээ харилцан адилгүй байдаг	9.0%	10.5%	7.6%
10	Сургалтын үр нөлөөг үнэлэх, эргэх холбоо авах тогтолцоо сул хөгжсөн	6.4%	5.3%	7.6%

9. ЖДҮ эрхлэгч иргэд, ААН-үүдэд шаардлагатай сургалт

	Улсын дүн	Улаанбаатар хот	Орон нутаг
Төрөөс олгож буй хөнгөлөлттэй зээлийн талаарх	6.3	18.2	2.7
Төсөл бичих сургалт	11.1	6.1	12.6
ЖДҮ-ийн талаар мэдлэг ойлголт өгөх сургалт	15.3	15.2	15.3
Санхүүгийн талаарх сургалт	16.7	12.1	18.0
Хүний нөөцийн талаарх сургалт	4.9	0.0	6.3
Татварын талаарх сургалт	1.4	3.0	0.9
Маркетинг	10.4	24.2	6.3
Хууль	3.5	3.0	3.6
Бизнесийн талаарх сургалт	30.6	18.2	34.2
Нийт	100.0	100.0	100.0

IV. САНХҮҮГИЙН ДЭМЖЛЭГ

7. Төрөөс жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих санхүүгийн дэмжлэгийн талаар иргэд, ААН-үүдийн мэдлэг, ойлголт

	Улсын дүн	Улаанбаатар хот	Орон нутаг
Маш муу	5.1	10.5	3.4
Муу	15.3	26.3	11.8
Дунд зэрэг	52.2	47.4	53.8
Сайн	22.9	5.3	28.6
Маш сайн	3.2	7.9	1.7
Хэлж мэдэхгүй	1.3	2.6	0.8
Нийт	100.0	100.0	100.0

7. 2024 онд санхүүгийн дэмжлэг үзүүлсэн ЖДҮ эрхлэгч иргэн, ААН-ийн тоо

	Улсын дүн	Улаанбаатар хот	Орон нутаг
5 хүртэлх	40.8	15.8	48.7
6-10	11.5	2.6	14.3
11-15	4.5	2.6	5.0
16-20	2.5	5.3	1.7
20-оос дээш	8.9	15.8	6.7
Сум/хорооны түвшинд санхүүгийн дэмжлэг үзүүлдэггүй тул мэдэхгүй	31.8	57.9	23.5
Нийт	100.0	100.0	100.0

10. Хамгийн их дэмжлэг авахыг хүсдэг санхүүгийн дэмжлэг

	Улсын дүн	Улаанбаатар хот	Орон нутаг
Хөнгөлөлттэй зээл авах	80.0	68.8	82.0
Шинээр бий болгосон ажлын байрны тоо	8.6	12.5	7.9
Зээлийн давхар батлан даалт гаргуулах	6.7	0.0	7.9
Зээлийн хүүгийн татаас олгуулах	1.9	12.5	0.0
Тоног төхөөрөмжийн санхүүгийн түрээсийн	2.9	6.3	2.2
Нийт	100.0	100.0	100.0

11. Доорх санхүүгийн дэмжлэгүүдээс алийг нь (бичиг баримт бүрдүүлэхээс бусад) иргэн, ААН-үүдэд өгөхөд хамгийн хүндрэлтэй байдаг вэ? (Зөвхөн нэг хариулт сонгоно)

	Улсын дүн	Улаанбаатар хот	Орон нутаг
Хөнгөлөлттэй зээл олгох	43.3	43.8	43.2
Шинээр бий болгосон ажлын байрны тоо	15.4	6.3	17.0
Зээлийн давхар батлан даалт гаргах	16.3	12.5	17.0
Зээлийн хүүгийн татаас олгох	1.9	0.0	2.3
Тоног төхөөрөмжийн санхүүгийн түрээсийн үйлчилгээ	8.7	25.0	5.7
Ямар нэгэн хүндрэл байдаггүй	14.4	12.5	14.8
	100.0	100.0	100.0

12. Санхүүгийн дэмжлэг үзүүлэхэд хүндрэл үүсдэг шалтгаан

	Улсын дүн	Улаанбаатар хот	Орон нутаг
Барьцаа хөрөнгийн хүндрэл	21.2	50.0	18.3
Санхүүжилтийн хүндрэл	13.6	16.7	13.3
Шаардлага өндөр	25.8	0.0	28.3
Зээлийн төлөлтийн хүндрэл	7.6	0.0	8.3
Зээлийн батлан даалтын хүндрэл	3.0	0.0	3.3
Зээлийн материал бүрдүүлэлт	9.1	0.0	10.0
Иргэд, бичил бизнес эрхлэгчдэд дэмжлэг байхгүй	7.6	16.7	6.7
Зээлийн хүртээмж	12.1	16.7	11.7
Нийт	100.0	100.0	100.0

13. Төрөөс олгож буй санхүүгийн дэмжлэгт ЖДҮ эрхлэгч иргэн, ААН бүр хамрагдаж чаддаг эсэх

	Улсын дүн	Улаанбаатар хот	Орон нутаг
Огт чаддаггүй	6.5	12.5	5.5
Ер нь чаддаггүй	28.0	6.3	31.9
Дунд зэрэг	41.1	62.5	37.4
Ер нь чаддаг	15.0	12.5	15.4
Бүрэн чаддаг	3.7	0.0	4.4
Хэлж мэдэхгүй	5.6	6.3	5.5
Нийт	100.0	100.0	100.0

14. Шаардлага хангасан ч санхүүгийн дэмжлэг авч чаддаггүй шалтгаан

	Улсын дүн	Улаанбаатар хот	Орон нутаг
Дэмжлэгийн төсөв, хүртээмж нь өргөдөл гаргасан бүх хүсэлтэд хүрэлцдэггүй	62.0	30.8	68.2
Хувийн танил тал, хандлага нөлөөлдөг байж болзошгүй	16.5	30.8	13.6
Өргөдөл, төсөл шийдвэрлэх хугацаа урт байдаг	5.1	0.0	6.1
Өмнө нь татгалзсан тохиолдолд дахин оролдох итгэл, мэдээлэл дутмаг байдаг	10.1	23.1	7.6
Мэдээлэл хомс, иргэн, ААН-үүд мэдээлэлгүй байдаг	6.3	15.4	4.5
Нийт	100.0	100.0	100.0

V. ЖИЖИГ, ДУНД ҮЙЛДВЭР КЛАСТЕРААР ТӨРӨЛЖҮҮЛЭН ХӨГЖҮҮЛЭХ (Жижиг, дунд үйлдвэрийг кластераар төрөлжүүлэн хөгжүүлэх гэдэг нь ижил салбарын аж ахуйн нэгжүүдийг газар зүйн болон үйлдвэрлэлийн уялдаанд үндэслэн хамтарч хөгжүүлэх замаар өрсөлдөх чадвар, бүтээмжийг нэмэгдүүлэх бодлого юм.)

15. “Төрөөс жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих ур чадварыг хөгжүүлэх чиглэлээр кластераар төрөлжүүлэн хөгжүүлэхэд чиглэсэн дунд хугацааны хөтөлбөр”-ийн талаарх иргэн, ААН-үүдийн ойлголтын үнэлгээ

	Улсын дүн	Улаанбаатар хот	Орон нутаг
Маш муу	8.9	15.8	6.7
Муу	27.4	23.7	28.6
Дунд зэрэг	49.0	44.7	50.4
Сайн	9.6	5.3	10.9
Маш сайн	1.3	2.6	0.8
Хэлж мэдэхгүй	3.8	7.9	2.5
Нийт	100.0	100.0	100.0

16. Төрөөс жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих ур чадварыг хөгжүүлэх чиглэлээр кластераар төрөлжүүлэн хөгжүүлэхэд чиглэсэн дунд хугацааны хөтөлбөртэй эсэх

	Улсын дүн	Улаанбаатар хот	Орон нутаг
Тийм	42.7	44.7	42.0

Үгүй	57.3	55.3	58.0
Нийт	100.0	100.0	100.0

17. Кластераар төрөлжүүлэхэд чиглэсэн дунд хугацааны хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ

	Улсын дүн	Улаанбаатар хот	Орон нутаг
Маш муу	1.3	4.5	0.0
Муу	12.7	18.2	10.5
Дунд зэрэг	59.5	59.1	59.6
Сайн	17.7	4.5	22.8
Маш сайн	1.3	0.0	1.8
Хэлж мэдэхгүй байна	7.6	13.6	5.3
Нийт	100.0	100.0	100.0

18. Зарим аймгийн Кластераар төрөлжүүлэхэд чиглэсэн дунд хугацааны хөтөлбөргүй байгаа шалтгаан (Олон хариулттай)

Шалтгаан	Улаанбаатар хот	Орон нутаг
Аймаг/дүүргийн хөгжлийн бодлого, төлөвлөлтөд кластерын чиглэлийг тусгаагүй	4	14
Кластерт чиглэсэн хөтөлбөр хэрэгжүүлэх санхүүжилт, хөрөнгө оруулалт тогтмол бус	9	24
Аймаг/дүүргийн түвшинд мэргэжлийн дэмжлэг, арга зүйн баг хүрэлцээгүй	5	13
Кластер байгуулах суурь нөхцөл (дэд бүтэц, зах зээл, хамтын орчин) бүрэн хангагдаагүй	9	19
ЖДҮ, үйлчилгээний кластерыг дэмжих журам тодорхойгүй	6	18
Хувийн хэвшлийн оролцоо тогтвортой биш, уялдаа холбоо сул	3	13
Хөтөлбөрийн талаарх мэдээлэл, сурталчилгаа орон нутагт дутмаг	4	11
Орон нутгийн түвшинд хэрэгжүүлэх удирдлага, зохион байгуулалт уялдаагүй байдаг	4	11
Бүс нутгийн эдийн засгийн онцлог, тэргүүлэх чиглэлүүдийг тодорхойлох судалгаа хязгаарлагдмал	1	8
Хөтөлбөр, төсөл сонгон шалгаруулах үндэслэл, шалгуур нь ойлгомжгүй	2	3

Хавсралт 3. Ганцаарчилсан ярилцлага

жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгч 1

Та (танай ажилчид) жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжих төвөөс зохион байгуулсан сургалтад хамрагдаж байсан уу? Үгүй бол яагаад? Сургалт зохион байгуулагдаж байгаа талаар мэдээлэл авч чаддаггүй эсвэл сургалтын агуулга таалагдаагүй юу? (§8.1.1)

2014 онд Нийслэлийн ЖДҮДТ-д сургалтад хамрагдаж байсан, түүнээс хойш хамрагдаагүй. Сүүлийн жилүүдэд BEST (АНУ-ын Олон улсын хөгжлийн агентлаг (USAID)-ын санхүүжилттэй, "Хөгжлийн Шийдэл" төрийн бус байгууллагын хэрэгжүүлсэн "Бизнесийн тогтвортой хөгжлийг сайжруулах, ил тод байдлыг нэмэгдүүлэх" хөтөлбөр), Европын холбооны "Эмэгтэй бизнес эрхлэгчдийг дэмжих" хөтөлбөрийн үнэгүй сургалтуудад их хамрагдсан.

Хэрвээ тийм бол тухайн сургалтаас таны бизнесийн хэрэгцээнд нийцсэн мэдээлэл, зөвлөгөө авах боломж хэр байсан бэ?

Best хөтөлбөр маш үр өгөөжтэй байсан. Багаар нь ч зөвлөгөө сайн өгсөн. Ганцаарчилсан зөвлөгөөнүүдийг ч сайн өгсөн. Бид нар өөрсдөө завгүй гээд оролцож чадахгүй байсан болохоос маш сайн үр дүнтэй байж чадсан.

Сургалтын чанар, хүртээмж, агуулга нь зах зээлийн эрэлт хэрэгцээтэй хэр зэрэг нийцэж байсан талаар та бодлоо хуваалцаач?

Best хөтөлбөрт хамрагдаж заалгасны дагуу төслөө өөрөө бичиж, зээлд амжилттай хамрагдсан.

Та Жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдэд

(1) хөнгөлөлттэй зээл олгох, (2) шинээр бий болгосон ажлын байрны тоо, борлуулалтын орлогын хэмжээг харгалзан зээлийн хүүгийн хэмжээг бууруулах, (3) зээлийн давхар батлан даалт гаргах, (4) зээлийн хүүгийн татаас олгох, (5) тоног төхөөрөмжийн санхүүгийн түрээсийн үйлчилгээ, түрээсийн хүүгийн дэмжлэг үзүүлэх зэргээр санхүүгийн дэмжлэг үзүүлдэг талаар мэдэх үү? (§8.1.2), (§11.3)

ЖДҮ-ийн хөнгөлөлттэй зээлийн талаар бол мэднэ, бусад дэмжлэгийн талаар сайн мэдэхгүй, сонсож байгаагүй. Бид (ЖДҮ эрхлэгчид) хоорондоо мэдээлэл солилцдог ч эдгээр дэмжлэгт хамрагдсан талаар сонсоогүй. Уг нь ийм дэмжлэгүүд хэрэгтэй байдаг. Батлан даалтын сан байдаг гэж сонссон ч бидний хувьд хэрэгжээгүй. Би 300 сая төгрөгийн зээл авах боломжтой байсан ч барьцаа хөрөнгө байхгүйгээс 160 саяын зээл авч 50 м2 ажлын байр авсан. Гэвч одоо үйлдвэр маань энэ байрандаа багтахгүй, 2-3 газар салгаж ажиллаж байна. Хэрэв тухайн үед батлан даалтын сангаар дэмжлэг авсан бол арай том байр авах боломжтой, үйлдвэрээ нэг дор байрлуулах боломжтой байх байсан. Одоо байр багтахгүй, хэцүү байдаг.

Хэрвээ тийм бол хаанаас мэдээлэл авч байсан бэ?

Ихэвчлэн сошиалаар мэдээлэл авдаг. Манай ЖДҮГ-аас мэдээллийг сайн өгдөг, зээл авснаас хойш янз бүрийн мэдээллийг утсаар хэлж, зээлд хамрагдсан хүмүүстэй тогтмол холбоотой байдаг. Зээл авахаас өмнө ч сошиалаар мэдээллээ авч байсан. Мөн янз бүрийн үзэсгэлэн, худалдаанд оролцох үед ЖДҮГ-аас ирж мэдээлэл өгдөг байсан. Манай Баянзүрх дүүргийн ЖДҮ-ийг дэмжих төв өмнө нь мэдээллийг маш сайн өгдөг байсан ч сүүлийн үед мэдээлэл дутмаг болсон.

Төрөөс үзүүлж байгаа дэмжлэгүүдэд хэрхэн хамрагдах, төслийн материал бэлдэх зэрэг асуудлаар төрийн байгууллагын холбогдох албан хаагчдаас тусламж авч байсан уу? Хэрвээ тийм бол ямар нэгэн хүндрэл бэрхшээл гарч байсан уу? Хүссэн мэдээллээ авч чадсан уу?

BEST хөтөлбөрийн багш нар маш сайн тусалсан. 2024 онд зээл авахад ч багш нар сайн зөвлөгөө өгч, тусалсан. Харин төрийн албан хаагчдаас тусламж авч байгаагүй.

Та Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх санд хөнгөлөлттэй зээлд хамрагдахаар материалаа явуулж байсан уу? Өөрийн материалдаа хэр итгэлтэй байсан бэ? Хөнгөлөлттэй зээлд хамрагдаж чадсан уу?

Тийм, 2024 онд зээлд хамрагдаж авсан. Тухайн үедээ төслөө 100 хувь өөрөө бичсэн, төсөл бичих сургалтад сууж ойлголттой болсон учраас өөрийн материалаа итгэлтэй байсан.

Та Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох төслийн сонгон шалгаруулалт хэр зэрэг шударга, ил тод явагддаг гэж бодож байна?

Өмнө нь ЖДҮ-ийн зээл арын хаалгаар олддог гэж их сонсдог байсан тул хүсэлт өгч байгаагүй, өндөр хүүтэй банкны зээл авч явдаг байсан. BEST хөтөлбөрт хамрагдаж, сүүлийн 2-3 жил мэдээлэл авч, шалгаруулалт шударга явагддаг гэдгийг ойлгосон. 2024 онд оролцоход шударга болсон гэж үзэж байна, учир нь зээл авсан компаниуд бүгд танил, үзэсгэлэн худалдаанд хамт оролцдог, жижиг дунд

үйлдвэрлэгч нар байсан. 2023 оны Экспортыг дэмжих төсөлд хамрагдахад ч шударга байсан. Өөрсдөө зээл авч чадсан тул төрөөс биднийг дэмжсэн гэж үзэж байна.

Төслийн сонгон шалгаруулалтад оролцоход шаардлагатай баримт, материал, тавигдах шалгуур хэр зэрэг практикт нийцсэн гэж үзэж байна?

Ерөнхийдөө нийцсэн гэж харсан. Үзсэн хичээлийг дагуу, суралцсан зүйл дээрээ үндэслэн бэлдэж өгсөн.

Нэг удаа олгох зээлийн дээд хэмжээ таны бизнест хангалттай хүрэлцээтэй байна уу? (§11.6)

Хүрэлцээтэй байгаагүй. Яагаад гэвэл барьцаа хөрөнгөгүй учраас.

Сонгон шалгаруулалтад төслийн саналаа мэдүүлэхэд хүндрэл, бэрхшээл тулгардаг уу? Тийм бол ямар?

Онлайнар бичиг баримтаа илгээсэн тул хүндрэл гараагүй.

Хөнгөлөлттэй зээл олгохгүй дараах нөхцөлүүдээс аль нь жижиг дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдэд санхүүгийн дэмжлэг авахад хамгийн их хүндрэл учруулдаг вэ? (§11.11)

1. Сангаас авсан зээлийн үлдэгдэлтэй;
2. Зээлийн мэдээллийн санд муу зээлийн түүхтэй;
3. Сангаас авсан зээлийг зориулалтын бусаар ашигласан нь тогтоогдсон;
4. Шүүхийн шийдвэрээр бусдад төлөх өртэй;
5. Төсөл хүлээн авах сүүлийн өдрийн байдлаар нийгмийн даатгал, татварын байгууллагад өртэй.

Нийгмийн даатгал, татварын өртэй байх нөхцөл хамгийн их хүндрэл учруулдаг. Өргүй байж л зээл авдаг. Өргүй ЖДҮ бараг байхгүй, зээл аваад өрөө төлдөг тул энэ шалгуур байхгүй бол зүгээр санагдсан. Энэ нь ЖДҮ эрхлэгчдэд том дарамт болдог.

Та жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдэд төрөөс татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн дэмжлэг үзүүлдэг талаар хэр мэдээлэлтэй байдаг вэ? (§8.1.3)

Тийм сайн мэдээлэлгүй, зурагтаар л сонсдог.

Та татварын хөнгөлөлт, чөлөөлөлтөд хамрагддаг уу? Хэрвээ тийм бол ямар хэлбэрийн татварын хөнгөлөлт, чөлөөлөлтөд хамрагддаг вэ? Энэхүү хөнгөлөлт танд бодит дэмжлэг болж чаддаг уу?

Үгүй, хамрагдаж байгаагүй.

Төрөөс экспортыг нэмэгдүүлэх, импортыг орлох өрсөлдөх чадвартай бүтээгдэхүүний үйлдвэрлэл, үйлчилгээг дэмждэг талаар мэдэх үү? Хэрвээ тийм бол ийм төрлийн дэмжлэгт хамрагдаж байсан уу? Дэмжлэгт хамрагдахад хүндрэл, бэрхшээл гарч байсан уу? Тийм бол ямар? (§8.1.4)

Мэднэ, Монгол-Хятадын хоёр жилд нэг удаа болдог экспо л мэднэ, тэрэнд оролцдог. Бага зардлаар бараа бүтээгдэхүүнээ гаргах боломжтой байдаг.

Та төрөөс бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний борлуулалтад төрийн худалдан авалтаар дэмжлэг үзүүлдэг талаар мэдэх үү? Та төрийн худалдан авах ажиллагаанд оролцож байсан уу? Хэрвээ тийм бол энэ дэмжлэгийг авч чадсан уу? (§8.1.5)

Мэдэхгүй. Бусад компаниуд оролцдог гэж сонссон, манайх оролцож байгаагүй. Манайх оролцох маш их хүсэлтэй.

Та жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ дэмжих төрийн байгууллагуудаас бизнесийн зөвлөгөө авч байсан уу? Хэрвээ тийм бол та өөрт хэрэгцээтэй зөвлөгөө, мэдээллийг авч чадсан уу? Та хэрхэн үнэлэх вэ? (§8.1.6)

Үгүй

Та шинэ бүтээгдэхүүн хөгжүүлэх эсхүл бүтээмжийг нэмэгдүүлэх судалгаа зэрэгт төрөөс дэмжлэг үзүүлдэг талаар мэдэх үү? Тийм бол дэмжлэг авахаар оролдож байсан уу? Ямар хүндрэл, бэрхшээл гарч байсан бэ? (§8.1.7)

Мэдэхгүй.

Төрөөс техник, технологийн дэвшлийг дамжуулах, нутагшуулах, шинжлэх ухаан, технологийн судалгааны үр дүнг үйлдвэрлэлд нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлдэг талаар та хэр сайн мэдэх вэ? (§8.1.8)

Мэдэхгүй.

Та кластерын талаар хэр сайн ойлголттой вэ? (§8.1.9) Танай компани үйл ажиллагаагаа эрхлэхдээ кластераар ажилладаг уу? Ийм хэлбэрээр ажиллахад төрөөс дэмжлэг авч байсан уу?

Тэр талаар ерөнхий ойлголттой. Манай арьс ширний холбоо кластер байгуулсан, цүнхний үйлдвэрүүд кластер болж ажилладаг, бид ч оролцож байгаа. Кластераар ажиллах нь хамтын хүчээр хөгжих боломж гэж үздэг. Одоогоор төрөөс дэмжлэг аваагүй, Европын холбооноос дэмжлэг авах гэж ажиллаж байна. Төрөөс тэгж дэмждэг гэж сонсоогүй.

Танай бүтээгдэхүүн үйлчилгээ гадаад, дотоод зах зээлд гарахдаа төрөөс ямар нэгэн дэмжлэг авч байсан уу? (§8.1.10) (жишээ нь дотоодын болон олон улсын үзэсгэлэн худалдаа зохион байгуулах, оролцох зэрэг)

Түрүүн дурдсан Монгол-Хятадын экспод оролцдог.

Хэрвээ авсан бол ямар? Энэ дэмжлэг нь гадаад, дотоод зах зээлд гарахад бодитой дэмжлэг болж чадсан уу?

Хоёр улсын экспо бодитой дэмжлэг байж чаддаг. Энэ нь манай экспортыг дэмжиж байгаа ганц дэмжлэг гэж харж байна. Түүнд Нарантуулын жижиг цехүүд хүртэл явдаг. Ер нь 1000-аад үйлдвэрлэгч явдаг, тэр дотор том, жижиг, дөнгөж үйл ажиллагаа эхэлж байгаа бизнес ч оролцдог. Бүх хүн хамрагддаг, маш бага түрээсийн зардалтай, бүх бараа бүтээгдэхүүн татваргүй гардаг болохоор төрөөс үзүүлж буй маш чухал дэмжлэг. Ард түмэн, үйлдвэрлэгч нарт маш их өгөөжөө өгч байгаа ганц үзэсгэлэн.

Таны бодлоор Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хууль хэр зэрэг хэрэгжиж байна? Яагаад?

Ёстой мэдэхгүй.

Нэмж хэлэх санал

Хуульдаа өөрчлөлт оруулахдаа татварын хувьд бид нарыг дэмжээд өгвөл хэрэгтэй. Түүнээс гадна татварын алба, нийгмийн даатгалын албаны хүнд суртал маш хэцүү, загнаж харьцдаг. Хүнтэй найрсаг харьцаасай гэж хүсдэг. Тэд нарыг сургалтад сайн хамруулж харьцааны соёлд суралцмаар.

Экспортоо сайн дэмжээсэй. Хоёр жилд 1 удаа болдог Хятадын экспо шиг үзэсгэлэн худалдааг сайн зохион байгуулвал үнэхээр хэрэгтэй дэмжлэг. Монголд ЖДҮ-ийн хувьд дотоодын худалдан авалт бараг байхгүй болсон. Төрийн худалдан авалт болон дотооддоо бараа бүтээгдэхүүнээ борлуулахад дэмжлэг хэрэгтэй байна. Төрийн худалдан авалтын тендер яаж зарлагддаг талаар мэдээлэл авч чаддаггүй, гэхдээ компаниуд мэдээлэл аваад оролцоод байдаг. Энэ мэдээллийг илүү хүртээмжтэй болговол зүгээр байна.

Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих газар бидэнтэй маш сайн холбоотой, дэмжиж ажилладагт их баярлаж явдаг. Харин Нийслэлийн ЖДҮҮ дэмжих төв сүүлийн жилүүдэд хэрхэн ажилаад байгаа нь мэдэгдэхгүй байна. Нийслэлийн ЖДҮҮ дэмжих төв сургалтаа явуулаад, бид нартай тулж ажиллах ёстой болов уу гэж боддог. Өмнө тэд мэдээлэл сайн өгч ажилладаг байсан бол сүүлийн жилүүдэд юу хийдэг нь мэдэгдэхгүй байгаа.

ЖИЖИГ, ДУНД ҮЙЛДВЭР, ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭГЧ 2.

Та (танай ажилчид) жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжих төвөөс зохион байгуулсан сургалтад хамрагдаж байсан уу? Үгүй бол яагаад? Сургалт зохион байгуулагдаж байгаа талаар мэдээлэл авч чаддаггүй эсвэл сургалтын агуулга таалагдаагүй юу? (§8.1.1)

Тийм. Өөрийгөө цэнэглэе гэж бодоод идэвхтэй оролцдог. Сургалтын мэдээллийг сошиалаар авдаг. Янз бүрийн групп-ээс давхар мэдээлэл авдаг. Дүүргээс бас сургалтын мэдээлэл өгдөг.

Хэрвээ тийм бол тухайн сургалтаас таны бизнесийн хэрэгцээнд нийцсэн мэдээлэл, зөвлөгөө авах боломж хэр байсан бэ?

Ер нь сургалтууд гайгүй явагддаг. Бид нар өөрсдөө хөрсөн дээрээ буулгаж чаддаггүй. Би бүтээгдэхүүнээ экспортод гаргах сонирхол маш өндөр, энэ тал дээр ч мэдлэг байгаа. Гэхдээ тавигдах шаардлага хэцүү, санхүүжилт хүрэлцдэггүй.

Сургалтын чанар, хүртээмж, агуулга нь зах зээлийн эрэлт хэрэгцээтэй хэр зэрэг нийцэж байсан талаар та бодлоо хуваалцаач?

Хэрэгцээтэй.

Та Жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдэд

(1) хөнгөлөлттэй зээл олгох, (2) шинээр бий болгосон ажлын байрны тоо, борлуулалтын орлогын хэмжээг харгалзан зээлийн хүүгийн хэмжээг бууруулах, (3) зээлийн давхар батлан даалт гаргах, (4) зээлийн хүүгийн татаас олгох, (5) тоног төхөөрөмжийн санхүүгийн түрээсийн үйлчилгээ, түрээсийн хүүгийн дэмжлэг үзүүлэх зэргээр санхүүгийн дэмжлэг үзүүлдэг талаар мэдэх үү? (§8.1.2), (§11.3)

ЖДҮ-аас хөнгөлөлттэй зээл олгодог талаар мэднэ. Бусад дэмжлэгийн талаар бараг мэдэхгүй.

Хэрвээ тийм бол хаанаас мэдээлэл авч байсан бэ?

ЖДҮГ, Нийслэлийн ЖДҮҮ төв болон дүүргийн ЖДҮҮ төвөөс мэдээлэл өгдөг.

Төрөөс үзүүлж байгаа дэмжлэгүүдэд хэрхэн хамрагдах, төслийн материал бэлдэх зэрэг асуудлаар төрийн байгууллагын холбогдох албан хаагчаас тусламж авч байсан уу? Хэрвээ тийм бол ямар нэгэн хүндрэл бэрхшээл гарч байсан уу? Хүссэн мэдээллээ авч чадсан уу?

Авч байсан. Дэмжлэг авах газраа зөв сонгож очих хэрэгтэй. Сургалтад суугаад өөрөө төсөл бичиж, хөлсийн бөгөөд тооцоолол хийж сурсан. Төсөл бичих асуудлаар төрийн албан хаагчид дээр очоод байдаггүй.

Та Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх санд хөнгөлөлттэй зээлд хамрагдахаар материалаа явуулж байсан уу? Өөрийн материалдаа хэр итгэлтэй байсан бэ? Хөнгөлөлттэй зээлд хамрагдаж чадсан уу?

Тийм. 50 сая төгрөгийн зээл авах хүсэлт гаргасан, шаардлага хангаагүй гэх шатлгаанаар хамрагдаж чадаагүй. Тэр үед би материалаа болж байна гэж харсан.

Та Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох төслийн сонгон шалгаруулалт хэр зэрэг шударга, ил тод явагддаг гэж бодож байна?

Шударга, ил тод биш гэж боддог. Ер нь ЖДҮ эрхлэгчид хоорондоо "материалаа өгсөн ч сонгон шалгаруулдаг хүмүүс нь өөрсдөдөө ашигтайгаар шийддэг" гэж ярьдаг. Тийм зүйл байхыг үгүйсгэхгүй. Бид өөрсдөө хамрагдаж чадаагүй.

Төслийн сонгон шалгаруулалтад оролцоход шаардлагатай баримт, материал, тавигдах шалгуур хэр зэрэг практикт нийцсэн гэж үзэж байна?

Бичил бизнес эрхлэгчдэд бараг нийцэхгүй байгаа. Шаардлага хангасан материал бүрдүүлэхэд үнэхээр хэцүү, заримдаа баримт бичгийг уншаад "больё доо" гэж бодогддог. Санал хэлэхэд, бичил, жижиг, дунд гээд ангилал тус бүрт тохирсон ялгаатай шаардлага тавьдаг байвал зүгээр санагддаг. Дэмжлэг үзүүлэхдээ жижиг, дундаас илүү бичил бизнест чиглэсэн бодит дэмжлэг их хэрэгтэй байна. Өрхийн үйлдвэрлэл эрхэлж байгаа олон хүмүүс бий, гэхдээ тэдэнд зориулсан дэмжлэг бараг байдаггүй. Үзэсгэлэн худалдаанд оролцох боломж л олддог, тэр нь маш чухал дэмжлэг болдог. Үзэсгэлэнд оролцсоноор борлуулалтаа хийж чаддаг, үүнд бид их баярладаг. Харин дэлгүүрээр бүтээгдэхүүнээ борлуулах гэхээр их хэцүү. Түрээс дор хаяж 1 сая 500 мянга төгрөг байдаг, дэлгүүрийн түрээс төлөх, худалдагчийн цалин өгөх, үйлдвэрлэлийн түүхий эдийн зардлаа нөхөхөд хэцүү. Бид өөрсдөө дэлгүүр ажиллуулах боломж бараг байдаггүй.

Нэг удаа олгох зээлийн дээд хэмжээ таны бизнест хангалттай хүрэлцээтэй байна уу? (§11.6)

Хүсэлт өгөөд зээл авч чадаагүй.

Сонгон шалгаруулалтад төслийн саналаа мэдүүлэхэд хүндрэл, бэрхшээл тулгардаг уу? Тийм бол ямар?

Төслөө яг цаг хугацаанд нь өгдөг. Тэгээд яасан нь мэдэгдэхгүй байж байгаад сарын дараа тэнцээгүй гэдэг хариу өгсөн. Ил тод байдал байгаагүй, яаж сонгон шалгаруулсан нь ойлгомжгүй. Яагаад хамрагдаагүй талаар мэдээлэлгүй.

Хөнгөлөлттэй зээл олгохгүй дараах нөхцөлүүдээс аль нь жижиг дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдэд санхүүгийн дэмжлэг авахад хамгийн их хүндрэл учруулдаг вэ? (§11.11)

1. Сангаас авсан зээлийн үлдэгдэлтэй;
2. Зээлийн мэдээллийн санд муу зээлийн түүхтэй;
3. Сангаас авсан зээлийг зориулалтын бусаар ашигласан нь тогтоогдсон;
4. Шүүхийн шийдвэрээр бусдад төлөх өртэй;
5. Төсөл хүлээн авах сүүлийн өдрийн байдлаар нийгмийн даатгал, татварын байгууллагад өртэй.

Би өр ширгүй явахыг хичээдэг. Эдгээр нөхцөлүүдээс татварын асуудал хэцүү байдаг.

Та жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдэд төрөөс татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн дэмжлэг үзүүлдэг талаар хэр мэдээлэлтэй байдаг вэ? (§8.1.3)

Мэдээлэл байхгүй.

Та татварын хөнгөлөлт, чөлөөлөлтөд хамрагддаг уу? Хэрвээ тийм бол ямар хэлбэрийн татварын хөнгөлөлт, чөлөөлөлтөд хамрагддаг вэ? Энэхүү хөнгөлөлт танд бодит дэмжлэг болж чаддаг уу?

Үгүй.

Төрөөс экспортыг нэмэгдүүлэх, импортыг орлох өрсөлдөх чадвартай бүтээгдэхүүний үйлдвэрлэл, үйлчилгээг дэмждэг талаар мэдэх үү? Хэрвээ тийм бол ийм төрлийн дэмжлэгт хамрагдаж байсан уу? Дэмжлэгт хамрагдахад хүндрэл, бэрхшээл гарч байсан уу? Тийм бол ямар? (§8.1.4)

Манайх бүтээгдэхүүнээ албан ёсоор экспортолж амжаагүй. Урагшаа наймаа хийдэг хүмүүс, үзэсгэлэнд оролцдог хүмүүс манайд захиалга өгч 40-50 ширхэгээр авдаг, хойшоо ч мөн захиалж авдаг хүмүүс бий. 2013 онд Москвагаас сертификат авч, Улаан-Үдийн нэг компанитай хамтарч монгол барааны дэлгүүр нээж байсан. Гэвч орос ажилтан, нягтлан авах шаардлага тавигдаж, өөрөө байнга очиж хянаж чадахгүйгээс бараа алдагдах гэх мэт бэрхшээл гарч, явц нь хэцүү байсан тул болиулсан. Тухайн үед төрөөс ямар нэг дэмжлэг аваагүй, өөрөө ч хандаагүй.

Монгол ноос, ноолууран бүтээгдэхүүнээ экспортод гаргахад төр анхаарч, холбож өгөөсэй гэж хүсдэг. Дотоодын жижиг зах зээлд үнэ нэмэх боломжгүй, олон жил ижил үнээр зарагдаж байна. Импортоор орж ирж буй барааг хязгаарлах нь чухал гэж боддог. Бид нэхий, гутлаа өөрсдөө хийж байгаа ч урдаас ижил төрлийн бүтээгдэхүүн ихээр орж ирдэг. Хятадын ноосыг авч ашигладаг ч, ингэснээр дотоодын ээрмэл утасны үйлдвэрүүд алдагдал хүлээж байдаг. Тиймээс импортын татварыг нэмэх, эсвэл хязгаарлаж, дотоодын үйлдвэрлэлийг хамгаалах бодлого хэрэгтэй гэж үздэг.

Та төрөөс бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний борлуулалтад төрийн худалдан авалтаар дэмжлэг үзүүлдэг талаар мэдэх үү? Та төрийн худалдан авах ажиллагаанд оролцож байсан уу? Хэрвээ тийм бол энэ дэмжлэгийг авч чадсан уу? (§8.1.5)

Компаниуд төрийн худалдан авалтад оролцдог гэж сонссон ч манайх оролцож байгаагүй. "Цагаан алт" хөтөлбөрийн хүрээнд Ноос, ноолуурын холбоо гишүүдээ цэргийн болон нисэх хүчний хувцас оёход оролцуулах талаар ярьж байсан ч ихэвчлэн том үйлдвэрүүд авч хийдэг, бидэнд боломж олддоггүй. Бид ч гэсэн адилхан бүтээгдэхүүн үйлдвэрлэж, шаардлагыг хангах боломжтой. Хэрэв хамрагдаж чадвал бид ч ажиллах хүсэлтэй, ажлын хувцас зэрэг юу ч хийж чадна.

Та жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ дэмжих төрийн байгууллагуудаас бизнесийн зөвлөгөө авч байсан уу? Хэрвээ тийм бол та өөрт хэрэгцээтэй зөвлөгөө, мэдээллийг авч чадсан уу? Та хэрхэн үнэлэх вэ? (§8.1.6)

Нийслэл, дүүргийн ЖДҮ дэмжих төвүүдтэй холбоотой ажилладаг. Сүүлийн 2-3 жил ЖДҮ-ийн асуудал ихээр яригдаж, ажил идэвхжиж байна. Өмнө нь төрийн байгууллагууд ихэнхдээ сургалт санал болгодог ч бусад төрлийн дэмжлэгийн мэдээлэл сайн өгдөггүй байсан, өөрөө ч мэдээлэл авахгүй өнгөрдөг байсан. Одоо зөвлөгөө, мэдээлэл авах боломжтой болсон. Гэхдээ хувь хүн өөрөө идэвхтэй байх хэрэгтэй байдаг. Би өөрөө нийгмийн ухааны багш хүн тул хууль эрх зүйн мэдлэг дутмаг, хуулиа сайн мэддэггүй. Идэвхгүй хандах үе ч байдаг.

Та шинэ бүтээгдэхүүн хөгжүүлэх эсхүл бүтээмжийг нэмэгдүүлэх судалгаа зэрэгт төрөөс дэмжлэг үзүүлдэг талаар мэдэх үү? Тийм бол дэмжлэг авахаар оролдож байсан уу? Ямар хүндрэл, бэрхшээл гарч байсан бэ? (§8.1.7)

Шинэ зүйлийг өөрсдөө л зохицуулж хийдэг. Яг төрөөс дэмждэг талаар мэдэхгүй. Хамрагдаж байгаагүй.

Төрөөс техник, технологийн дэвшлийг дамжуулах, нутагшуулах, шинжлэх ухаан, технологийн судалгааны үр дүнг үйлдвэрлэлд нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлдэг талаар та хэр сайн мэдэх вэ? (§8.1.8)

2 жилийн өмнөөс инновац, инновац шингэсэн бүтээгдэхүүн гэж яригдаад л байгаа. Манайх энэ төрлийн дэмжлэгт хамрагдаагүй, сайн мэдэхгүй.

Та кластерын талаар хэр сайн ойлголттой вэ? (§8.1.9) Танай компани үйл ажиллагаагаа эрхлэхдээ кластераар ажилладаг уу? Ийм хэлбэрээр ажиллахад төрөөс дэмжлэг авч байсан уу?

Кластер маш чухал гэж үздэг. Манай бүтээгдэхүүн 21 дамжлагатайгаар үйлдвэрлэгддэг тул кластераар ажиллавал илүү үр дүнтэй байх болов уу гэж боддог. Европын холбоонд ноос, ноолууран бүтээгдэхүүний экспортыг дэмжих кластер байдаг, бид энэ оны 3-р сард гишүүнээр элссэн. Гишүүд нэгдэж арга хэмжээнд оролцож, бүтээгдэхүүнээ гадаадад гаргах зорилготой ажиллаж байна. Гадаадад бүтээгдэхүүнээ гаргахад бичиг баримт бүрдүүлэх асуудал тулгардаг тул төрөөс дэмжлэг хэрэгтэй. Харин кластерын хүрээнд төрөөс дэмжлэг байдаггүй, холбооны зүгээс түрээс төлөх, үзэсгэлэнд оролцуулах байдлаар дэмжлэг үзүүлдэг.

Танай бүтээгдэхүүн үйлчилгээ гадаад, дотоод зах зээлд гарахдаа төрөөс ямар нэгэн дэмжлэг авч байсан уу? (§8.1.10) (жишээ нь дотоодын болон олон улсын үзэсгэлэн худалдаа зохион байгуулах, оролцох зэрэг)

Тийм.

Хэрвээ авсан бол ямар? Энэ дэмжлэг нь гадаад, дотоод зах зээлд гарахад бодитой дэмжлэг болж чадсан уу?

Үзэсгэлэнд оролцдог. Төв талбайд ч байсан, хөдөө ч байсан, хаана л бол хаана үзэсгэлэн худалдаанд оролцохыг хичээдэг. Бүтээгдэхүүнээ борлуулахад дээр байдаг.

Таны бодлоор Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хууль хэр зэрэг хэрэгжиж байна? Яагаад?

Яг үнэндээ хуулиа ч тодорхой сайн мэдэхгүй.

Нэмж хэлэх санал

Өөрсдөө дотооддоо хийж чадахгүй тоног төхөөрөмж зэргээс бусад өөрсдөө үйлдвэрлэдэг бүтээгдэхүүний хувьд дотоодын үйлдвэрлэлээ хамгаалах бодлого чухал.

Үйлдвэрлэл явуулахад шаардлагатай тоног төхөөрөмжийн сурталчлах ажил бас чухал санагддаг.

Бичил бизнесүүдэд дэмжлэг илүү их хэрэгтэй. Яагаад гэвэл бичил бизнесүүд барьцаа хөрөнгө гэх зүйл байхгүй учир зээл авч чаддаггүй. Тэгээд банк бусаас өндөр хүүтэй зээл авахад хүрдэг. Жишээ нь би зун жуулчны улирлаар бүтээгдэхүүнээ зарчих санаатай ажилладаг, гэтэл утас авах мөнгө байхгүй, хөнгөлөлттэй зээлд хамрагдаж чадахгүй учраас банк бусаас 3.4 хувийн өндөр хүүтэй зээл аваад ажиллаж байна.

ЖИЖИГ, ДУНД ҮЙЛДВЭР, ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭГЧ 3

Та (танай ажилчид) жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжих төвөөс зохион байгуулсан сургалтад хамрагдаж байсан уу? Үгүй бол яагаад? Сургалт зохион байгуулагдаж байгаа талаар мэдээлэл авч чаддаггүй эсвэл сургалтын агуулга таалагдаагүй юу? (§8.1.1)

Тийм. Баянгол, Сүхбаатар дүүргийн ЖДҮ дэмжих хэлтсээс зохион байгуулсан сургалтуудад хамрагдаж байсан. Гэвч сургалтын талаарх мэдээлэл хоцорч ирдэг, сургалт дууссаны дараа л мэддэг. Судалгаанд хамрагдаж буй шигээ сургалт болохоос өмнө мэдээллээ өгч, бүртгэлд хамруулдаг бол сургалтад оролцож, бизнесээ дэмжүүлэх, гадаад, дотоодын хөрөнгө оруулагчидтай B2B уулзалтад оролцох боломж бүрдэх тул хэрэгтэй гэж үздэг. Манайх Баянгол дүүргийн ЖДҮ эрхлэгчдийн холбоонд гишүүнээр элссэн. Холбооноос зохион байгуулсан сургалтуудад хамрагдаж мэдээлэл авдаг.

Хэрвээ тийм бол тухайн сургалтаас таны бизнесийн хэрэгцээнд нийцсэн мэдээлэл, зөвлөгөө авах боломж хэр байсан бэ?

Сургалтууд хэрэгтэй, үр дүнтэй байдаг. Гадаад, дотоодын хөрөнгө оруулагч нартай уулзаж, B2B гэрээ, санамж бичгийн хүрээнд бэлтгэн нийлүүлэгч, туслан гүйцэтгэгчээр хамтран ажиллах боломжийг нээж өгөх нь их хэрэгтэй байна.

Сургалтын чанар, хүртээмж, агуулга нь зах зээлийн эрэлт хэрэгцээтэй хэр зэрэг нийцэж байсан талаар та бодлоо хуваалцаач?

Хэрэгцээтэй байж чаддаг. Сүүлийн 5 жилд 4 удаа хамрагдсан.

Та Жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдэд

(1) хөнгөлөлттэй зээл олгох, (2) шинээр бий болгосон ажлын байрны тоо, борлуулалтын орлогын хэмжээг харгалзан зээлийн хүүгийн хэмжээг бууруулах, (3) зээлийн давхар батлан даалт гаргах, (4) зээлийн хүүгийн татаас олгох, (5) тоног төхөөрөмжийн санхүүгийн түрээсийн үйлчилгээ, түрээсийн хүүгийн дэмжлэг үзүүлэх зэргээр санхүүгийн дэмжлэг үзүүлдэг талаар мэдэх үү? (§8.1.2), (§11.3)

Энэ дэмжлэгүүдийн талаар мэдээлэлтэй байдаг. Гэхдээ алийг нь ч авч чаддаггүй. Жишээ нь дэлгүүрүүд манайд зорсон мах нийлүүлэгч гэсэн хүсэлт байнга тавьдаг. Гэтэл одоо зах зээл дээр Буян-Ундарга гээд ганц компани монополь. Энэ компани ганцаараа зах зээлээ хангаж чадахгүй, зэрэгцээд манайх бас зорсон мах, татсан мах, калбижан мах нийлүүлмээр байдаг. Тэгэхээр тоног төхөөрөмж бас ажлын байр их чухал. Манайх нэг хэсэг Гэгээ гээд захад ажлын байр түрээсэлдэг байсан чинь эзэн нь СУ-д өгнө гээд их олон компани ажлын байргүй болсон. Өөрийн гэсэн ажлын байргүй, түрээсэлдэг болохоор бас хэцүү. Одоо манайх Баянгол дүүрэгт түрээсийн байранд үйл ажиллагаа явуулдаг. Тэр нь хүнсний зориулалттай биш хувцасны чиглэлийнх. Ер нь бид нарт хүнсний зориулалттай шаардлага хангасан ажлын байраар хангах дэмжлэг маш их хэрэгтэй. Бас тоног төхөөрөмжтэй болоход дэмжлэг хэрэгтэй. Манай бизнест худалдан авах зах зээл нь байна. Зарим газарт мах зүсдэг тоног төхөөрөмж, хөлдөөгч гээд байх юм, тэрийгээ хэрэглэхгүй зарна гээд. Ямар хүмүүст дэмжлэг нь олноод, тэр нь ашиглагдахгүй илүүдээд байдаг юм бол. Тэр илүүдээд байгаа хүмүүс ядаж тоног төхөөрөмжөө бидэнд түрээсэлдэг бол зүгээр юм. Би хамрагдаж гэж хүсээд ч авч чаддаггүй. Би Баянгол дүүрэгт ийм төсөл хэрэгжүүлмээр байгаа, тоног төхөөрөмж олгоод өгөөч гээд хүсэлтээ өгсөн. Сүхбаатар дүүрэгт хандахаар улс төрийн нөхцөл байдлаас болоод юмуу, шийдвэр гаргахдаа маш удаан. Хэрэв би тоног төхөөрөмжийн дэмжлэг авч чадвал Хэнтий, Дорнодоос мах авдаг хүнтэй учраас ажлын байр түрээсэлдэг махан бүтээгдэхүүний бизнесээ өргөжүүлэх боломжтой. Манай бизнесийн хувьд нэгдүгээрт ажлын байр, хоёрдугаарт тоног төхөөрөмж, гуравдугаарт эргэлтийн хөрөнгө чухал хэрэгцээтэй байна. Дэмжээд өгвөл маш чухал байна. Түрээсийн байранд үйл ажиллагаа явуулахад хэцүү. Түрээсийн гэрээгээ нэг нэг жилээр сунгадаг, ядаж 5 жилээр байдаг бол. Тэгээд илүү өндөр түрээс төлөх хүн гараад ирвэл надтай байгуулсан гэрээгээ цуцална. ЖДҮү дэмжих төвүүд үйлдвэр эрхлэгчдэд байр түрээсэлдэг, гэхдээ ноос ноолуур, хувцас, эсгий шаахайн үйлдвэрүүдэд голдуу түрээсэлдэг.

Хэрвээ тийм бол хаанаас мэдээлэл авч байсан бэ?

Facebook хуудсуудаас, холбооноос, сургалтад хамрагдсан хүмүүсийн группээс мэдээлэл авдаг. ЖДҮ эрхлэгчид адил асуудалтай тул бие биедээ мэдээлэл дамжуулж, арга хэмжээнд хамт оролцох, дэмжих

нь нэмэгдэж байгаа. Нэгдэж хоршоо байгуулаад хамтран ажиллах нь илүү үр дүнтэй гэж боддог, энэ санааг төрөөс чиглүүлэн дэмжээсэй гэж хүсдэг.

Төрөөс үзүүлж байгаа дэмжлэгүүдэд хэрхэн хамрагдах, төслийн материал бэлдэх зэрэг асуудлаар төрийн байгууллагын холбогдох албан хаагчдаас тусламж авч байсан уу? Хэрвээ тийм бол ямар нэгэн хүндрэл бэрхшээл гарч байсан уу? Хүссэн мэдээллээ авч чадсан уу?

Төрийн албан хаагчид хандаж байгаагүй, би өмнө төрийн албанд ажиллаж байсан болохоор бичиг цаасны ажил болон төслөө өөрөө бичдэг. Ер нь төрийн албан хаагч нар их хүнд сурталтай, бас бид нарын мэдэж байгаа мэдээллээс ч муу мэдээлэлтэй байдаг. Бизнес хийж байгаа хүнд цаг бол алт шиг үнэтэй болохоор тийшээ очиж уулзаад байх цаг зав гарахгүй. Тэрний оронд өөрсдөө утсаар асууна, онлайнаар мэдээлэл авна. Мөн сургалтад суух явцдаа мэдэхгүй, чадахгүй, ойлгохгүй байгаа зүйлээ хүмүүсээс асуугаад авдаг.

Та Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх санд хөнгөлөлттэй зээлд хамрагдахаар материалаа явуулж байсан уу? Өөрийн материалдаа хэр итгэлтэй байсан бэ? Хөнгөлөлттэй зээлд хамрагдаж чадсан уу?

Тийм. 2023 онд хүсэлт өгсөн, өөрийнхөө материалдаа итгэлтэй байсан. Нөхөртэйгөө хамт төслөө бичиж, хөрөнгө оруулалтын өгөөж, ашиг, зах зээлийн судалгаа гээд бүх тооцооллоо сайн хийсэн. Гэвч хамрагдаж чадаагүй.

Та Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох төслийн сонгон шалгаруулалт хэр зэрэг шударга, ил тод явагддаг гэж бодож байна?

2023, 2024 онд их бүрхэг байсан. Би бусад хүмүүст төсөл бичихэд нь тусалдаг. Энэ жил Төв, Дархан, Сэлэнгэ аймгийн сонгон шалгаруулалтыг харсан. Урьд нь юу болж байгаа нь мэдэгдэхгүй таг алга болчихдог байсан. Энэ жилийн хувьд хүнд сурталгүй, явц юу болж байгаа талаар цаг тухайд нь хурдан хариу өгдөг, мэдээлэл илүү ил тод болсон байна.

Уг нь Улаанбаатарт хүн ам илүү төвлөрсөн байхад энэ жил хөнгөлөлттэй зээл олголт нь зөвхөн төвийн бүсийнхэнд (Төв, Дархан, Сэлэнгэ) олгохоор болсон. Энэ нь бид нарын боломжийг хязгаарлаж байна. Тэгэхээр нь би хөдөө шилжээд зээлд хамрагддаг юмуу гэж бодсон. Даанч хүүхдүүд энд сургуульд явдаг болохоор чадаагүй.

Төслийн сонгон шалгаруулалтад оролцоход шаардлагатай баримт, материал, тавигдах шалгуур хэр зэрэг практикт нийцсэн гэж үзэж байна?

Материал бүрдүүлэхэд асуудал гараагүй.

Нэг удаа олгох зээлийн дээд хэмжээ таны бизнест хангалттай хүрэлцээтэй байна уу? (§11.6)

(Хүсэлт өгөөд зээл авч чадаагүй). Хэрэв зээл авч чадвал хангалттай хүрнэ, би тооцоо хийж үзсэн.

Сонгон шалгаруулалтад төслийн саналаа мэдүүлэхэд хүндрэл, бэрхшээл тулгардаг уу? Тийм бол ямар?

Би төслөө онлайнаар мэдүүлдэг. Гэхдээ систем нь дахин дахин гацаад байсан учраас өөрөө биеэрээ очсон. Би ямар асуудал байгаа талаар тодруулж асуухад ЖДҮ хариуцсан ажилтан нэг өөр тайлбар хэлээд, IT хариуцсан мэргэжилтэн бас өөр тайлбар хэлээд, 2 өөр тайлбар хэлээд байхаар хэцүү байсан. Өөр ойлгомжгүй асуудал гараагүй.

Хөнгөлөлттэй зээл олгохгүй дараах нөхцөлүүдээс аль нь жижиг дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдэд санхүүгийн дэмжлэг авахад хамгийн их хүндрэл учруулдаг вэ? (§11.11)

1. Сангаас авсан зээлийн үлдэгдэлтэй;
2. Зээлийн мэдээллийн санд муу зээлийн түүхтэй;
3. Сангаас авсан зээлийг зориулалтын бусаар ашигласан нь тогтоогдсон;
4. Шүүхийн шийдвэрээр бусдад төлөх өртэй;
5. Төсөл хүлээн авах сүүлийн өдрийн байдлаар нийгмийн даатгал, татварын байгууллагад өртэй.

Та жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдэд төрөөс татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн дэмжлэг үзүүлдэг талаар хэр мэдээлэлтэй байдаг вэ? (§8.1.3)

Мэдээлэл байхгүй. Сонсоогүй.

Та татварын хөнгөлөлт, чөлөөлөлтөд хамрагддаг уу? Хэрвээ тийм бол ямар хэлбэрийн татварын хөнгөлөлт, чөлөөлөлтөд хамрагддаг вэ? Энэхүү хөнгөлөлт танд бодит дэмжлэг болж чаддаг уу?

Хамрагдаагүй.

Төрөөс экспортыг нэмэгдүүлэх, импортыг орлох өрсөлдөх чадвартай бүтээгдэхүүний үйлдвэрлэл, үйлчилгээг дэмждэг талаар мэдэх үү? Хэрвээ тийм бол ийм төрлийн дэмжлэгт хамрагдаж байсан уу? Дэмжлэгт хамрагдахад хүндрэл, бэрхшээл гарч байсан уу? Тийм бол ямар? ; (§8.1.4)

Энэ талаар сонсож байсан гэхдээ хамрагдаж байгаагүй. Цагаан алт хөтөлбөр гэнэ, их олон хөтөлбөр байдаг. Яг үнэндээ цаасан дээр л сайхан сайхан зүйл байдаг боловч яг бодит дэмжлэг, үр дүн байдаггүй. Миний мэдэх бизнес эрхлэгчдийн хувьд ийм төрлийн дэмжлэгт хамрагдсан гэж сонсоогүй.

Та төрөөс бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний борлуулалтад төрийн худалдан авалтаар дэмжлэг үзүүлдэг талаар мэдэх үү? Та төрийн худалдан авах ажиллагаанд оролцож байсан уу? Хэрвээ тийм бол энэ дэмжлэгийг авч чадсан уу? (§8.1.5)

Төрийн худалдан авалтад оролцож байсан. Баянгол дүүргийн сургалтад цай, кофе нийлүүлж, 1-р сургуульд мах нийлүүлсэн. Гэхдээ төлбөр орж ирэх хугацаа их удах тул хэцүү, заримдаа ашиггүй байх тохиолдол гардаг. Манай бизнест эргэлтийн мөнгө чухал байдаг.

Та жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ дэмжих төрийн байгууллагуудаас бизнесийн зөвлөгөө авч байсан уу? Хэрвээ тийм бол та өөрт хэрэгцээтэй зөвлөгөө, мэдээллийг авч чадсан уу? Та хэрхэн үнэлэх вэ? (§8.1.6)

Төрийн байгууллагад өөрөө очиж зөвлөгөө авч байгаагүй. Харин Содура Консалтинг зэрэг зөвлөх үйлчилгээ үзүүлдэг компаниуд, төрийн бус байгууллагын менторуудаас зөвлөгөө авдаг.

Та шинэ бүтээгдэхүүн хөгжүүлэх эсхүл бүтээмжийг нэмэгдүүлэх судалгаа зэрэгт төрөөс дэмжлэг үзүүлдэг талаар мэдэх үү? Тийм бол дэмжлэг авахаар оролдож байсан уу? Ямар хүндрэл, бэрхшээл гарч байсан бэ? (§8.1.7)

Мэдэхгүй. Хамрагдаагүй.

Төрөөс техник, технологийн дэвшлийг дамжуулах, нутагшуулах, шинжлэх ухаан, технологийн судалгааны үр дүнг үйлдвэрлэлд нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлдэг талаар та хэр сайн мэдэх вэ? (§8.1.8)

Энэ талаар мэдээлэл муутай. Шинжлэх ухааны академи, Мал эмнэлэгийн хүрээлэн, Биологийн хүрээлэн зэрэг байгууллагуудтай хувийн хэвшлийнхэн хамтарч ажиллах боломж нээж өгвөл зүгээр байх гэж боддог.

Та кластерын талаар хэр сайн ойлголттой вэ? (§8.1.9) Танай компани үйл ажиллагаагаа эрхлэхдээ кластераар ажилладаг уу? Ийм хэлбэрээр ажиллахад төрөөс дэмжлэг авч байсан уу?

Кластерийн талаар ойлголттой. Төрөөс энэ чиглэлээр дэмжлэг аваагүй. Манай мах махан бүтээгдэхүүний бизнесийн хувьд хөдөө малчдаас мах авахад намайг холбож өгдөг нэг хүн бий. Иймэрхүү байдлаар бид хоорондоо сүлжээ үүсгээд ажиллахад илүү үр дүнтэй. Кластераар ажиллах их чухал бие биедээ тустай байдаг.

Танай бүтээгдэхүүн үйлчилгээ гадаад, дотоод зах зээлд гарахдаа төрөөс ямар нэгэн дэмжлэг авч байсан уу? (§8.1.10) (жишээ нь дотоодын болон олон улсын үзэсгэлэн худалдаа зохион байгуулах, оролцох зэрэг)

Тийм.

Хэрвээ авсан бол ямар? Энэ дэмжлэг нь гадаад, дотоод зах зээлд гарахад бодитой дэмжлэг болж чадсан уу?

Намрын өдрүүд зэрэг дотоодын үзэсгэлэн худалдаанд оролцдог. Өөр дэмжлэгт хамрагдаж байгаагүй. Үзэсгэлэнд оролцоход заримдаа түрээс өндөр байдаг. Жишээ нь наадмаар болох үзэсгэлэнгийн түрээс 250 мянган төгрөг, 3 өдөр гарахаар 750 мянга төгрөг болно. Төр нь мөнгө олох гээд байна уу, ЖДҮ-гээ дэмжих гээд байна уу. Түрээс өндөр байгааг анхаарах хэрэгтэй.

Таны бодлоор Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хууль хэр зэрэг хэрэгжиж байна? Яагаад?

Хууль байгаа нь сайхан. Гэхдээ хуулийн хэрэгжилтийн хувьд дэмжлэг нь яг эзэндээ хүрэхгүй байна.

Нэмж хэлэх санал

Төрөөс үзүүлж байгаа дэмжлэгийг яг эзэнд нь хүргэх хэрэгтэй. Одоо ч гэсэн танил тал харах, хувь өгдөг гэх асуудлууд байсаар байна. Бид дэмжлэг авч чадвал бизнесээ өргөжүүлээд дараагийн ангилалд орох боломжтой.

Манайд үйлдвэрлэгч нар бүтээгдэхүүнээ үйлдвэрлээд, тэрийгээ өөрсдөө борлуулдаг. Энэ нь бизнес эрхлэгчдэд үнэхээр их ачаалалтай. Зарим нь бүтээгдэхүүнээ худалдаж чадахгүйгээс болж, бизнес нь явж чадахгүй байх тохиолдол байна.

Би Япон руу ажлаар явах үеэр махны чиглэлийн үхрийн аж ахуйтай фермерийн ажилтай танилцсан. Тэр хүн зөвхөн үхрээ бордож, тэжээх ажилдаа л санаа тавьдаг. Тэгээд үхэр нь 300 кг болж, стандарт шаардлагад хүрэхээр цахимаар мэдээллээ өгдөг. Тэгэнгүүт зуучлан борлуулагч компани ирээд үхрийг аваад явдаг. Фермер борлуулах асуудалд толгой өвдөхгүй. Манайд иймэрхүү тогтолцоо, бодитой дэмжлэг хэрэгтэй.

ЖДҮ дэмжихэд чиглэсэн төрийн байгууллагуудын уялдаа холбоог сайжруулах, чиг үүргийг оновчтой болгох шаардлагатай. Энэ олон байгууллага нэг нь нэг юм ярина, нөгөө нь өөр юм ярина. Хоорондоо уялдаа холбоо муу, бие биеэ үгүйсгээд байгаа ч юм шиг, хамтраад ч байгаа юм шиг ойлгомжгүй. ЖДҮ газар болон нийслэлийн байгууллага нь бодлого тодорхойлоод, хэрэгжилтийг аймаг, дүүргийн байгууллагууд бид нартай илүү ойр ажилладаг болохоор түлхүү хийвэл оновчтой гэж бодож байна. Хуульд заасан, түрүүн дурдагдсан санхүүгийн дэмжлэгүүдийг авах хүсэлтэй байдаг ч авч чадахгүй байна. Дэмжлэгтэй холбоотой мэдээллээ цаг тухайд нь сайн хүргээдэг баймаар байна, зарим тохиолдолд мэдээлэл дутмаг байдаг.

ЖИЖИГ, ДУНД ҮЙЛДВЭР, ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭГЧ 4

Та (танай ажилчид) жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжих төвөөс зохион байгуулсан сургалтад хамрагдаж байсан уу? Үгүй бол яагаад? Сургалт зохион байгуулагдаж байгаа талаар мэдээлэл авч чаддаггүй эсвэл сургалтын агуулга таалагдаагүй юу? (§8.1.1)

Сая хэлсэн сав баглаа боодолтой холбоотой сургалтад сүүлийн 5 жилд нэг удаа, 2023 онд хамрагдсан. Манай ЖДҮ эрхлэгчид бүх зүйлээ өөрсдөө хийдэг болохоор зав муутай. Тиймээс сургалтуудад суух боломжгүй. Мэдээлэл ч дутмаг хүрдэг.

Хэрвээ тийм бол тухайн сургалтаас таны бизнесийн хэрэгцээнд нийцсэн мэдээлэл, зөвлөгөө авах боломж хэр байсан бэ?

Ер нь мэдээлэл өгдөг. Би дээр дурдсан сургалтад суухаас өмнө манайх сав баглаа боодлынхоо дизайн, бүх зүйлийг гаргасан байсан. Би төрийн байгууллагын сургалтаас гадна “Хөгжлийн шийдэл” ТББ-аас явуулдаг сургалтад хамрагддаг. Миний хувьд тэр нь илүү үр дүнтэй санагдсан. Төрийн байгууллагын сургалтын багш нар учир дутагдалтай санагдсан. Сэтгэлд хүрээгүй.

Сургалтын чанар, хүртээмж, агуулга нь зах зээлийн эрэлт хэрэгцээтэй хэр зэрэг нийцэж байсан талаар та бодлоо хуваалцаач?

Хүн хүний хэрэгцээнээс шалтгаална. Миний хувьд тийм ч нийцтэй байгаагүй. Би ТББ-аас явуулдаг олон сургалтад сууж байсан. Жишээ нь, Швейцар улсад төвтэй BPN төрийн бус байгууллагын сургалтууд маш чанартай байдаг. Жилд 2-3 сургалтад суудаг, төлбөргүй. Сургалтууд нь чанартай, хөрсөн дээрээ буусан. ЖДҮ эрхлэгч бидэнд хэрэгтэй мэдээлэл өгдөг. Мөн “Хөгжлийн шийдэл” ТББ-ийн Best хөтөлбөрийн хүрээнд сургалтад хамрагдсан. Тэр нь бас зүгээр байсан.

Та Жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдэд

(1) хөнгөлөлттэй зээл олгох, (2) шинээр бий болгосон ажлын байрны тоо, борлуулалтын орлогын хэмжээг харгалзан зээлийн хүүгийн хэмжээг бууруулах, (3) зээлийн давхар батлан даалт гаргах, (4) зээлийн хүүгийн татаас олгох, (5) тоног төхөөрөмжийн санхүүгийн түрээсийн үйлчилгээ, түрээсийн хүүгийн дэмжлэг үзүүлэх зэргээр санхүүгийн дэмжлэг үзүүлдэг талаар мэдэх үү? (§8.1.2), (§11.3)

Яг дэлгэрэнгүй нарийн мэдэхгүй. Хөнгөлөлттэй зээл байдгийг мэднэ. Хүнсний хувьсгалын хөтөлбөрт нэг удаа хамрагдаж байсан. Зээлийн батлан даалтын сан гэж сонсож байсан. Үүнийг өөрөө хөөцөлдөж үзээгүй, мэдэхгүй. Хүмүүсийн ярианаас сонсоход хэцүү гэдэг. Бусад дэмжлэгийн талаар мэдэхгүй, сонсож байгаагүй.

Хэрвээ тийм бол хаанаас мэдээлэл авч байсан бэ?

Дэмжлэгийн талаарх мэдээллийг харилцагч банкнаасаа авдаг. Хөнгөлөлттэй зээлийн мэдээллийг ЖДҮ газрын цахим хуудаснаас авдаг.

Төрөөс үзүүлж байгаа дэмжлэгүүдэд хэрхэн хамрагдах, төслийн материал бэлдэх зэрэг асуудлаар төрийн байгууллагын холбогдох албан хаагчдаас тусламж авч байсан уу? Хэрвээ тийм бол ямар нэгэн хүндрэл бэрхшээл гарч байсан уу? Хүссэн мэдээллээ авч чадсан уу?

Үгүй, авч байгаагүй.

Та Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх санд хөнгөлөлттэй зээлд хамрагдахаар материалаа явуулж байсан уу? Өөрийн материалдаа хэр итгэлтэй байсан бэ? Хөнгөлөлттэй зээлд хамрагдаж чадсан уу?

Материал явуулж байгаагүй.

Та Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох төслийн сонгон шалгаруулалт хэр зэрэг шударга, ил тод явагддаг гэж бодож байна?

-

Төслийн сонгон шалгаруулалтад оролцоход шаардлагатай баримт, материал, тавигдах шалгуур хэр зэрэг практикт нийцсэн гэж үзэж байна?

Энэ жил хүсэлт өгье гэж бодсон. Гэвч Улаанбаатар хотод биш, зөвхөн төвийн бүсэд Дархан, Сэлэнгэ, Төв аймагт олгогдоно гэсэн. Үүнийг дагаад хөдөө нүүж амьдрах боломжгүй. Сүүлийн үед бүсчилсэн хөгжил гэж их яригдаж байгаа, түүнтэй холбоотой орон нутгийн ААН-үүдийг дэмжих зорилготой хийсэн байх. Гэхдээ энэ нь хотын ААН-үүдийн боломжийг хязгаарлаж байна.

Нэг удаа олгох зээлийн дээд хэмжээ таны бизнест хангалттай хүрэлцээтэй байна уу? (§11.6)

Зээлийн хэмжээ 300 сая төгрөг хүртэл бол арилжааны банкаар дамжихгүй, ЖДҮ газар шууд олгож болдог, энэ хэмжээнээс дээш бол банкаар дамждаг. Хэрэв би 300 саяын зээл авч чадвал хүрэлцээтэй эсэх нь ямар үйл ажиллагаа явуулахаас шалтгаална. 300 сая аваад бизнес шууд цэцэглэхгүй. Хэрэв би ажлын байраа сайжруулъя гэвэл 300 сая багадаа байх гэж бодож байна.

Сонгон шалгаруулалтад төслийн саналаа мэдүүлэхэд хүндрэл, бэрхшээл тулгардаг уу? Тийм бол ямар?

-

Хөнгөлөлттэй зээл олгохгүй дараах нөхцөлүүдээс аль нь жижиг дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдэд санхүүгийн дэмжлэг авахад хамгийн их хүндрэл учруулдаг вэ? (§11.11)

1. Сангаас авсан зээлийн үлдэгдэлтэй;
2. Зээлийн мэдээллийн санд муу зээлийн түүхтэй;
3. Сангаас авсан зээлийг зориулалтын бусаар ашигласан нь тогтоогдсон;
4. Шүүхийн шийдвэрээр бусдад төлөх өртэй;
5. Төсөл хүлээн авах сүүлийн өдрийн байдлаар нийгмийн даатгал, татварын байгууллагад өртэй.

Сангаас авсан зээлийн үлдэгдэлтэй байвал гэж байгаа. Үүнийг огт зээлгүй байх гэхээс илүү тодорхой хувь тогтоовол, тухайлбал өмнө авсан зээлийн 70 хувийг төлсөн байх гэвэл илүү зөв санагдсан. Бусад нөхцөл нь ойлгомжтой.

Та жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдэд төрөөс татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн дэмжлэг үзүүлдэг талаар хэр мэдээлэлтэй байдаг вэ? (§8.1.3)

Мэдэхгүй.

Та татварын хөнгөлөлт, чөлөөлөлтөд хамрагддаг уу? Хэрвээ тийм бол ямар хэлбэрийн татварын хөнгөлөлт, чөлөөлөлтөд хамрагддаг вэ? Энэхүү хөнгөлөлт танд бодит дэмжлэг болж чаддаг уу?

Үгүй.

Төрөөс экспортыг нэмэгдүүлэх, импортыг орлох өрсөлдөх чадвартай бүтээгдэхүүний үйлдвэрлэл, үйлчилгээг дэмждэг талаар мэдэх үү? Хэрвээ тийм бол ийм төрлийн дэмжлэгт хамрагдаж байсан уу? Дэмжлэгт хамрагдахад хүндрэл, бэрхшээл гарч байсан уу? Тийм бол ямар? ; (§8.1.4)

Энэ дэмжлэг ямар шугамаар явдагийг сайн мэдэхгүй.

Та төрөөс бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний борлуулалтад төрийн худалдан авалтаар дэмжлэг үзүүлдэг талаар мэдэх үү? Та төрийн худалдан авах ажиллагаанд оролцож байсан уу? Хэрвээ тийм бол энэ дэмжлэгийг авч чадсан уу? (§8.1.5)

Оролцож байгаагүй. Мэдэхгүй. Сонирхоё гэхэд хаана хандахаа мэдэхгүй.

Та жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ дэмжих төрийн байгууллагуудаас бизнесийн зөвлөгөө авч байсан уу? Хэрвээ тийм бол та өөрт хэрэгцээтэй зөвлөгөө, мэдээллийг авч чадсан уу? Та хэрхэн үнэлэх вэ? (§8.1.6)

Үгүй.

Та шинэ бүтээгдэхүүн хөгжүүлэх эсхүл бүтээмжийг нэмэгдүүлэх судалгаа зэрэгт төрөөс дэмжлэг үзүүлдэг талаар мэдэх үү? Тийм бол дэмжлэг авахаар оролдож байсан уу? Ямар хүндрэл, бэрхшээл гарч байсан бэ? (§8.1.7)

Мэдэхгүй. Хамрагдаагүй.

Төрөөс техник, технологийн дэвшилийг дамжуулах, нутагшуулах, шинжлэх ухаан, технологийн судалгааны үр дүнг үйлдвэрлэлд нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлдэг талаар та хэр сайн мэдэх вэ? (§8.1.8)

Үгүй.

Та кластерын талаар хэр сайн ойлголттой вэ? (§8.1.9) Танай компани үйл ажиллагаагаа эрхлэхдээ кластераар ажилладаг уу? Ийм хэлбэрээр ажиллахад төрөөс дэмжлэг авч байсан уу?

Кластераар үйл ажиллагаа явуулдаггүй. Миний бодлоор манайх шиг бүтээгдэхүүнээ савладаг компаниуд дундаа нэг савлах үйлдвэртэй байвал илүү үр дүнтэй гэж боддог. Яагаад гэвэл бид адилхан тоног төхөөрөмж хэрэглэдэг, гэхдээ бүгд тус тусдаа тоног төхөөрөмжөө оруулж ирдэг. Энэ нь их зардалтай, талбай, түрээсийн зардал гардаг. Гэвч 24 цаг ажилладаггүй, зарим байгууллага сардаа 7 хоног ажиллаад бусад үед борлуулалт хийдэг.

Танай бүтээгдэхүүн үйлчилгээ гадаад, дотоод зах зээлд гарахдаа төрөөс ямар нэгэн дэмжлэг авч байсан уу? (§8.1.10) (жишээ нь дотоодын болон олон улсын үзэсгэлэн худалдаа зохион байгуулах, оролцох зэрэг)

Тийм. 2024 оны 10 сар, 2025 оны 3 сард Солонгост Made in Mongolia үзэсгэлэнд оролцсон.

Хэрвээ авсан бол ямар? Энэ дэмжлэг нь гадаад, дотоод зах зээлд гарахад бодитой дэмжлэг болж чадсан уу?

Энэ нь бүтээгдэхүүнээс шалтгаална. Төрөөс зардлыг хөнгөлөөд явуулж байгаа нь сайн боловч, тухайн бүтээгдэхүүний зах зээлд ямар байгаагаас их шалтгаалдаг юм байна. Манай барагшуун тэнд сайн танигдаагүй. Жишээ нь, ноолууран бүтээгдэхүүний хувьд ашигтай харагдсан.

Таны бодлоор Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хууль хэр зэрэг хэрэгжиж байна? Яагаад?

Хуулийн хэрэгжилт сайн биш. Энэ нь төрийн үйлчилгээ үзүүлэгч байгууллага болон ЖДҮ эрхлэгч бидний уялдаа холбоо сул байгаатай холбоотой. Нэг талдаа бид мэдээлэл муутай, тэрийгээ өөрсдөө судалдаггүй. Би ч бас мэдэхгүй зүйл их байна. Нөгөө талаас төр яг чиглэх зүйлдээ зөв хандаж чадаж байна уу гэдэг асуудал байна. Аль аль талдаа асуудалтай, уулзалтын цэгээ олохгүй байна гэж боддог.

Нэмж хэлэх санал

ЖДҮ дэмжих хөнгөлөлттэй зээлийн хугацаа урт байвал зүгээр байна. Жишээ нь, би Хүнсний хувьсгал хөтөлбөрийн хүрээнд ХААН банкаар олгосон Засгийн газрын татаастай 100 сая төгрөгийн зээл авсан. Энэ зээлийн үндсэн хүү 18 хувь, түүний 13 хувийг Засгийн газар, 5 хувийг би төлдөг нөхцөлтэй. 2023 оны 12 сард авсан, энэ өвөл төлж дуусах хугацаатай. Хугацаа богино тул сард 5 сая төгрөг төлөх шаардлагатай. Хэрэв хугацаа 5 жил байсан бол дарамт багатай байх байсан. Миний бодлоор, төрийн дэмжлэгтэй зээлд хамрагдаад хугацаандаа төлсөн бол дараагийн зээлд хүүг бууруулах, эсвэл хугацааг уртасгах зэргээр хөнгөлөлт үзүүлбэл илүү үр дүнтэй.

ЖДҮ-ийн дэмжлэгүүд яг эзэндээ хүрч байна уу гэдэг нь асуудалтай. Хянах систем сул байдаг санагддаг. Зарим хүн үйлдвэрлэлийн зориулалттай зээл аваад наймаа хийх гэх мэт өөр зориулалтаар ашигладаг. Иймд зориулалтын дагуу ашиглаж байгаа эсэхийг хянах систем хэрэгтэй.

Гадаад орнуудад төрөөс ЖДҮ эрхлэгчдэд хууль, санхүүгийн чиглэлээр туслах мэргэжилтнүүд ажиллуулдаг, тэд хэрэгтэй чиглэлээр зөвлөдөг. 10, 100 ААН-ийн дунд нэг мэргэжилтэн ажиллуулдаг жишээтэй.

Том компаниуд томрох сонирхолгүй, компаниа жижиглэн жижиг ангилалд оруулж, хөнгөлөлттэй зээлийг авч явдаг. Харин үйл ажиллагаа шинээр эхлүүлсэн компаниудад энэ зээл хүртээмжгүй байдаг. Зар тавихад очиход зээл дууссан байдаг тохиолдол олон байсан. Одоо арай гайгүй болж байгаа. Үйл ажиллагаа шинээр эхлүүлсэн компаниудад хүртээмжтэй баймаар байна.

Би 2023 онд зээл авахдаа банкны бүх шаардлагыг хангаж материалаа бүрдүүлсэн тул асуудалгүй байсан. Гэхдээ жижиг компаниудад барьцаа хөрөнгө хэцүү байдаг. Би орон сууцны зээлтэй, ажлын байр нь түрээсийнх болохоор барьцаа хөрөнгийн шаардлага хангахгүй. 3 жил үйл ажиллагаа явуулсан, 100 сая төгрөгийн зээлийг төлж чадах ч банк тэгж харахгүй. Би хамаатан, найз нөхдийнхөө байрыг барьцаанд тавьж байгаад зээл авсан. Энэ зээлийн ачаар 2024 онд Хонхорт ажлын байраа худалдаж авсан. Иймд Зээлийн батлан даалтын сан сайн ажиллаж, дэмжлэг үзүүлдэг бол хэрэгтэй.

Тендерт оролцоход нөхцөл нь чанга, шаардлагад нь нийцэх боломжгүй байдаг. Үйл ажиллагаагаа эхлүүлж хөлөө олсон компаниудад илүү боломж олддог, шинээр гарч ирсэн компаниудад хүртээмж муу байна. Зарим тендер урьдчилан захиалгатай юм шиг санагддаг. Жишээ нь, саяхан ГОК-оос зарласан тендерт барагшуун авна гэсэн, бүр Моносын "Витос" бүтээгдэхүүний нэр заасан байсан. Гэтэл Моностой өрсөлдөх компани Монголд байхгүй.

ЖИЖИГ, ДУНД ҮЙЛДВЭР, ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭГЧ 5

Та (танай ажилчид) жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжих төвөөс зохион байгуулсан сургалтад хамрагдаж байсан уу? Үгүй бол яагаад? Сургалт зохион байгуулагдаж байгаа талаар мэдээлэл авч чаддаггүй эсвэл сургалтын агуулга таалагдаагүй юу? (§8.1.1)

Үгүй. Нэгт, мэдээлэл хомс. Хоёрт, төрөөс дэмжлэг үзүүлнэ гэхээр худлаа санагддаг.

Хэрвээ тийм бол тухайн сургалтаас таны бизнесийн хэрэгцээнд нийцсэн мэдээлэл, зөвлөгөө авах боломж хэр байсан бэ?

-

Сургалтын чанар, хүртээмж, агуулга нь зах зээлийн эрэлт хэрэгцээтэй хэр зэрэг нийцэж байсан талаар та бодлоо хуваалцаач?

-
Та Жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдэд

(1) хөнгөлөлттэй зээл олгох, (2) шинээр бий болгосон ажлын байрны тоо, борлуулалтын орлогын хэмжээг харгалзан зээлийн хүүгийн хэмжээг бууруулах, (3) зээлийн давхар батлан даалт гаргах, (4) зээлийн хүүгийн татаас олгох, (5) тоног төхөөрөмжийн санхүүгийн түрээсийн үйлчилгээ, түрээсийн хүүгийн дэмжлэг үзүүлэх зэргээр санхүүгийн дэмжлэг үзүүлдэг талаар мэдэх үү? (§8.1.2), (§11.3)

Мэдэхгүй. Наад дэмжлэгүүд чинь ёстой зүгээр юм байна шүү.

Хэрвээ тийм бол хаанаас мэдээлэл авч байсан бэ?

-
Төрөөс үзүүлж байгаа дэмжлэгүүдэд хэрхэн хамрагдах, төслийн материал бэлдэх зэрэг асуудлаар төрийн байгууллагын холбогдох албан хаагчдаас тусламж авч байсан уу? Хэрвээ тийм бол ямар нэгэн хүндрэл бэрхшээл гарч байсан уу? Хүссэн мэдээллээ авч чадсан уу?

Энэ мэдээллийг хаанаас, яаж авдгийг мэдэхгүй. Ийм зүйл байдаг бол хамрагдмаар байна.

Та Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх санд хөнгөлөлттэй зээлд хамрагдахаар материалаа явуулж байсан уу? Өөрийн материалдаа хэр итгэлтэй байсан бэ? Хөнгөлөлттэй зээлд хамрагдаж чадсан уу?

Манай TDRB компани 2010 онд ЖДҮ-ийг дэмжих зээл авч байсан. Өөрсдөө хөөцөлдөж авахад маш хэцүү байсан. Тухайн үед зээлийнхээ 5 хувийг яамны мэргэжилтэнд хахуульд өгч байж зээл бүтсэн. 80 саяын зээл авч байсан.

Та Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох төслийн сонгон шалгаруулалт хэр зэрэг шударга, ил тод явагддаг гэж бодож байна?

Шударга гэж бодохгүй байна. Тухайн үед яамны мэргэжилтэн “хувь өгвөл бүтээж өгнө” гэж байсан.

Төслийн сонгон шалгаруулалтад оролцоход шаардлагатай баримт, материал, тавигдах шалгуур хэр зэрэг практикт нийцсэн гэж үзэж байна?

Ёстой худлаа санагдсан. Хахууль өгвөл зохицуулж өгдөг байсан.

Нэг удаа олгох зээлийн дээд хэмжээ таны бизнест хангалттай хүрэлцээтэй байна уу? (§11.6)

Тухайн үед барьцаа хөрөнгөнөөс шалтгаалдаг байсан.

Сонгон шалгаруулалтад төслийн саналаа мэдүүлэхэд хүндрэл, бэрхшээл тулгардаг уу? Тийм бол ямар?

Бор зүрхээрээ явж зээлд хамрагдана гэдэг хэцүү.

Хөнгөлөлттэй зээл олгохгүй дараах нөхцөлүүдээс аль нь жижиг дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдэд санхүүгийн дэмжлэг авахад хамгийн их хүндрэл учруулдаг вэ? (§11.11)

1. Сангаас авсан зээлийн үлдэгдэлтэй;
2. Зээлийн мэдээллийн санд муу зээлийн түүхтэй;
3. Сангаас авсан зээлийг зориулалтын бусаар ашигласан нь тогтоогдсон;
4. Шүүхийн шийдвэрээр бусдад төлөх өртэй;
5. Төсөл хүлээн авах сүүлийн өдрийн байдлаар нийгмийн даатгал, татварын байгууллагад өртэй.

Би ЖДҮ-ийн зээл авах үед эдгээр нөхцөлүүд надад байгаагүй. Авлигаар л шийддэг нь хамгийн их дургүй хүргэдэг.

Та жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдэд төрөөс татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн дэмжлэг үзүүлдэг талаар хэр мэдээлэлтэй байдаг вэ? (§8.1.3)

Ёстой мэдэхгүй.

Та татварын хөнгөлөлт, чөлөөлөлтөд хамрагддаг уу? Хэрвээ тийм бол ямар хэлбэрийн татварын хөнгөлөлт, чөлөөлөлтөд хамрагддаг вэ? Энэхүү хөнгөлөлт танд бодит дэмжлэг болж чаддаг уу?

Үгүй. Миний бодлоор НӨАТ нь далд эдийн засгийг ил болгох бүртгэлийн систем болдог. АНУ, Европт НӨАТ-ыг жилд нэг удаа буцаан олгодог, манайд 10 хувь авч 2 хувийг л буцаадаг. НӨАТ нь ААН-д их дарамт болдог, өргүй компани бараг байдаггүй. Би үүнийг эсэргүүцдэг. ЖДҮ эрхлэгчид үүнийг мэддэг ч эсэргүүцлээ илэрхийлэх завгүйд харамсдаг.

Төрөөс экспортыг нэмэгдүүлэх, импортыг орлох өрсөлдөх чадвартай бүтээгдэхүүний үйлдвэрлэл, үйлчилгээг дэмждэг талаар мэдэх үү? Хэрвээ тийм бол ийм төрлийн дэмжлэгт хамрагдаж байсан уу? Дэмжлэгт хамрагдахад хүндрэл, бэрхшээл гарч байсан уу? Тийм бол ямар? ; (§8.1.4)

Мэдэхгүй. PayPal, Stripe зэрэг төлбөрийн систем манайд ажилладаггүй. Онлайн худалдааны эрх зүйн орчин байхгүй, ийм байж экспорт дэмжих тухай яриад байдгийг ойлгодоггүй.

Та төрөөс бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний борлуулалтад төрийн худалдан авалтаар дэмжлэг үзүүлдэг талаар мэдэх үү? Та төрийн худалдан авах ажиллагаанд оролцож байсан уу? Хэрвээ тийм бол энэ дэмжлэгийг авч чадсан уу? (§8.1.5)

Би офсет хэвлэлийн компани ажиллуулдаг байхдаа 2008 онд Боловсролын яамны тендерт орж үзсэн. Гэвч шалгарах компани нь урьдчилан тодорхой байдаг, бага үнэ санал болгосон компаниудыг янз бүрийн шалтгаанаар хасдаг. Шударга бус явдаг гэж одоо ч боддог.

Та жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ дэмжих төрийн байгууллагуудаас бизнесийн зөвлөгөө авч байсан уу? Хэрвээ тийм бол та өөрт хэрэгцээтэй зөвлөгөө, мэдээллийг авч чадсан уу? Та хэрхэн үнэлэх вэ? (§8.1.6)

Үгүй. Татварын байгууллага, төрийн байгууллагууд мэдээлэл өгөхдөө хангалтгүй. Иргэд Google хайлтаар мэдээллээ авах боломжтой байх хэрэгтэй, одоо хайгаад ч олдохгүй байна.

Та шинэ бүтээгдэхүүн хөгжүүлэх эсхүл бүтээмжийг нэмэгдүүлэх судалгаа зэрэгт төрөөс дэмжлэг үзүүлдэг талаар мэдэх үү? Тийм бол дэмжлэг авахаар оролдож байсан уу? Ямар хүндрэл, бэрхшээл гарч байсан бэ? (§8.1.7)

Ёстой мэдэхгүй.

Төрөөс техник, технологийн дэвшлийг дамжуулах, нутагшуулах, шинжлэх ухаан, технологийн судалгааны үр дүнг үйлдвэрлэлд нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлдэг талаар та хэр сайн мэдэх вэ? (§8.1.8)

Ноу-хау гэж ойлгож байна. Төрөөс заадаг бол сайхан л байна.

Та кластерын талаар хэр сайн ойлголттой вэ? (§8.1.9) Танай компани үйл ажиллагаагаа эрхлэхдээ кластераар ажилладаг уу? Ийм хэлбэрээр ажиллахад төрөөс дэмжлэг авч байсан уу?

Кластер нь оролцогч талуудад ашигтай. Төрөөс дэмжих нь зөв бодлого, гэхдээ хэр хүртээмжтэй байдаг бол гэж бодож байна, одоо л сонсож байна.

Танай бүтээгдэхүүн үйлчилгээ гадаад, дотоод зах зээлд гарахдаа төрөөс ямар нэгэн дэмжлэг авч байсан уу? (§8.1.10) (жишээ нь дотоодын болон олон улсын үзэсгэлэн худалдаа зохион байгуулах, оролцох зэрэг)

Тийм.

Хэрвээ авсан бол ямар? Энэ дэмжлэг нь гадаад, дотоод зах зээлд гарахад бодитой дэмжлэг болж чадсан уу?

Үгүй. Ковидын үед Монгол улс саарал жагсаалтад орсон тул retail sale дээр төлбөр хүлээн авах боломжгүй болсон. Төр тогтвортой байж, PayPal-аар төлбөр хүлээн авах боломжтой болвол маш том дэмжлэг болно гэж боддог.

Таны бодлоор Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хууль хэр зэрэг хэрэгжиж байна? Яагаад?

Манай улс үйлдвэрлэлээ дэмжих бодлого явуулдаггүй. Хүмүүс урдаас бараа авчирч зарж байхад үйлдвэрлэгчид цалин, түрээс, зээлээ арай гэж төлөөд хоосон үлдэж байна. Төрд байгаа хүмүүс үйлдвэрлэгч биш учраас асуудлыг ойлгодоггүй. Худалдаачид мөнгөтэй, үйлдвэрлэгчид ядуу хэвээр байна. Үйлдвэрлэлийг дэмжихгүй байгаагаас үйлдвэрлэгчид жилээс жилд цөөрч, офсет хэвлэлийн салбар ажиллах хүчингүй болж, Gen Z үеийн залуус ачаалал авахгүй учраас үйлдвэрлэлийн салбар, ЖДҮ үнэхээр явахгүй болж байна.

Нэмж хэлэх санал

PayPal, Stripe-аар төлбөр хүлээн авах боломжийг нээх, дэд бүтэц, логиستيкийн асуудлаа шийдэх, онлайн худалдааны эрх зүйн орчныг бүрдүүлэх шаардлагатай.

ЖИЖИГ, ДУНД ҮЙЛДВЭР, ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭГЧ 6

Та (танай ажилчид) жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжих төвөөс зохион байгуулсан сургалтад хамрагдаж байсан уу? Үгүй бол яагаад? Сургалт зохион байгуулагдаж байгаа талаар мэдээлэл авч чаддаггүй эсвэл сургалтын агуулга таалагдаагүй юу? (§8.1.1)

Үгүй.

Хэрвээ тийм бол тухайн сургалтаас таны бизнесийн хэрэгцээнд нийцсэн мэдээлэл, зөвлөгөө авах боломж хэр байсан бэ?

-

Сургалтын чанар, хүртээмж, агуулга нь зах зээлийн эрэлт хэрэгцээтэй хэр зэрэг нийцэж байсан талаар та бодлоо хуваалцаач?

-

Та Жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдэд

(1) хөнгөлөлттэй зээл олгох, (2) шинээр бий болгосон ажлын байрны тоо, борлуулалтын орлогын хэмжээг харгалзан зээлийн хүүгийн хэмжээг бууруулах, (3) зээлийн давхар батлан даалт гаргах, (4) зээлийн хүүгийн татаас олгох, (5) тоног төхөөрөмжийн санхүүгийн түрээсийн үйлчилгээ, түрээсийн хүүгийн дэмжлэг үзүүлэх зэргээр санхүүгийн дэмжлэг үзүүлдэг талаар мэдэх үү? (§8.1.2), (§11.3)

Хөнгөлөлттэй зээл олгодог талаар мэднэ. Төрөөс үнэгүй гарц зохион байгуулдаг банк 2-4 хувь болгож олгодог талаар мэдээлэл авч байсан. 2 дахийг сонсож байсан. 3 дахийг сонсож байгаагүй.

Хэрвээ тийм бол хаанаас мэдээлэл авч байсан бэ?

Нийслэлийн инновацын төвөөс.

Төрөөс үзүүлж байгаа дэмжлэгүүдэд хэрхэн хамрагдах, төслийн материал бэлдэх зэрэг асуудлаар төрийн байгууллагын холбогдох албан хаагчаас тусламж авч байсан уу? Хэрвээ тийм бол ямар нэгэн хүндрэл бэрхшээл гарч байсан уу? Хүссэн мэдээллээ авч чадсан уу?

Төрийн байгууллага, албан хаагчаас тусламж авч байгаагүй.

Та Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх санд хөнгөлөлттэй зээлд хамрагдахаар материалаа явуулж байсан уу? Өөрийн материалдаа хэр итгэлтэй байсан бэ? Хөнгөлөлттэй зээлд хамрагдаж чадсан уу?

Үгүй. Ирэх жилээс төлөвлөж байгаа.

Та Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох төслийн сонгон шалгаруулалт хэр зэрэг шударга, ил тод явагддаг гэж бодож байна?

ЖДҮ-д хамрагдаж байгаагүй болохоор мэдэхгүй байна.

Төслийн сонгон шалгаруулалтад оролцоход шаардлагатай баримт, материал, тавигдах шалгуур хэр зэрэг практикт нийцсэн гэж үзэж байна?

Мэдэхгүй

Нэг удаа олгох зээлийн дээд хэмжээ таны бизнест хангалттай хүрэлцээтэй байна уу? (§11.6)

-

Сонгон шалгаруулалтад төслийн саналаа мэдүүлэхэд хүндрэл, бэрхшээл тулгардаг уу? Тийм бол ямар?

-

Хөнгөлөлттэй зээл олгохгүй дараах нөхцөлүүдээс аль нь жижиг дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдэд санхүүгийн дэмжлэг авахад хамгийн их хүндрэл учруулдаг вэ? (§11.11)

1. Сангаас авсан зээлийн үлдэгдэлтэй;
2. Зээлийн мэдээллийн санд муу зээлийн түүхтэй;
3. Сангаас авсан зээлийг зориулалтын бусаар ашигласан нь тогтоогдсон;
4. Шүүхийн шийдвэрээр бусдад төлөх өртэй;
5. Төсөл хүлээн авах сүүлийн өдрийн байдлаар нийгмийн даатгал, татварын байгууллагад өртэй.

Зээлийн сайн түүх бидэнд байхгүй.

Та жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдэд төрөөс татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн дэмжлэг үзүүлдэг талаар хэр мэдээлэлтэй байдаг вэ? (§8.1.3)

Тэр талаар мэдэхгүй.

Та татварын хөнгөлөлт, чөлөөлөлтөд хамрагддаг уу? Хэрвээ тийм бол ямар хэлбэрийн татварын хөнгөлөлт, чөлөөлөлтөд хамрагддаг вэ? Энэхүү хөнгөлөлт танд бодит дэмжлэг болж чаддаг уу?

Гарааны компани гээд НӨАТ-аас чөлөөлөгдөж байсан. Гааль дээр чөлөөлөгдөх гэхээр татвараа л авна гэдэг. Листэнд ороогүй учир бараг хамаагүй гэдэг.

Төрөөс экспортыг нэмэгдүүлэх, импортыг орлох өрсөлдөх чадвартай бүтээгдэхүүний үйлдвэрлэл, үйлчилгээг дэмждэг талаар мэдэх үү? Хэрвээ тийм бол ийм төрлийн дэмжлэгт хамрагдаж байсан уу? Дэмжлэгт хамрагдахад хүндрэл, бэрхшээл гарч байсан уу? Тийм бол ямар? ; (§8.1.4)

Мэдэхгүй.

Та төрөөс бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний борлуулалтад төрийн худалдан авалтаар дэмжлэг үзүүлдэг талаар мэдэх үү? Та төрийн худалдан авах ажиллагаанд оролцож байсан уу? Хэрвээ тийм бол энэ дэмжлэгийг авч чадсан уу? (§8.1.5)

Мэдэхгүй.

Та жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ дэмжих төрийн байгууллагуудаас бизнесийн зөвлөгөө авч байсан уу? Хэрвээ тийм бол та өөрт хэрэгцээтэй зөвлөгөө, мэдээллийг авч чадсан уу? Та хэрхэн үнэлэх вэ? (§8.1.6)

Нийслэлийн инновацын төв гэж байдаг тэндээс авч байсан.

Та шинэ бүтээгдэхүүн хөгжүүлэх эсхүл бүтээмжийг нэмэгдүүлэх судалгаа зэрэгт төрөөс дэмжлэг үзүүлдэг талаар мэдэх үү? Тийм бол дэмжлэг авахаар оролдож байсан уу? Ямар хүндрэл, бэрхшээл гарч байсан бэ? (§8.1.7)

ШУТ сангаас авч байсан. ЖДҮ-гээс үгүй.

Төрөөс техник, технологийн дэвшлийг дамжуулах, нутагшуулах, шинжлэх ухаан, технологийн судалгааны үр дүнг үйлдвэрлэлд нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлдэг талаар та хэр сайн мэдэх вэ? ; (§8.1.8)

Мэдэхгүй.

Та кластерын талаар хэр сайн ойлголттой вэ? (§8.1.9) Танай компани үйл ажиллагаагаа эрхлэхдээ кластераар ажилладаг уу? Ийм хэлбэрээр ажиллахад төрөөс дэмжлэг авч байсан уу?

Кластер үйлдвэрлэл давгүй ойлголт. Хувийхан өөрсдөө л гарддаг, ингээд удаж байна. Төр удаан. Авч байгаагүй. Төр удаан болохоор хувийхантай л хийдэг.

Танай бүтээгдэхүүн үйлчилгээ гадаад, дотоод зах зээлд гарахдаа төрөөс ямар нэгэн дэмжлэг авч байсан уу? (§8.1.10) (жишээ нь дотоодын болон олон улсын үзэсгэлэн худалдаа зохион байгуулах, оролцох зэрэг)

Үгүй.

Хэрвээ авсан бол ямар? Энэ дэмжлэг нь гадаад, дотоод зах зээлд гарахад бодитой дэмжлэг болж чадсан уу?

Үгүй.

Таны бодлоор Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хууль хэр зэрэг хэрэгжиж байна? Яагаад?

Хүртээмж, мэдээлэл муутай гэж бодож байна.

Нэмж хэлэх санал

Мэдээллээ ил тод нээлттэй байлгаж, сангийн үйл ажиллагааг сурталчилах, хурал семинар сайн хийх, хүртээмжтэй мэдээлэл өгдөг байх хэрэгтэй. Татвар нийгмийн даатгал их өгдөгөөс хүмүүсийн гарт цалин бага очиж байна. Үүнээс болж урт хугацаанд ажиллах хүн олдохгүй байна. Төрөөс техник технологи инновацыг дэмжихгүй байна. Цаасан дээр л байхаас бодит амьдрал дээр хэрэгжихгүй. Бодитоор ашиглаж амьдралд хэрэглэх боломжгүй байна. Өөр улсын хуулийг хуулаад аваад ирсэн учир хэрэгжилт байхгүй байна.

ЖИЖИГ, ДУНД ҮЙЛДВЭР, ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭГЧ 7

Та (танай ажилчид) жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжих төвөөс зохион байгуулсан сургалтад хамрагдаж байсан уу? Үгүй бол яагаад? Сургалт зохион байгуулагдаж байгаа талаар мэдээлэл авч чаддаггүй эсвэл сургалтын агуулга таалагдаагүй юу? (§8.1.1)

Үгүй, тийм сургалт мэдэхгүй, цаг зав ч болдоггүй. Огт хамрагдаж байгаагүй.

Хэрвээ тийм бол тухайн сургалтаас таны бизнесийн хэрэгцээнд нийцсэн мэдээлэл, зөвлөгөө авах боломж хэр байсан бэ?

-

Сургалтын чанар, хүртээмж, агуулга нь зах зээлийн эрэлт хэрэгцээтэй хэр зэрэг нийцэж байсан талаар та бодлоо хуваалцаач?

-

Та Жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдэд

(1) хөнгөлөлттэй зээл олгох, (2) шинээр бий болгосон ажлын байрны тоо, борлуулалтын орлогын хэмжээг харгалзан зээлийн хүүгийн хэмжээг бууруулах, (3) зээлийн давхар батлан даалт гаргах, (4) зээлийн хүүгийн татаас олгох, (5) тоног төхөөрөмжийн санхүүгийн түрээсийн үйлчилгээ, түрээсийн хүүгийн дэмжлэг үзүүлэх зэргээр санхүүгийн дэмжлэг үзүүлдэг талаар мэдэх үү? (§8.1.2), (§11.3)

Сайн мэдэхгүй байна. Судлаад явж байсан ч юм байхгүй.

Хэрвээ тийм бол хаанаас мэдээлэл авч байсан бэ?

Мэдэхгүй.

Төрөөс үзүүлж байгаа дэмжлэгүүдэд хэрхэн хамрагдах, төслийн материал бэлдэх зэрэг асуудлаар төрийн байгууллагын холбогдох албан хаагчаас тусламж авч байсан уу? Хэрвээ тийм бол ямар нэгэн хүндрэл бэрхшээл гарч байсан уу? Хүссэн мэдээллээ авч чадсан уу?

Төрийн байгууллага, албан хаагчаас тусламж авч байгаагүй.

Та Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх санд хөнгөлөлттэй зээлд хамрагдахаар материалаа явуулж байсан уу? Өөрийн материалдаа хэр итгэлтэй байсан бэ? Хөнгөлөлттэй зээлд хамрагдаж чадсан уу?

Ганц нэг удаа материал явуулж байсан. Тухайн төсөл нь сайн төсөл байна гэж байсан боловч дэмжлэг авч чадаагүй.

Та Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох төслийн сонгон шалгаруулалт хэр зэрэг шударга, ил тод явагддаг гэж бодож байна?

Шударга биш санагддаг.

Төслийн сонгон шалгаруулалтад оролцоход шаардлагатай баримт, материал, тавигдах шалгуур хэр зэрэг практикт нийцсэн гэж үзэж байна?

Нээх их нийцээд байдаггүй юм шиг харагддаг. Шалгуур нь хэтэрхий өндөр, жижиг, дунд гэдгээсээ илүү өндөр шаардлага тавиад байдаг.

Нэг удаа олгох зээлийн дээд хэмжээ таны бизнест хангалттай хүрэлцээтэй байна уу? (§11.6)

Мэдэхгүй. Авч байгаагүй болохоор тэр талаар мэдэхгүй байна.

Сонгон шалгаруулалтад төслийн саналаа мэдүүлэхэд хүндрэл, бэрхшээл тулгардаг уу? Тийм бол ямар?

Тэр бол аягүй төвөгтэй, татварын өрийн асуудлаас эхлээд. Татварын өргүй хүн гэж алга. ХХОАТ, ашгийн татвар гээд авахаар мань мэт хоолтой хоолгүй гэдэг шиг л байна. Хэдэн хүмүүсээ хоолтой байлгая л гэж байна.

Хөнгөлөлттэй зээл олгохгүй дараах нөхцөлүүдээс аль нь жижиг дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдэд санхүүгийн дэмжлэг авахад хамгийн их хүндрэл учруулдаг вэ? (§11.11)

1. Сангаас авсан зээлийн үлдэгдэлтэй;
2. Зээлийн мэдээллийн санд муу зээлийн түүхтэй;
3. Сангаас авсан зээлийг зориулалтын бусаар ашигласан нь тогтоогдсон;
4. Шүүхийн шийдвэрээр бусдад төлөх өртэй;
5. Төсөл хүлээн авах сүүлийн өдрийн байдлаар нийгмийн даатгал, татварын байгууллагад өртэй.

Хамгийн сүүлийнх нь. Бусдын бол даваад гарч болдог. Татвар л хаалт болдог. Татварын өргүй байхад хэцүү.

Та жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдэд төрөөс татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн дэмжлэг үзүүлдэг талаар хэр мэдээлэлтэй байдаг вэ? (§8.1.3)

Тэрийг ёстой мэдэхгүй. Татварынхан татвараа төл л гэж дарамтлахаас хөнгөлөлт, чөлөөлөлт байдаг гэж хэлдэггүй.

Та татварын хөнгөлөлт, чөлөөлөлтөд хамрагддаг уу? Хэрвээ тийм бол ямар хэлбэрийн татварын хөнгөлөлт, чөлөөлөлтөд хамрагддаг вэ? Энэхүү хөнгөлөлт танд бодит дэмжлэг болж чаддаг уу?

Ер нь мэднэ. Гэхдээ авч байгаагүй.

Төрөөс экспортыг нэмэгдүүлэх, импортыг орлох өрсөлдөх чадвартай бүтээгдэхүүний үйлдвэрлэл, үйлчилгээг дэмждэг талаар мэдэх үү? Хэрвээ тийм бол ийм төрлийн дэмжлэгт хамрагдаж байсан уу? Дэмжлэгт хамрагдахад хүндрэл, бэрхшээл гарч байсан уу? Тийм бол ямар? ; (§8.1.4)

Ер нь бол мэднэ. Хамрагдаж байгаагүй. Уул нь гаалиар гаднаас эрчим хүчийг хэмнэх, дулаан, цахилгааны эрчим хүчийг хэмнэх тоног төхөөрөмж оруулж ирэхэд татварын хөнгөлөлт үзүүлдэг гэдэг. Гэвч бодит байдал дээр байхгүй, заалт нь байдаг боловч есөн шидийн юм нэхээд, татварын хөнгөлөлтөд орох гээд ч орж чаддаггүй.

Та төрөөс бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний борлуулалтад төрийн худалдан авалтаар дэмжлэг үзүүлдэг талаар мэдэх үү? Та төрийн худалдан авах ажиллагаанд оролцож байсан уу? Хэрвээ тийм бол энэ дэмжлэгийг авч чадсан уу? (§8.1.5)

Тэр дэмжлэг ч байхгүй дээ.

Та жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ дэмжих төрийн байгууллагуудаас бизнесийн зөвлөгөө авч байсан уу? Хэрвээ тийм бол та өөрт хэрэгцээтэй зөвлөгөө, мэдээллийг авч чадсан уу? Та хэрхэн үнэлэх вэ? (§8.1.6)

Үгүй.

Та шинэ бүтээгдэхүүн хөгжүүлэх эсхүл бүтээмжийг нэмэгдүүлэх судалгаа зэрэгт төрөөс дэмжлэг үзүүлдэг талаар мэдэх үү? Тийм бол дэмжлэг авахаар оролдож байсан уу? Ямар хүндрэл, бэрхшээл гарч байсан бэ? (§8.1.7)

Мэдэхгүй.

Төрөөс техник, технологийн дэвшлийг дамжуулах, нутагшуулах, шинжлэх ухаан, технологийн судалгааны үр дүнг үйлдвэрлэлд нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлдэг талаар та хэр сайн мэдэх вэ? (§8.1.8)

Сонсож байсан. Шинэ технологи гэдгээр барилгын зураг зурдаг, тооцоолол хийдэг программыг Монголд оруулж ирэх талаар хөөцөлдөж байсан. Тэр нь Боловсролын яамнаас зөвшөөрөл авдаг гээд чадаагүй. Манайхны хэрэглэдэг программыг бодвол илүү хялбар, нарийн тооцоолол хийдэг байсан. Олон зөвшөөрөл шаардлагаас болоод орхисон.

Та кластерын талаар хэр сайн ойлголттой вэ? (§8.1.9) Танай компани үйл ажиллагаагаа эрхлэхдээ кластераар ажилладаг уу? Ийм хэлбэрээр ажиллахад төрөөс дэмжлэг авч байсан уу?

Кластерын талаар ойлголт муу байна.

Танай бүтээгдэхүүн үйлчилгээ гадаад, дотоод зах зээлд гарахдаа төрөөс ямар нэгэн дэмжлэг авч байсан уу? (§8.1.10) (жишээ нь дотоодын болон олон улсын үзэсгэлэн худалдаа зохион байгуулах, оролцох зэрэг)

Үгүй.

Хэрвээ авсан бол ямар? Энэ дэмжлэг нь гадаад, дотоод зах зээлд гарахад бодитой дэмжлэг болж чадсан уу?

Үгүй.

Таны бодлоор Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хууль хэр зэрэг хэрэгжиж байна? Яагаад?

Мэдээлэл тааруухан байна. Тэгээд ч хэрэгжилт ямар байгааг мэдэхгүй. Ер нь хэрэгжилт муутай гэж үзэж байна.

Нэмж хэлэх санал

Нэгдүгээрт, татварын асуудал. Татвар жижиг, дунд үйлдвэрлэгчдэд хөнгөлөлт үзүүлдэг л гэж байна. Тэрэнд би хамрагдаж чадаагүй. Татварын хувь хэмжээг бууруулж, арга хэмжээ авч жижиг, дунд үйлдвэрлэгчдээ дэмжихгүй бол хамгийн хүнд асуудал болоод байна.

Хоёрдугаарт, мэдээ мэдээллийг сайн хүргэх тал дээр сайн ажилламаар байна. Манайд ийм боломж үүсч байна гэх мэт... Татвар нэхэхдээ бүх юмыг ухаад гаргадаг шигээ, ЖДҮ гээд явахад төрийн байгууллага, банкаар явахад дандаа гацдаг.

Бас тусгай зөвшөөрлөөр хамаг юмыг хааж, боож байна. Тусгай зөвшөөрлийн өндөр шаардлагыг хангах ЖДҮ бараг байдаггүй. Мөн нэг сар татварын байцаагч ярихгүй бол тайван амьдарч байна.

ЖИЖИГ, ДУНД ҮЙЛДВЭР, ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭГЧ 8

Та (танай ажилчид) жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжих төвөөс зохион байгуулсан сургалтад хамрагдаж байсан уу? Үгүй бол яагаад? Сургалт зохион байгуулагдаж байгаа талаар мэдээлэл авч чаддаггүй эсвэл сургалтын агуулга таалагдаагүй юу? (§8.1.1)

Үгүй, тийм сургалт мэдэхгүй

Хэрвээ тийм бол тухайн сургалтаас таны бизнесийн хэрэгцээнд нийцсэн мэдээлэл, зөвлөгөө авах боломж хэр байсан бэ?

-

Сургалтын чанар, хүртээмж, агуулга нь зах зээлийн эрэлт хэрэгцээтэй хэр зэрэг нийцэж байсан талаар та бодлоо хуваалцаач?

-

Та Жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдэд

(1) хөнгөлөлттэй зээл олгох, (2) шинээр бий болгосон ажлын байрны тоо, борлуулалтын орлогын хэмжээг харгалзан зээлийн хүүгийн хэмжээг бууруулах, (3) зээлийн давхар батлан даалт гаргах, (4) зээлийн хүүгийн татаас олгох, (5) тоног төхөөрөмжийн санхүүгийн түрээсийн үйлчилгээ, түрээсийн хүүгийн дэмжлэг үзүүлэх зэргээр санхүүгийн дэмжлэг үзүүлдэг талаар мэдэх үү? (§8.1.2), (§11.3)

Сайн мэдэхгүй байна.

Хэрвээ тийм бол хаанаас мэдээлэл авч байсан бэ?

Мэдэхгүй.

Төрөөс үзүүлж байгаа дэмжлэгүүдэд хэрхэн хамрагдах, төслийн материал бэлдэх зэрэг асуудлаар төрийн байгууллагын холбогдох албан хаагчдаас тусламж авч байсан уу? Хэрвээ тийм бол ямар нэгэн хүндрэл бэрхшээл гарч байсан уу? Хүссэн мэдээллээ авч чадсан уу?

Төрийн байгууллага, албан хаагчаас тусламж авч байгаагүй.

Та Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх санд хөнгөлөлттэй зээлд хамрагдахаар материалаа явуулж байсан уу? Өөрийн материалдаа хэр итгэлтэй байсан бэ? Хөнгөлөлттэй зээлд хамрагдаж чадсан уу?

Үгүй.

Та Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох төслийн сонгон шалгаруулалт хэр зэрэг шударга, ил тод явагддаг гэж бодож байна?

Мэдэхгүй.

Төслийн сонгон шалгаруулалтад оролцоход шаардлагатай баримт, материал, тавигдах шалгуур хэр зэрэг практикт нийцсэн гэж үзэж байна?

Мэдэхгүй. Зээл олддог бол сайхан л байна.

Нэг удаа олгох зээлийн дээд хэмжээ таны бизнест хангалттай хүрэлцээтэй байна уу? (§11.6)

Манайд бол 30-60 сая төгрөг байхад л болно.

Сонгон шалгаруулалтад төслийн саналаа мэдүүлэхэд хүндрэл, бэрхшээл тулгардаг уу? Тийм бол ямар?

Өгч байгаагүй болохоор мэдэхгүй.

Хөнгөлөлттэй зээл олгохгүй дараах нөхцөлүүдээс аль нь жижиг дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдэд санхүүгийн дэмжлэг авахад хамгийн их хүндрэл учруулдаг вэ? (§11.11)

1. Сангаас авсан зээлийн үлдэгдэлтэй;

2. Зээлийн мэдээллийн санд муу зээлийн түүхтэй;

3. Сангаас авсан зээлийг зориулалтын бусаар ашигласан нь тогтоогдсон;

4. Шүүхийн шийдвэрээр бусдад төлөх өртэй;

5. Төсөл хүлээн авах сүүлийн өдрийн байдлаар нийгмийн даатгал, татварын байгууллагад өртэй.

Мэдэхгүй.

Та жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдэд төрөөс татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн дэмжлэг үзүүлдэг талаар хэр мэдээлэлтэй байдаг вэ? (§8.1.3)

Мэдэхгүй.

Та татварын хөнгөлөлт, чөлөөлөлтөд хамрагддаг уу? Хэрвээ тийм бол ямар хэлбэрийн татварын хөнгөлөлт, чөлөөлөлтөд хамрагддаг вэ? Энэхүү хөнгөлөлт танд бодит дэмжлэг болж чаддаг уу?

Мэдэхгүй.

Төрөөс экспортыг нэмэгдүүлэх, импортыг орлох өрсөлдөх чадвартай бүтээгдэхүүний үйлдвэрлэл, үйлчилгээг дэмждэг талаар мэдэх үү? Хэрвээ тийм бол ийм төрлийн дэмжлэгт хамрагдаж байсан уу? Дэмжлэгт хамрагдахад хүндрэл, бэрхшээл гарч байсан уу? Тийм бол ямар? (§8.1.4)

Мэдэхгүй.

Та төрөөс бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний борлуулалтад төрийн худалдан авалтаар дэмжлэг үзүүлдэг талаар мэдэх үү? Та төрийн худалдан авах ажиллагаанд оролцож байсан уу? Хэрвээ тийм бол энэ дэмжлэгийг авч чадсан уу? (§8.1.5)

Мэдэхгүй.

Та жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ дэмжих төрийн байгууллагуудаас бизнесийн зөвлөгөө авч байсан уу? Хэрвээ тийм бол та өөрт хэрэгцээтэй зөвлөгөө, мэдээллийг авч чадсан уу? Та хэрхэн үнэлэх вэ? (§8.1.6)

Үгүй. Хаана байдаг вэ.

Та шинэ бүтээгдэхүүн хөгжүүлэх эсхүл бүтээмжийг нэмэгдүүлэх судалгаа зэрэгт төрөөс дэмжлэг үзүүлдэг талаар мэдэх үү? Тийм бол дэмжлэг авахаар оролдож байсан уу? Ямар хүндрэл, бэрхшээл гарч байсан бэ? (§8.1.7)

Мэдэхгүй.

Төрөөс техник, технологийн дэвшлийг дамжуулах, нутагшуулах, шинжлэх ухаан, технологийн судалгааны үр дүнг үйлдвэрлэлд нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлдэг талаар та хэр сайн мэдэх вэ? (§8.1.8)

Мэдэхгүй.

Та кластерын талаар хэр сайн ойлголттой вэ? (§8.1.9) Танай компани үйл ажиллагаагаа эрхлэхдээ кластераар ажилладаг уу? Ийм хэлбэрээр ажиллахад төрөөс дэмжлэг авч байсан уу?

Кластерийн талаар ойлголт муутай байна.

Танай бүтээгдэхүүн үйлчилгээ гадаад, дотоод зах зээлд гарахдаа төрөөс ямар нэгэн дэмжлэг авч байсан уу? (§8.1.10) (жишээ нь дотоодын болон олон улсын үзэсгэлэн худалдаа зохион байгуулах, оролцох зэрэг)

Үгүй.

Хэрвээ авсан бол ямар? Энэ дэмжлэг нь гадаад, дотоод зах зээлд гарахад бодитой дэмжлэг болж чадсан уу?

Үгүй.

Таны бодлоор Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хууль хэр зэрэг хэрэгжиж байна? Яагаад?

Ямар ч мэдээлэл алга. Бидэнд хүрэхгүй л байна гэж бодож байна..

Нэмж хэлэх санал

Бид ийм үйл ажиллагаа эрхлэхдээ олон хүн ажиллуулдаг. Бид одоо тавуулаа ажиллаж байна. Дандаа одонтой ээжүүд байдаг. Бүгд дөрвөн хүүхэдтэй. Сая 6 сарын 1-ээс тог цахилгаан нэмэгдсэн. Энэ маш хүнд тусч байна. Түрээс, тог, усаа өгөөд үлдэх юм бага байна. Бид материалаа авахдаа Дэнжийн мянга зэргээс мах авахад НӨАТ өгдөггүй. Тэгэхэд би НӨАТ-ийн баримт өгч бас адил өгөхгүй байж болно биз дээ. Би энэ бизнесийг эхлүүлэхэд 30 сая төгрөг хувь хүнээс 10 хувийн хүүтэй зээлсэн. Хүүнээс өөр юм өгч чадахгүй байна. Шантраад больё гэхээр энэ хэд маань хэцүүднэ. Хэрэв бага хүүтэй зээл олддог бол хөл дээрээ босоход хэцүү биш байна. Боломж бол байна. Үйл ажиллагаа явуулаад олон жил болж байгаа, төрөөс дэмжлэг хэрэгтэй бүлгийн хүмүүст өгдөг хөнгөлөлт зэрэг байвал зүгээр санагддаг. Энэ хавийхан мэдэж байхад ирээд асууна биз. Заавал нотол гэдэг. Орлогоо нотлоход хэцүү байдаг шалтгаан нь өдөр бүр бид мах ногоогоо гар дээрээс авдаг болохоор санхүүгийн тайлан гаргахад хэцүү. Манай энд төрөөс ямар нэгэн үйлчилгээ үзүүлж хүн ирж байгаагүй. Онцгой байдлаас нэг хүн ирж байсан. Эндээс харахад үйлчилгээг иргэдэд ойртуулах хэрэгтэй байна. Мэдээлэл маш дутмаг байна.

ЖИЖИГ, ДУНД ҮЙЛДВЭР, ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭГЧ 9

Та (танай ажилчид) жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжих төвөөс зохион байгуулсан сургалтад хамрагдаж байсан уу? Үгүй бол яагаад? Сургалт зохион байгуулагдаж байгаа талаар мэдээлэл авч чаддаггүй эсвэл сургалтын агуулга таалагдаагүй юу? (§8.1.1)

Үгүй, тийм сургалт мэдэхгүй, огт хамрагдаж байгаагүй.

Хэрвээ тийм бол тухайн сургалтаас таны бизнесийн хэрэгцээнд нийцсэн мэдээлэл, зөвлөгөө авах боломж хэр байсан бэ?

-

Сургалтын чанар, хүртээмж, агуулга нь зах зээлийн эрэлт хэрэгцээтэй хэр зэрэг нийцэж байсан талаар та бодлоо хуваалцаач?

-

Та Жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдэд

(1) хөнгөлөлттэй зээл олгох, (2) шинээр бий болгосон ажлын байрны тоо, борлуулалтын орлогын хэмжээг харгалзан зээлийн хүүгийн хэмжээг бууруулах, (3) зээлийн давхар батлан даалт гаргах, (4) зээлийн хүүгийн татаас олгох, (5) тоног төхөөрөмжийн санхүүгийн түрээсийн үйлчилгээ, түрээсийн хүүгийн дэмжлэг үзүүлэх зэргээр санхүүгийн дэмжлэг үзүүлдэг талаар мэдэх үү? (§8.1.2), (§11.3)

Дээрх 5 төрлөөс зээл авч болохыг ерөнхийдөө нь мэдэж байгаа.

Хэрвээ тийм бол хаанаас мэдээлэл авч байсан бэ?

Энэ мэдээллийн нийгмийн сүлжээнээс л авсан санагдаад байна, хүнээс ч сонссон билүү.

Төрөөс үзүүлж байгаа дэмжлэгүүдэд хэрхэн хамрагдах, төслийн материал бэлдэх зэрэг асуудлаар төрийн байгууллагын холбогдох албан хаагчдаас тусламж авч байсан уу? Хэрвээ тийм бол ямар нэгэн хүндрэл бэрхшээл гарч байсан уу? Хүссэн мэдээллээ авч чадсан уу?

Төрийн байгууллага, албан хаагчдаас тусламж авч байгаагүй.

Та Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх санд хөнгөлөлттэй зээлд хамрагдахаар материалаа явуулж байсан уу? Өөрийн материалдаа хэр итгэлтэй байсан бэ? Хөнгөлөлттэй зээлд хамрагдаж чадсан уу?

Тиймээ, дээр хэлсэнчлэн би зээл авсан.

Та Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох төслийн сонгон шалгаруулалт хэр зэрэг шударга, ил тод явагддаг гэж бодож байна?

-

Төслийн сонгон шалгаруулалтад оролцоход шаардлагатай баримт, материал, тавигдах шалгуур хэр зэрэг практикт нийцсэн гэж үзэж байна?

Төвөгтэй, заавал барьцаа хөрөнгө байршуулна гэдэг. Анх ЖДҮ эрхлэх гэж байгаа хүнд барьцаа байхгүй шүү дээ. Гадаад улсад төслөө сайн бичээд, төрөөс өгөөжтэй эсэхийг нь хянаж шалгаад, зах зээлд нь нийцэж байна гэж үзвэл зээл олгодог.

Манайх төслийг хардаг ч заавал барьцаа нэхдэг. Манай олгож байгаа зээл хүү багатай болохоос биш, барьцаа нэхдэг нь хүртээмжгүй гэж боддог. Хэрэв төсөл сайн гэж үзвэл төр хяналт тавиад барьцаагүй зээл өгөх нь илүү хүртээмжтэй.

Мөн заримдаа 1 тэрбум 500 сая төгрөгийн зээл хүсээд, ТЭЗҮ хийж төсөл бичээд ороход барьцаа хүрэхгүйгээс 1 тэрбум, бүр хүссэн хэмжээнийхээ 50 хувийг л олгодог. Ингэхээр анх тооцсон хөрөнгөд тааруулж төлөвлөсөн төсөл бага мөнгө авснаас болж цааш бизнес болон хөгжихөд маш хэцүү, боломжгүй болдог. Ингээд л зээл тарамдаад... Үүнээс болоод ААН-үүд анхны чиглэлээ сольдог, эсвэл дампуурч, сайн төслүүд хэрэгжихгүй үлддэг шалтгаан болдог.

Нэг удаа олгох зээлийн дээд хэмжээ таны бизнест хангалттай хүрэлцээтэй байна уу? (§11.6)

Мэдээж дэмжлэг болдог. Гэхдээ манайх 1 тэрбум 500 сая төгрөгөөр батлагдлаа гэхэд барьцаа хөрөнгө байхгүйгээс зээл нь танагдаж, дээр хэлсэнчлэн 50 эсвэл 30 хувь олгогддог тул анхны хэрэгцээгээ хангаж чаддаггүй.

Сонгон шалгаруулалтад төслийн саналаа мэдүүлэхэд хүндрэл, бэрхшээл тулгардаг уу? Тийм бол ямар?

Тийм. Манай төрийн албан хаагчид, шалгаруулдаг байгууллагын хүнд суртал дийлдэхгүй шүү дээ. Энэ нь зөвхөн ЖДҮ-д биш, бүх төрийн үйлчилгээнд харагддаг.

Хөнгөлөлттэй зээл олгохгүй дараах нөхцөлүүдээс аль нь жижиг дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдэд санхүүгийн дэмжлэг авахад хамгийн их хүндрэл учруулдаг вэ? (§11.11)

1. Сангаас авсан зээлийн үлдэгдэлтэй;
2. Зээлийн мэдээллийн санд муу зээлийн түүхтэй;
3. Сангаас авсан зээлийг зориулалтын бусаар ашигласан нь тогтоогдсон;
4. Шүүхийн шийдвэрээр бусдад төлөх өртэй;
5. Төсөл хүлээн авах сүүлийн өдрийн байдлаар нийгмийн даатгал, татварын байгууллагад өртэй.

Ер нь 2 дугаар заалт хэцүү. Муу зээлийн түүх үүсэх шалтгаан олон байдаг. Тухайлбал, үнийн өсөлт, барааны хомстол. 3 байх ёстой. 4 байж болно. 5 бол ААН бүрийн зовлон шүү дээ.

Та жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдэд төрөөс татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн дэмжлэг үзүүлдэг талаар хэр мэдээлэлтэй байдаг вэ? (§8.1.3)

Байхгүй. Энэ талаар мэдэхгүй.

Та татварын хөнгөлөлт, чөлөөлөлтөд хамрагддаг уу? Хэрвээ тийм бол ямар хэлбэрийн татварын хөнгөлөлт, чөлөөлөлтөд хамрагддаг вэ? Энэхүү хөнгөлөлт танд бодит дэмжлэг болж чаддаг уу?

Энэ төрлийн дэмжлэг авч байгаагүй.

Төрөөс экспортыг нэмэгдүүлэх, импортыг орлох өрсөлдөх чадвартай бүтээгдэхүүний үйлдвэрлэл, үйлчилгээг дэмждэг талаар мэдэх үү? Хэрвээ тийм бол ийм төрлийн дэмжлэгт хамрагдаж байсан уу? Дэмжлэгт хамрагдахад хүндрэл, бэрхшээл гарч байсан уу? Тийм бол ямар? (§8.1.4)

Ийм дэмжлэгт хамрагдаж байгаагүй. Улс импорт орлох юманд хөнгөлөлт үзүүлдэг байх. Танил талаараа хаана юу байна гээд явдаг юм шиг байна лээ.

Та төрөөс бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний борлуулалтад төрийн худалдан авалтаар дэмжлэг үзүүлдэг талаар мэдэх үү? Та төрийн худалдан авах ажиллагаанд оролцож байсан уу? Хэрвээ тийм бол энэ дэмжлэгийг авч чадсан уу? (§8.1.5)

Энэ талаар мэдэхгүй.

Та жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ дэмжих төрийн байгууллагуудаас бизнесийн зөвлөгөө авч байсан уу? Хэрвээ тийм бол та өөрт хэрэгцээтэй зөвлөгөө, мэдээллийг авч чадсан уу? Та хэрхэн үнэлэх вэ? (§8.1.6)

Хувиараа зөвлөгөө авч байсан. Төрийн байгууллагаас авч байгаагүй. Дүүрэг, хороо зэрэгт ЖДҮ төвүүд байдаг ч бидэнд хүрч үйлчилдэггүй.

Та шинэ бүтээгдэхүүн хөгжүүлэх эсхүл бүтээмжийг нэмэгдүүлэх судалгаа зэрэгт төрөөс дэмжлэг үзүүлдэг талаар мэдэх үү? Тийм бол дэмжлэг авахаар оролдож байсан уу? Ямар хүндрэл, бэрхшээл гарч байсан бэ? (§8.1.7)

Мэдэхгүй.

Төрөөс техник, технологийн дэвшлийг дамжуулах, нутагшуулах, шинжлэх ухаан, технологийн судалгааны үр дүнг үйлдвэрлэлд нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлдэг талаар та хэр сайн мэдэх вэ? (§8.1.8)

Мэдэхгүй.

Та кластерын талаар хэр сайн ойлголттой вэ? (§8.1.9) Танай компани үйл ажиллагаагаа эрхлэхдээ кластераар ажилладаг уу? Ийм хэлбэрээр ажиллахад төрөөс дэмжлэг авч байсан уу?

Кластерын талаар ойлголтгүй.

Танай бүтээгдэхүүн үйлчилгээ гадаад, дотоод зах зээлд гарахдаа төрөөс ямар нэгэн дэмжлэг авч байсан уу? (§8.1.10) (жишээ нь дотоодын болон олон улсын үзэсгэлэн худалдаа зохион байгуулах, оролцох зэрэг)

Тийм.

Хэрвээ авсан бол ямар? Энэ дэмжлэг нь гадаад, дотоод зах зээлд гарахад бодитой дэмжлэг болж чадсан уу?

Авч байгаагүй.

Таны бодлоор Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хууль хэр зэрэг хэрэгжиж байна? Яагаад?

Муу, дунд гэж хэлье. Төрийн байгууллагууд хүссэн зээлийг нь хангалттай олгохгүй, бүх талаар дэмжиж зөвлөгөө өгч ажилладаггүй. Зүгээр зээл өгсөн болоод хаядаг, зарим нь хүссэн хэмжээгээрээ авч чаддаггүй гэх мэт асуудал хаа сайгүй байдаг.

Нэмж хэлэх санал

Миний гол санаа бол ЖДҮ дэмжих гэж байгаа бол сайн төслийг мэргэжлийн баг нь үнэлээд боломжтой гэж үзвэл нийгмийн даатгал, барьцаа хөрөнгийн шаардлагыг болих хэрэгтэй. Тэгвэл хүртээмжтэй дэмжлэг болно. Барьцаа хөрөнгөтэй хэдэн тэрбум төгрөгийн хөрөнгөтэй бол аль хэдийн хөл дээрээ тогтсон том ААН-үүд л зээл авч байна. Жишээлбэл, МАК цемент барьцаатай хамгийн том зээл авсан, 1 зээл нь 180 сая ам.доллар гэж байсан байх. Том ААН-ууд энэ зээлийг авч өөрсдийн бизнесээ өргөжүүлж байна. Энэ чинь ЖДҮ биш шүү дээ.

ЖДҮ эрхлэгчид барьцаа, нийгмийн даатгалын шалгуур дээр бүдэрч байна. МАК импортыг орлож байгаа нь сайшаалтай боловч, жишээ нь паркетан шалны үйлдвэр нээж зээл аваад өөрийн барилгад ашиглаж байгаа нь импортыг орлохгүй жишээ олон байна. Залуу бизнес эрхлэгчдэд боломж олдохгүй байна. Танил тал, барьцаа хөрөнгөгүйгээс олон залуус хүссэн зээлээ авч, бизнесээ өргөжүүлж чадахгүй байна гэж боддог.

ЖИЖИГ, ДУНД ҮЙЛДВЭР, ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭГЧ 10

Та (танай ажилчид) жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжих төвөөс зохион байгуулсан сургалтад хамрагдаж байсан уу? Үгүй бол яагаад? Сургалт зохион байгуулагдаж байгаа талаар мэдээлэл авч чаддаггүй эсвэл сургалтын агуулга таалагдаагүй юу? (§8.1.1)

Алийг нь мэдэхгүй байна, гэхдээ олон сургалтад хамрагдаж байсан. Бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн сургалт, Арвайхээр дэх сургалт, ажил олгогчдод зориулсан сургалт гээд сууж байсан ч яг ЖДҮ-д зориулсан сургалтанд хамрагдаж байгаагүй юм шиг байна.

Хэрвээ тийм бол тухайн сургалтаас таны бизнесийн хэрэгцээнд нийцсэн мэдээлэл, зөвлөгөө авах боломж хэр байсан бэ?

Хүсвэл зөвлөгөө өгөх байсан байх. Гэхдээ ямар чиглэлээр авахаа сайн шийдээгүй. Ялангуяа оёдлын чиглэлийн бичил бизнесийг дэмжих сонирхол бага байдаг юм шиг санагдсан.

Сургалтын чанар, хүртээмж, агуулга нь зах зээлийн эрэлт хэрэгцээтэй хэр зэрэг нийцэж байсан талаар та бодлоо хуваалцаач?

ЖДҮ-ийн сургалтад хамрагдаж байгаагүй болохоор энэ асуултыг алгасъя.

Та Жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдэд

(1) хөнгөлөлттэй зээл олгох, (2) шинээр бий болгосон ажлын байрны тоо, борлуулалтын орлогын хэмжээг харгалзан зээлийн хүүгийн хэмжээг бууруулах, (3) зээлийн давхар батлан даалт гаргах, (4) зээлийн хүүгийн татаас олгох, (5) тоног төхөөрөмжийн санхүүгийн түрээсийн үйлчилгээ, түрээсийн хүүгийн дэмжлэг үзүүлэх зэргээр санхүүгийн дэмжлэг үзүүлдэг талаар мэдэх үү? (§8.1.2), (§11.3)

Мэднэ.

Хэрвээ тийм бол хаанаас мэдээлэл авч байсан бэ?

Бусад сургалтан дээрээс л авсан юм шиг байна.

Төрөөс үзүүлж байгаа дэмжлэгүүдэд хэрхэн хамрагдах, төслийн материал бэлдэх зэрэг асуудлаар төрийн байгууллагын холбогдох албан хаагчдаас тусламж авч байсан уу? Хэрвээ тийм бол ямар нэгэн хүндрэл бэрхшээл гарч байсан уу? Хүссэн мэдээллээ авч чадсан уу?

Үгүй.

Та Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх санд хөнгөлөлттэй зээлд хамрагдахаар материалаа явуулж байсан уу? Өөрийн материалдаа хэр итгэлтэй байсан бэ? Хөнгөлөлттэй зээлд хамрагдаж чадсан уу?

Тийм ээ, бага хэмжээний зээл авч байсан. Дахиж аваагүй. Төсөл, тооцоо гаргах тал дээр мэдлэг дутмаг, зарим нь хүнээр бичүүлдэг юм билээ. Би их хэмжээний зээл авах зорилготой очоогүй. ХАС банкинд очиход зээл авах боломжтой гэсэн ч барьцаа хөрөнгө хүрээгүйгээс бага зээл авсан.

Та Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох төслийн сонгон шалгаруулалт хэр зэрэг шударга, ил тод явагддаг гэж бодож байна?

Мэдэхгүй.

Төслийн сонгон шалгаруулалтад оролцоход шаардлагатай баримт, материал, тавигдах шалгуур хэр зэрэг практикт нийцсэн гэж үзэж байна?

Би яг өөрөө төслөө өгч байгаагүй учир мэдэхгүй байна. Ер нь ганц ЖДҮ ч биш бүх төслүүд ойролцоо л юм шаарддаг.

Нэг удаа олгох зээлийн дээд хэмжээ таны бизнест хангалттай хүрэлцээтэй байна уу? (§11.6)

Дээд хэмжээ хэд байдгийг би мэдэхгүй. Миний авч байсан бага зээл хүрэлцээгүй бага зэрэг дэм болсон. Хүний амьдралд огцом эргэлт болохоор дэмжлэг болоогүй.

Сонгон шалгаруулалтад төслийн саналаа мэдүүлэхэд хүндрэл, бэрхшээл тулгардаг уу? Тийм бол ямар?

Санал өгч байгаагүй.

Хөнгөлөлттэй зээл олгохгүй дараах нөхцөлүүдээс аль нь жижиг дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдэд санхүүгийн дэмжлэг авахад хамгийн их хүндрэл учруулдаг вэ? (§11.11)

1. Сангаас авсан зээлийн үлдэгдэлтэй;

2. Зээлийн мэдээллийн санд муу зээлийн түүхтэй;
3. Сангаас авсан зээлийг зориулалтын бусаар ашигласан нь тогтоогдсон;
4. Шүүхийн шийдвэрээр бусдад төлөх өртэй;
5. Төсөл хүлээн авах сүүлийн өдрийн байдлаар нийгмийн даатгал, татварын байгууллагад өртэй.

Мэдэхгүй. Гэхдээ зориулаагүй зүйлд ашигласан гэж асуудал үүсдэг гэж сонссон. Бид материал авахад НӨАТ-ын баримт шаардах нь асуудал болдог. Нарантуул, хувь хүнээс авахад баримт байхгүй байдаг.

Та жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдэд төрөөс татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн дэмжлэг үзүүлдэг талаар хэр мэдээлэлтэй байдаг вэ? (§8.1.3)

Мэдээлэлгүй. Тайлан гаргах хэцүү санагддаг.

Та татварын хөнгөлөлт, чөлөөлөлтөд хамрагддаг уу? Хэрвээ тийм бол ямар хэлбэрийн татварын хөнгөлөлт, чөлөөлөлтөд хамрагддаг вэ? Энэхүү хөнгөлөлт танд бодит дэмжлэг болж чаддаг уу?

Ер нь мэднэ. Оюутны сургалтын төлбөр, орон сууцны хөнгөлөлтөөр хамрагдаж байсан.

Төрөөс экспортыг нэмэгдүүлэх, импортыг орлох өрсөлдөх чадвартай бүтээгдэхүүний үйлдвэрлэл, үйлчилгээг дэмждэг талаар мэдэх үү? Хэрвээ тийм бол ийм төрлийн дэмжлэгт хамрагдаж байсан уу? Дэмжлэгт хамрагдахад хүндрэл, бэрхшээл гарч байсан уу? Тийм бол ямар? ; (§8.1.4)

Ер нь мэднэ. Гэхдээ бид хэрэглэж байгаа бүх юмаа Хятадаас авдаг, Монголоос авах юм байдаггүй.

Та төрөөс бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний борлуулалтад төрийн худалдан авалтаар дэмжлэг үзүүлдэг талаар мэдэх үү? Та төрийн худалдан авах ажиллагаанд оролцож байсан уу? Хэрвээ тийм бол энэ дэмжлэгийг авч чадсан уу? (§8.1.5)

Ковидын үеэр манай үйлдвэрээс эрүүд мэндийн газар, эмнэлэг хөнжил авч байсан.

Та жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ дэмжих төрийн байгууллагуудаас бизнесийн зөвлөгөө авч байсан уу? Хэрвээ тийм бол та өөрт хэрэгцээтэй зөвлөгөө, мэдээллийг авч чадсан уу? Та хэрхэн үнэлэх вэ? (§8.1.6)

Зөвлөгөө нь бодит дэмжлэг болсон гэж боддог. Миний хөнжлийг авахад хэрэг болсон.

Та шинэ бүтээгдэхүүн хөгжүүлэх эсхүл бүтээмжийг нэмэгдүүлэх судалгаа зэрэгт төрөөс дэмжлэг үзүүлдэг талаар мэдэх үү? Тийм бол дэмжлэг авахаар оролдож байсан уу? Ямар хүндрэл, бэрхшээл гарч байсан бэ? (§8.1.7)

Сайн мэдэхгүй. Брэндийг цөөвтөр хүн л хийдэг байх.

Төрөөс техник, технологийн дэвшлийг дамжуулах, нутагшуулах, шинжлэх ухаан, технологийн судалгааны үр дүнг үйлдвэрлэлд нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлдэг талаар та хэр сайн мэдэх вэ? (§8.1.8)

Мэдэхгүй. Зарим тохиолдолд төрөөс өгсөн тоног төхөөрөмжийг ашиглахад хэцүү, хэрэггүй төхөөрөмж авсан байдаг. Төр оролцоод ирэхээрээ бүтэлгүй байдаг.

Та кластерын талаар хэр сайн ойлголттой вэ? (§8.1.9) Танай компани үйл ажиллагаагаа эрхлэхдээ кластераар ажилладаг уу? Ийм хэлбэрээр ажиллахад төрөөс дэмжлэг авч байсан уу?

Ойлголттой. Үгүй.

Танай бүтээгдэхүүн үйлчилгээ гадаад, дотоод зах зээлд гарахдаа төрөөс ямар нэгэн дэмжлэг авч байсан уу? (§8.1.10) (жишээ нь дотоодын болон олон улсын үзэсгэлэн худалдаа зохион байгуулах, оролцох зэрэг)

Үгүй. Зарим салбарт л дэмжлэг ярьдаг, манай салбарт байхгүй.

Хэрвээ авсан бол ямар? Энэ дэмжлэг нь гадаад, дотоод зах зээлд гарахад бодитой дэмжлэг болж чадсан уу?

Үгүй.

Таны бодлоор Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хууль хэр зэрэг хэрэгжиж байна? Яагаад?

Сайн мэдэхгүй байна. Том зээл авбал үр дүнтэй байх, миний ажилд мэдрэгддэггүй.

Нэмж хэлэх санал

Зээл эзнээ олвол зүгээр. Ихэнхдээ эрх бүхий хүмүүс авч, жижиг хүмүүст бага багаар өгдөг. Гэхдээ бага багаар дэмжиж байгаа нь өмнөх үеэс дээрдсэн. Миний салбар жижиг болохоор дэмжлэг бага, мэдрэгддэггүй.

---oOo---